



**СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТой
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТАСЛАН ЗОГСООХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ
ДЭЛХИЙН УДИРДАМЖ**





СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТАСЛАН ЗОГСООХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

ДЭЛХИЙН УДИРДАМЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2025 он

Эмхэтгэсэн Я.Мөнхчимэг

Техник редактор Б.Батчимэг

Хавтасны гэрэл зургийг Д.Давааням, Б.Инжинаш

*Энэхүү удирдамжийг Боловсролын төлөө чанга дуугарцгаая!
төслийн санхүүжилтээр хэвлэв.*

EDUCATION OUTLOUD
advocacy & social accountability



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ОЙЛГОХ НЬ	6
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	9
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОЙМ	11
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮНДСЭН ШАЛТГААН	13
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ	14
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮР ДАГАВАР ..	17
ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, АМЛАЛТУУД	19
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ЧИГЛЭЛЭЭРХ ХӨТӨЛБӨРТ БАРИМТЛАХ ЗАРЧМУУД	21
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЗОГСООХ ЦОГЦ ХАРИУ ҮЙЛДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХАМ	24
2.1 МАНЛАЙЛАЛ: ХУУЛЬ, БОДЛОГЫН ОРЧИН, БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ	24
2.2 АЮУЛГҮЙ, ДЭМЖЛЭГИЙН ТОГТОЛЦОО БҮХИЙ СУРГУУЛИЙН ОРЧИН	28
2.3 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ БОЛОН СУРАХУЙ	36
2.4 ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ: СУРГУУЛИЙН ГАДААД, ДОТООД ОРЧИН	48
2.5 ТҮНШЛЭЛ: ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ, УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙХ	53
2.6 БАРИМТ, НОТОЛГОО: СХЖСХ-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ТОГТМОЛ ҮНЭЛГЭЭ	63
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ АРГА ХЭМЖЭЭ	74
ХАВСРАЛТ 1	88
ХАВСРАЛТ 2	91

БҮЛЭГ I

**СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ОЙЛГОХ НЬ**


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ОЙЛГОХ НЬ

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл нь сургууль болон түүний эргэн тойронд тохиолдох, жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголтын дүнд үйлдэгдсэн эрх мэдлийн тэгш бус динамикаар хэрэгжсэн бэлгийн, бие махбодын, сэтгэл зүйн хүчирхийллийн үйлдэл, заналхийллийг хэлнэ.

Дэлхийн бүх улс оронд сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудал хурцаар тавигдаж, анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудын нэг болж байна. Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл, тухайлбал, бие махбодын, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэл, дээрэлхэлт бүх улс оронд тохиолдож байна. Үндсэн шалтгаанууд нь жендэр, нийгмийн хэм хэмжээ, орлогын тэгш бус байдал, гадуурхалт, зөрчил зэрэг өргөн хүрээний бүтцийн болон нөхцөл байдлын хүчин зүйлсээс шалтгаалдаг.

Зураг 1. Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд¹



¹ Global Guidance on addressing school-related gender based violence (2016)

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл (СХЖСХ) нь дэлхийн бүхий л улс оронд тохиолддог бөгөөд сая сая хүүхэд залуус, гэр бүл, нийгэмд нөлөөлж байдаг үзэгдэл юм. Үүнийг сургууль болон түүний орчинд гардаг, жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголтын улмаас үүссэн, эрх мэдлийн тэгш бус байдлаар дэмжигдсэн бэлгийн, бие махбодын болон сэтгэлзүйн хүчирхийлэл, заналхийлэл хэмээн өргөн хүрээнд тодорхойлж болно. Энэ төрлийн хүчирхийлэл нь соёлын олон янзат байдал, газарзүйн болон эдийн засаг, нийгэм хамт олны ялгааг үл харгалзан нийгэм, хамт олны дунд өргөн тархсан байдаг.

СХЖСХ нь нарийн төвөгтэй, олон талтай асуудал бөгөөд үүнд бие махбодын, бэлгийн болон/эсвэл сэтгэлзүйн хүчирхийллийн янз бүрийн илрэлүүд багтдаг. Үүнд: үгэн хүчирхийлэл, доромжлол, дээрэлхэлт, бэлгийн хүчирхийлэл, дарамт, албадлага, халдлага, хүчин зэрэг. Эдгээр өөр өөр хэлбэрийн хүчирхийлэл өөр хоорондоо давхцаж, бие биенээ улам бүр нэмэгдүүлдэг (Зураг 1).

СХЖСХ нь сургуулийн орчинд гардаг хүчирхийллийн өргөн тархсан хэлбэр бөгөөд жендэр нь хүчирхийллийн олон хэлбэрийн суурь хүчин зүйл болдог тул хүчирхийллийг жендэрийн өнцгөөр харах нь урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг боловсруулахад тус дөхөм болно.

Залуус жендэр идентити, бэлгийн чиг баримжаа, улс орны соёлын болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан СХЖСХ-ийн туршлага нь өөр өөр байдлаар мэдэрдэг. Жишээлбэл, охид ихэвчлэн сэтгэлзүйн болон цахим дээрэлхэлт, бэлгийн дарамт хүчирхийлэлд өртдөг бол хөвгүүд бие махбодын хүчирхийлэл, бие махбод сэтгэлзүйн шийтгэлд илүүтэй өртдөг². Мөн ЛГБТИК³ сурагчдын ихэнх нь өөрсдийн бэлгийн чиг баримжаа эсвэл жендэрийн илэрхийллээс болж дээрэлхэлт, хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлсэн судалгаанууд нэмэгдсээр байна⁴.

Хүүхдүүд СХЖСХ-ийн хохирогч, эсвэл хүчирхийлэгч, гэрч аль нь ч байж болно. Сургуулийн орчин дахь насны ялгаа, эрх мэдлийн харилцаанаас үүдэн, насанд хүрэгчид ч мөн хүчирхийлэгч эсвэл зарим тохиолдолд хохирогч болох магадлалтай байдаг.

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) зөвхөн сургуулийн орчинд төдийгүй, сургуульдаа явах болон буцах замд ч гарч болзошгүй. Мөн цахим орчин, имэйл, гар утсаар дамжуулан цахим дарамт, дээрэлхэлт, троллинг⁵, грүүминг⁶ гэх мэт шинэ хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгдэх боломжтой. ЖСХ нь онлайн чат өрөөнүүд гэх мэт шинэ орчин болон уламжлалт сургуулийн орчны хүчирхийлэлтэй давхцаж, харилцан бие биенээ нөхцөлдүүлэхийн зэрэгцээ улам эрчимжиж байгааг анхаарууштай.

СХЖСХ нь хүүхдийн үндсэн хүний эрхийг зөрчдөг бөгөөд энэ нь жендэрийн ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр. Хүүхэд бүх төрлийн хүчирхийллээс, тэр дундаа сургуулийн орчин дахь хүчирхийллээс

2 Pinheiro, 2006; UNESCO/UNGEI, 2015; UNICEF, 2011

3 ЛГБТИК + ЛГБТИК гэдэг нь бэлгийн цөөнхийг хэлэх олон улсын хэвшмэл нэр томъёоны товчлол юм. “Л” гэдэг нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэйчүүд буюу лесбиан, “Г” нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрэгтэйчүүд буюу гей, “Б” нь аль аль хүйсийн хүмүүст чиглэсэн бэлгийн чиг баримжаатай бисексуал хүмүүс бол “Т” нь өөрийн хүйсийг төрсөн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрч, мэдэрч буйгаараа хүйсээ илэрхийлж амьдардаг транс хүмүүсийг хэлдэг. “И” нь аль аль хүйсийн анхдагч болон хоёрдогч бэлгийн шинж чанарыг буюу хромосом, гонад болон нөхөн үржихүйн эрхтний хувьд эр, эм аль хүйст хамаарахыг нь шууд хэлэх боломжгүй хүмүүсийг интерсекс гэнэ. “К” нь бэлгийн чиг баримжаа болоод хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх хүмүүсийг нийтэд нь ЛГБТИ эсвэл Күйр гэдэг. Түүхийн хувьд энэхүү үг нь нэлээд сөрөг утга агуулдаг байсан ч энэ үгийг ЛГБТИ хүмүүс өөрийн болгож авч чадсан. Хэдийн тийм ч бүх ЛГБТИ хүмүүс энэ үгийг өөртөө хамаатуулан ашигладаггүй. Ихэвчлэн энэ нэр томъёог хүйс болон бэлгийн чиг баримжааг хоёрхон туйлт хэмээн үзэхийн эсрэг байдаг ЛГБТИ хүмүүс хэрэглэдэг. (ЛГБТ төв ТББ-аас “Бэлгийн цөөнхийн тухай түгээмэл асуугддаг асуултууд” гарын авлагыг авах боломжтой)

4 Plan/ICRW, 2015; UNESCO, 2012a; UNESCO et al, 2014

5 Trolling – Хэн нэгэн бусдыг зориудаар бухимдуулж, уурлуулахын тулд доромж үгийг цахим орчинд сэтгэгдэл бичих

6 Grooming – “Цахимаар урхидах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг ойлгоно. (Хүүхэд хамгааллын хууль, 25-р зүйл)

хамгаалагдах эрхтэй. СХЖСХ-г мэдрэх нь хүүхдийн сайн сайхан байдал, бие махбодын болон сэтгэлзүйн эрүүл мэндэд ноцтой хор учруулж, тэдний танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн хөгжилд хохирол учруулах эрсдэлтэй.

Тухайлбал, жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүүхэд, залуусын сурлагын амжилтад сөргөөр нөлөөлж, тэдний боловсрол эзэмшихэд шууд болон шууд бусаар саад болж байдаг. Энэ нь боловсролын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд томоохон бэрхшээл учруулж буй бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ын тодорхой зорилтуудтай уялддаг. Үүнд:

- Бүхий л орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах болон бүх төрлийн хүчирхийллийг устгах (Зорилт 16.2);
- Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жендэрийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүчирхийллээс ангид, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах (Зорилт 4.а);
- Жендэрийн тэгш байдлыг хангаж, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах (Зорилт 5)

Боловсрол нь нийгэмшихүйн гол тогтолцоо бөгөөд хүүхэд, өсвөр үе, залуусын нийгэм – сэтгэлзүйн болон сэтгэл хөдлөлийн хөгжилд чухал үүрэгтэй. Тиймээс боловсрол нь хувь хүний зан үйл болон хүчирхийлэл, жендэрийн эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтын талаарх өргөн хүрээний нийгмийн хандлагыг хувирган өөрчлөх чухал ХЭРЭГСЭЛ билээ.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

“Боловсрол нь дэлхийн хэмжээнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх гол түлхүүр юм. Боловсрол нь бидний өөрчлөлтөд дасан зохицох, амьдарч буй дэлхийгээ өөрчлөх хүчин чармайлтын үндэс суурь”.

UNESCO 2015a

ЖЕНДЭРИЙН БОЛОН НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ, ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТУУД, ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ СОРИЛТ БА БОЛОВСРОЛЫН ЗОРИЛГО

Боловсрол бол хүний үндсэн эрх төдийгүй бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх хамгийн чухал эх сурвалж юм. Боловсрол нь чадавхын эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүд, томчуудад ядуурлаас өөрсдийгөө гаргах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл нь болдог. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүнд, хортой хөдөлмөр, бэлгийн мөлжлөгөөс хүүхдүүдийг хамгаалах болон хүний эрх, ардчиллыг хөхүүлэн дэмжих, хүрээлэн буй орчноо хамгаалах, хүн амын өсөлтийг хянахад нэн чухал үүрэгтэй. Боловсрол нь төрийн санхүүгийн хөрөнгө оруулалтуудаас хийж болох хамгийн сайн хөрөнгө оруулалтын нэг хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Гэвч боловсролын ач холбогдол нь зөвхөн практик зүйл биш. Чөлөөтэй, өргөн хүрээтэй сэтгэх чадвар бүхий сайн боловсрол эзэмшсэн, идэвхтэй санаа бодолтой хүн л хүн болж төрсний гавьяа, аз жаргалыг мэдэрдэг. Харамсалтай нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх мэдлэг, хандлага, ойлголт дутагдсанаар ялгаварлан гадуурхалт бий болж үүнээс үүдэлтэй сурч боловсрох эрхээ эдлэхэд саад тотгорууд учирч хүүхдийг амжилттай суралцах, өөртөө итгэлтэй хувь хүн болж төлөвшихөд нөлөөлж цаашлаад сургууль завсардахад хүргэдэг. Боловсрол эвслийн хийсэн судалгаагаар⁷ жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийхний дээрлэхэлт нь сургуулиас гарах үндсэн шалтгаануудын нэг болох нь батлагдсан. Боловсролын зорилгыг Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Олон Улсын Пактад тодорхойлсноор:

- хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, авьяас билэг, оюуны болон биеийн чадавхыг бүрэн төгс хөгжүүлэх;
- хүний эрх, үндсэн эрх чөлөө болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмыг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх;
- эцэг эх, соёл, хэл, үнэт зүйлс, амьдарч байгаа улсынхаа болон төрсөн улс орныхоо үндэсний үнэт зүйлс болон өөрийнхөөсөө ялгаатай соёл иргэншлийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэн хөгжүүлэх;
- харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, аливаа ард түмэн, угсаатны болон шашны бүлэг, нутгийн уугуул иргэдийг хүндэтгэх үзлийг хүүхдэд төлөвшүүлж чөлөөт нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх;
- байгаль орчныг хайрлан хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх юм.

Тиймээс боловсролын орчин айдас, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх ёстой. Нөгөө талаар Монгол улсын хууль тогтоомжид зааснаар боловсролын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч насанд хүрэгчид нь хүүхдийг дараах үйлдэл, эс үйлдлээс хамгаалах үүрэг хүлээсэн байдаг. Үүнд: аливаа төрлийн хүчирхийлэл, үл хайхрах, дарамт, мөлжлөг, эрсдэлт нөхцөл, гэмт хэрэг, зөрчил, бие махбодын шийтгэл, хорт зуршилд өртөхгүй байх зэрэг багтана. Улмаар “ялгаатай байдал”-ыг хүлээн зөвшөөрөх агуулга нь соёлын, нийгмийн, бие махбодын, эдийн засгийн, улс төрийн болон шашны эх сурвалжтай бөгөөд өөр бусдыг үл хүлцэх нь хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтын гол эх болдог. Үүнээс урьдчилан сэргийлэхэд хүлээцтэй байдал тэр дундаа хүний эрх, эрхэм чанар, ялгаатай байдлыг хүндлэх, зөрчлийг хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэх цогц, ухаалаг арга зүйг нэвтрүүлэх нь

7 “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгаа, 2020 он

боловсролын салбарын эн тэргүүний зорилт байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийг ялгаварладаг тогтолцоо нь хэн бүхнийг хүйс, нас, оршин буй газар, ядуурал, нийгмийн статус, үндэс угсаа, харьяалал, хэл, шашин, шилжин ирсэн эсвэл дүрвэсэн байдал, бэлгийн чиг баримжаа, жендэр, шоронд хоригдсон явдал төдийгүй итгэл үнэмшил мөн хандлагаас нь болж гадуурхаж байдаг⁸. Дээрх агуулгыг ТХЗ-ын 4.7-д “Бүх суралцагчдад тогтвортой хөгжил болон тогтвортой амьдралын хэв маягийн тухай боловсрол, хүний эрх, жендэрийн тэгш эрхийн боловсрол, энх тайвныг эрхэмлэх болон үл хүчирхийлэх соёл, дэлхийн иргэн байх болон соёлын олон янз ялгаатай байдлыг дээдлэх хандлагыг түгээх замаар тогтвортой хөгжлийг бий болгох мэдлэг, ур чадварыг эзэмшүүлсэн байна” хэмээн тодорхойлсон. Харин Боловсролын Ерөнхий хуульд заахдаа боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээ⁹ хэмээн анх удаа тодорхойлжээ.

Боловсрол хүний эрхээс гадна нийгэмд онцгой үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ бол бүх нийтийн хамтын сайн сайхан байдал¹⁰ юм. Энх тайван, хөгжил цэцэглэлтийг дэмжих чадамжтай төдийгүй, сайн засаглалыг төлөвшүүлэхэд ч хувь нэмэр оруулдаг. Олон улсын хамтын нийгэмлэгүүдийн хүлээн зөвшөөрснөөр, боловсрол нь хүүхдүүдийг нийгмээ хувирган өөрчлөх үйл явцад идэвхтэй оролцогч болгоод зогсохгүй, суралцахуйгаар дамжуулан олон талт, олон янзын ертөнцөд хамтдаа оршин тогтнох боломж бий болгох үнэт зүйлс, хандлага, зан төлөвийг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой.

Олон улсын хүний эрхийн конвенци, баримт бичгүүдийн дагуу (цаашид дэлгэрэнгүй авч үзнэ) аюулгүй, чанартай, тэгш хүртээмжтэй боловсрол эзэмших эрх нь боловсролын нийгэм дэх гол үүрэгтэй салшгүй холбоотой. Тиймээс хүүхдийн эрхийг зөрчиж буй үйлдэл болох сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүүхдүүдийн боловсролоос хүртэх ашиг тусыг хязгаарлаж, тэдний хувь хүний болон нийгмийн хөгжилд бүрэн дүүрэн оролцох боломжийг хумьдаг.

Боловсролын мөн чанар, зорилго хийгээд нийгэмд гүйцэтгэх үүргийг өргөн хүрээнд авч үзвэл, сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ нь зөвхөн хяналтын тогтолцоо, бодлого боловсруулж, хариуцлага тооцохоос гадна СХЖСХ-ийн суурь шалтгаанууд руу чиглэсэн хүчин чармайлтаа нэмэх ёстой.

Хувь хүний болон нийгмийн үнэт зүйлс, хандлага, зан төлөвийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг боловсролын байгууллагын хувьд боловсрол нь хүчирхийлэл, ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) үндсэн шалтгаануудыг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь СХЖСХ-ийг шийдвэрлэхэд шаардлагатай тогтолцоо, бодлогыг цогцоор хөгжүүлэхтэй адил чухал ач холбогдолтой юм.

Боловсролын тогтолцоог олон салбарт үр дүнтэй ашиглаж, өсвөр үе, залуусыг нийгмийн хэм хэмжээ, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн үүрэг, эрэгтэйлэг, эмэгтэйлэг байдлын талаарх өрөөсгөл ойлголтууд нь тэдний амьдрал, дотно харилцаанд хэрхэн нөлөөлж болох талаар шүүмжлэлт эргэцүүлэлд татан оролцуулж болно. Боловсролоор дамжуулан өсвөр үе, залуучуудад эрүүл дотно харилцаа, аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай амьдрах ухааны ур чадвар, эерэг хандлагыг эзэмшүүлэх боломжтой. Энэ хүрээнд жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр, дидактик арга зүйг бэхжүүлэхийн зэрэгцээ нөхөн үржихүй болон бэлгийн цогц боловсрол олгох нь нэн чухал.

Мөн боловсролын салбар нь энх тайван, тэгш байдал, хүлцэхүй хийгээд нийгмийн эв зөийг дэмжих замаар хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг. Олон янзат байдлыг хүлээн зөвшөөрөх эерэг арга барилуудыг энх тайвны боловсрол, хүлцэхүйн боловсрол болон иргэний боловсрол зэргээр дамжуулан хүлээцтэй байдал, энх тайван, олон янзат байдлыг хүндэтгэх үзэл санааг түгээхэд чухал ач холбогдолтой.

8 “Боловсролын хяналт мониторингийн дэлхийн тайлан 2020”, ЮНЕСКО

9 3.1.24. “ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

10 UNESCO, 2015a

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОЙМ

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн (СХЖСХ) цар хүрээг бүрэн тодорхойлсон баримт нотолгоо хангалтгүй байгаа ч олон улсын байгууллагууд, Засгийн газрууд, судлаачид энэ талаар мэдээлэл цуглуулж, асуудлын ноцтой байдлыг харуулсан баримтууд хангалттай байна.

НҮБ-ын «Hidden in Plain Sight» (2014) тайланд дэлхийн хамгийн том хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээлэл багтсан бөгөөд сургуулийн орчинд тохиолдож буй бие махбодын, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл ноцтой түвшинд буйг харуулсан. Судалгаанаас харахад дараах хүчирхийллийн хэлбэрүүд түгээмэл байна.

Дээрэлхэлт

- Сургуулийн орчинд хамгийн өргөн тархсан хүчирхийллийн хэлбэр.
- Дэлхий даяар **13-15 насны сурагчдын гуравны нэгээс дээш хувь** нь дээрэлхүүлж байсан туршлагатай.¹¹
- Монгол улсад 2023 онд хийгдсэн “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйл” үндэсний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн **4 хүүхэд тутмын 1** нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчин (сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олгоор цугладаг газар) аюулгүй байдал алдагдсан, **3 хүүхэд тутмын 1** нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэжээ.

Бэлгийн хүчирхийлэл

- Дэлхий даяар **120 сая охид** (10 охин тутмын 1) 20 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртдөг.
- 2017-2020 оны хооронд Монгол улс даяар **676 хүүхэд** бэлгийн халдлага, дайралтад өртсөн гэж мэдээлсэн. Зөвхөн 2020 онд гэхэд **160 хүүхэд** (ихэнх нь охид) бэлгийн халдлагад өртсөн¹².

Бие махбодын шийтгэл

- Зарим улс оронд сурагчдын **80-аас дээш хувь** нь сургуулийн орчинд бие махбодын шийтгэл амсдаг¹³.
- Дэлхий даяарх хүүхдийн **тал хувь** нь бие махбодын шийтгэлийг хориглосон хуулийн хамгаалалтгүй улс оронд амьдарч байна.
- Монгол улс хуулиар хүүхдийн эсрэг биемахбодын шийтгэлийг хориглосон хэдий ч хүүхэд гэр бүл болон сургуулийн орчинд биемахбодын шийтгэлээс ангид байж чадахгүй байна.

Маргинал бүлгийн хүүхдүүдийн эрсдэл өндөр

- Уганда дахь бага ангийн сурагчдын дунд хийсэн судалгаагаар **11-14 насны хөгжлийн бэрхшээлтэй охидын 24 хувь** нь сургуулийн орчинд бэлгийн хүчирхийлэлд өртсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлгүй охидын (12%) үзүүлэлтээс **хоёр дахин их**¹⁴ байна.
- Сургуулийн орчинд хөгждийн бэрхшээлтэй хүүхдийн жендэрийн ялгаатай хэрэгцээг хангасан орчин хангалтгүй, багш нарын зүгээс жендэрийн болон хүний эрхийн мэдрэмжгүй үйлдэл гаргаж сурагчийг ичээх, сэтгэл санааны хүчирхийлэлд өртүүлэх тохиолдолууд Боловсрол эвсэлд мэдээлэгдсээр байна.

¹¹ Global Guidance on addressing school-related gender based violence (2016) UNGEI

¹² Монгол улс: Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ, 2024 оны 6 сар

¹³ Greene et al., 2013

¹⁴ Devries et al., 2014

• **Үзэн ядалтаас үүдэлтэй хүчирхийлэл**

- ЮНЕСКО-ын (2012а, 2014) судалгаагаар Чили, Мексик, Перу дахь ЛГБТИ хүүхдүүдийн **60-аас дээш хувь** нь сургуулийн орчинд дээрэлхүүлдэг гэж мэдээлсэн.
- Их Британид дунд сургуулийн сурагчдын **90-ээс дээш хувь** үзэн ядалтаас үүдэлтэй (гомофобик) дээрэлхэлт байгааг онцолсон.
- Норвегид ЛГБ сурагчдын **15-48 хувь нь** дээрэлхүүлж байсан бол энэ үзүүлэлт гетеросексуал сурагчдын дунд ердөө **7 хувь** байжээ¹⁵.
- Монгол улсад “багш нар транс сурагчдын эсрэг ялгаварлан гадуурхах хандлагатайн дээр үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох бус өөгшүүлэн дэмжих” хандлага ажиглагджээ. Тухайлбал, багш нар транс сурагчдыг үг хэлээр доромжлох, тодорхой хэмжээнд бие махбодын хүчирхийлэл үзүүлэх, цаашлаад бэлгийн дарамт үзүүлэх тохиолдлууд илэрсэн. Судалгаа¹⁶ны дүгнэлтэд “Хэдийгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны тухай сэдэв 9 дүгээр ангийн эрүүл мэндийн боловсролын хичээлийн хөтөлбөрт багтсан боловч багш нар ихэвчлэн энэ сэдвийг алгасах, заасан ч заах аргазүйн хувьд зарим талаар сөрөг, ялгаварлан гадуурхах хандлагатай байсаар байна” хэмээн онцолжээ.

• **Цахим дээрэлхэлт**

- АНУ-ын 20.426 ахлах сургуулийн сурагчдын дунд хийсэн судалгаагаар цахим дээрэлхэлт дээрэлхүүлсэн сурагчдын 60 хувь нь сургуулийн орчинд ч мөн дээрэлхүүлж байсан гэж мэдээлсэн. Мөн тус судалгаагаар охид хөвгүүдээс илүүтэйгээр цахим дээрэлхэлтэд өртсөн тухайгаа мэдээлэх магадлал өндөр байсан¹⁷.
- Олон улсын “Сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдэд туслах төв”-өөс гаргасан мэдээллээр Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийг бэлгийн хүчирхийлэл мөлжлөгт ашигласан байж болзошгүй зураг, дүрс бичлэг 2020 онд 10.757 бүртгэгдэж байсан бол 2021 онд 21.656 болж, харин 2023 онд 80203 болж, гурван жилийн дотор 3 дахин өсжээ¹⁸.
- Монгол улсад цахим орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар хийсэн судалгаа¹⁹нд оролцсон 1699 хүүхдийн 16.4 хувь (280) нь цахим гэмт халдлагад өртөж байсан гэжээ. Цахим гэмт хэрэгт өртөж байсан гэх эдгээр хүүхдүүдийн 33.8 хувь нь мөнгө эд зүйлсээ залилуулсан, 19.0 хувь нь нууц үг хувийн мэдээллээ алдсан, 15.7 хувь нь зодуулж дээрэмдүүлсэн, 12.8 хувь нь садар самуунтай холбоотой гэмт хэрэгт өртөж байсан, 10.2 хувь нь гүтгүүлж, доромжлуулсан, 8.5 хувь нь дарамтад орсон гэж хариулжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁵ UNESCO, 2016

¹⁶ “Монголын сургуульд транс сурагч байх нь” чанарын судалгааны тайлан, 2023 он, Боловсрол эвсэл, ЛГБТ төв

¹⁷ Schneider et al., 2012

¹⁸ “Хөөрхөн зүрх” ТББ-аас авсан мэдээлэл, 2025 он.

¹⁹ Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгааны тайлан, НҮБ-ын Хүүхдийн Сан. УБ. 2021 он

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮНДСЭН ШАЛТГААН

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл бүх улс, бүс нутаг, гэр бүлийн орчинд гардаг бөгөөд үүний үндсэн шалтгаан нь ганцхан соёл, уламжлал, тогтолцооноос хамаардаггүй. Харин жендэрийн хэвшмэл ойлголтууд болон эрх мэдлийн хэлбэрүүдийг бий болгож буй өргөн хүрээний **нийгмийн бүтцийн асуудлууд, нийгмийн хэм хэмжээнд гүн гүнзгий шингэсэн итгэл үнэмшил, зан үйлүүд** нь гол хүчин зүйл болдог. Үүнд:

- **Жендэрээр ялгаварлан гадуурхсан хэм хэмжээ** Ихэнх соёлд патриархын дор эрэгтэйчүүдийн ноёлох байдлыг хадгалах, эмэгтэйчүүдийг тэдний эрхшээлд дуулгавартай байхыг шаардах үзэл санаа ямар нэгэн хэлбэрээр байдаг. Ноёрхогч жендэрийн хэм хэмжээнд нийцэхийг шаардах нийгмийн дарамт шахалт өндөр байдаг. ЛГБТИК+ хүмүүс, эсвэл “зүй зохистой” зан үйлд сураагүй залуус, эмэгтэйчүүд дээрх хэм хэмжээнд нийцэхгүй бол хүчирхийллээр шийтгэгдэх эрсдэлтэй.
- **Нийгмийн хэм хэмжээ** Энэхүү эрх мэдлийн хэлбэр нь ихэвчлэн **насанд хүрсэн болон эрэгтэй хүнд төвлөрдөг** гэж үздэг бөгөөд заах, хүмүүжүүлэх, сахилга бат тогтоох, хянах эрхийг зөвшөөрөхөөс гадна хүчирхийллийг ч зүй ёсны хэмээн хүлээн зөвшөөрдөг. Боловсролын орчинд эрэгтэй, эмэгтэй багш болон эцэг эх, насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийг шийтгэх зорилгоор бие махбодод халдах, хүчирхийлэл үйлдэхийг зөвтгөх хандлагыг дэмждэг.

• Бүтцийн болон нийгмийн томоохон нөхцөл байдал

- Зөрчил мөргөлдөөн, орлогын тэгш бус байдал, нийгмээс гадуурхагдах байдал, боловсролын тогтолцооны сул байдал зэрэг өргөн хүрээний хүчин зүйлс нь хүчирхийллийн соёлыг өдөөх, дэмжих суурь нөхцөл болдог.
- Цахим ертөнцийн хил хязгааргүй байдал нь цахим дээрэлхэлт, онлайн залилан, троллинг зэрэг жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүдийг үүсгэдэг.
- Цахим хүчирхийлэл нь улс орны хууль, хяналтын тогтолцоонд баригдахгүйгээр өрнөх боломжтой цаг үе, нөхцөлд байна.

Боловсролын тогтолцоо болон сургуулиуд эдгээр нийгмийн болон бүтцийн өргөн хүрээтэй орчны дунд үйл ажиллагаа явуулдаг тул зарим тохиолдолд хүүхдийг хамгаалах бус харин ч хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй орчин болж хувирдаг. Учир нь боловсролын тогтолцоо нь хүрээлэн буй нийгэм, иргэд олон нийт, гэр бүлүүдийн ялгаатай соёл, хэм хэмжээ, эрх мэдлийн тэгш бус динамикийг хуулбарлаж, улам бэхжүүлж, хүүхдийг эрсдэлд өртүүлэх бичил орчинг дахин бүтээдэг.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд **бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, багш нар, эцэг эх асран хамгаалагчид, сурагчид, орон нутгийн иргэд, бүлгүүд бүхий л хоршин ажиллах шаардлагатай.**

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ

Сургуулийн орчинтой холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдэлийг нэмэгдүүлэх олон хүчин зүйлс байдаг. Эдгээр нь хувь хүн, гэр бүл, сургууль, олон нийт, орон нутаг, нийгмийн (төрийн болон инстүүцийн түвшинд) ялгаатай түвшинд харилцан адилгүй үйлчилнэ.

Эдгээр нь тухайн нөхцөл байдал, орчин, орон нутгаас хамаарч өөр өөр байдаг тул тухайн улс орон, орон нутгийн түвшинд нарийвчилсан судалгаа хийх зайлшгүй шаардлагатай.

Зураг 2. Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйл²⁰


Хувь хүн (Биологи, хувийн түүх, хүн амзүйн шинж чанар)	Гэр бүл (Гэр бүл болон ойр дотно харилцаа)	Сургууль (Сургуулийн түвшний хүчин зүйлс)	Орон нутаг (Нийгмийн хэм хэмжээ, орон нутгийн түвшний хүчин зүйлс)	Нийгэм (Хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх уур амьсгалыг бүрдүүлэгч нийгмийн хүчин зүйлс)
- Хувь хүний болон хамтын эрхийн талаарх ойлголт дутмаг - Хүйс, нас, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл - Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэл - Боловсролын түвшин доогуур - Эдийн засгийн статус доогуур - Газарзүйн байршил - Төрсний бүртгэлгүй - ХДХВ, ДОХ-ын халдвартай - Хүчирхийлэлд өртөж байсан туршлага (гэрч, хохирогч, гэмт хэрэгтэн гэх мэт)	- Гэр бүлд хүүхдийг хүйсээр нь ялгавартай үнэлэх үнэлэмж - Эцэг эхийн анхаарал, халамж муу байх - Гэр бүлийн орчин нь архидалт, мансууруулах бодисны хэрэглээ, хамааралтай байх - Гэр бүл дэх үе дамжсан жендэрт суурилсан хүчирхийллийг (бэлгийн, бие махбодын, сэтгэлзүйн) хүлцэн тэвчих байдал - Хүүхэд, өсвөр үеийхний талаарх болон СХЖСХ-ийн мэдлэг дутмаг байдал	- СХЖСХ-ийн мэдлэг ойлголт дутмаг байх - Сургууль СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэх чадавх сул байх - Үр дүнтэй хяналтын тогтолцоо дутмаг, багш\ажилтнууд хүчирхийлэл үйлдсэн ч шийтгэл хүлээхгүй байдал их - Боловсрол эзэмшиж буй орчин нь аюулгүй, ээлтэй, орон зай дутмаг - Багшлахуй суралцахуйд сахилга бат тогтоож буй арга зүй нь хүчирхийллийг бататгах стратегитай байх	- СХЖСХ-ийг мэдээлэх, хариу арга хэмжээ авах тохирсон, хүртээмжтэй хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний дутмаг байдал - Орон нутаг, хүй олны дундах соёл нь сэтгэл санаа, бэлгийн, биемахбодын хүчирхийллийг хүлцэн тэвчих байдал - Патриархат үнэт зүйлийг хадгалах зорилгоор жендэрийн тэгш бус байдлыг дэмжих	- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, түүн дотроо СХЖСХ-ийг хориглосон хууль тогтоомж дутмаг, эсвэл хэрэгжилт муу - СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, таслан зогсоох чиглэлээр цогц ажиллах бодлогын тогтолцоо сул - СХЖСХ-г таслан зогсоох чиглэлээр салбар хоорондын уялдаа муу - Багш бэлтгэх хөтөлбөрт СХЖСХ тусаагүй эсвэл сургалт тогтмол, тогтвортой биш - Зөрчил мөргөлдөөнтэй, үл хамгаалагдсан байдал

20 Global Guidance on addressing school-related gender based violence (2016), p-28

		○ Сургалтын хөтөлбөр, багшлахуйгаар дамжуулан үе тэнгийхэнтэйгээ эрүүл харилцаа холбоо тогтоох хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үндсэн мэдлэг, ойлголт, амьдрах ухаан олгодоггүй арга зүйтэй байх	○ СХЖСХ-г мэдээлэхийг хориглодог нийгмийн хэм хэмжээ оршдог. Эсвэл бүр тодорхой шийтгэл ил болон далд байдаг. ○ Охидын боловсрол эзэмших эрхийг улс төржүүлж эсэргүүцдэг соёлтой байх ○ СХЖСХ шийдвэрлэхэд гэрч хохирогч хамгааллын тогтолцоо сул.	○ Хуулийн хариуцлага хүлээхгүй, үл шийтгэл хүлээдэггүй соёлтой байх ○ Тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын түвшин өндөр ○ Засаглалын хувьд авлига, хээл хахууль өндөр байх
--	--	--	--	--

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хувь хүн, ойрын харилцаа, орон нутаг, нийгмийн түвшинд янз бүрийн бэрхшээл авчирдаг олон талт асуудал учраас хэд хэдэн түвшинд нэгэн зэрэг шийдвэрлэх шаардлагатай.

Зураг 3. Хүчирхийллийн төрлүүдэд өртөх эрсдэл насны бүлгээр²¹



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, СХЖСХ-ийг аль алиныг урьдчилан сэргийлэх боломж болон хүчирхийлэл гарах эрсдэл хоёрыг түвшин бүрт зэрэг анхаарахад нийгэм-экологийн загварыг давхар үүрэгтэйгээр ашиглаж болно.

Нийгэм-экологийн загвар²² нь хүүхдийг хамгаалах эсвэл хүчирхийллийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд нийгэм, эдийн засаг болон соёлын хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байдгийг харахад тусалдаг. Эдгээр хүчин зүйлүүд нь хувь хүний түвшинд, гэр бүл зэрэг дотно харилцааны түвшинд, орон нутаг болон инстүүцийн түвшинд, эсвэл нийгэмд бүхэлд нь зэрэг маш олон шатлалд оршин байдаг. Нотолгоогоор дэмжигдсэн, хувь хүн болон гэр бүлд зориулсан аргачлалууд нь эрх зүйн хүрээ, бодлого, эрх мэдлийн хүрээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажилтнууд болон нөөц бололцоо бүхий бүтэц, байгууллагуудыг бэхжүүлэх зэрэг нийгмийн хүрээн дэх асуудлуудыг сайжруулснаар хэрэгжүүлэхэд улам хялбар болдог. Уг шалтгааны улмаас УДИРДАМЖийг хэрэгжүүлэхдээ нийгэм экологийн загвар болон интервенц хэрэгжиж байдаг олон шатлалуудыг харгалзан үзэх нь чухал. СХЖСХ-ийн эрсдэл болон хамгааллын хүчин зүйлүүдийг тогтмол

21 INSPIRE Арга зүйн тойм: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 7 стратеги, х-16

22 INSPIRE Гарын авлага: Долоон стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, ДЭМБ, 2017 он

авч үзэх чухал. Зураг 2-т Эрсдэлт хүчин зүйлсийг авч үзсэн бол Зураг 4-т хамгааллын хүчин зүйлийг харуулав.

Зураг 4. Хамгааллын хүчин зүйл (Нийгэм-экологийн загвараар)²³

Хамгааллын хүчин зүйл - Албан ёсоор зөвшөөрөгдсөн хүүхдийн болон жендэрийн эрх - Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон түүнд хариу үзүүлэх эрх зүйн хүрээг хэрэгжүүлдэг - Жендэрийн тэгш байдал, хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг дээдэлдэг хэм хэмжээ байх - Эдийн засгийн эмзэг байдал болон ялгаварлан гадуурхалттай тэмцдэг бодлогууд	- Хүчирхийллийг олон нийт хүлээн зөвшөөрөхгүй байх - Жендэрийн тэгш байдал хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг дээдэлсэн хэм хэмжээ болон зан үйлийг үлгэрлэх - Хүүхэд залуучуудад зориулсан чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжүүлэх хөтөлбөрүүдтэй байх - Аюулгүй орчин - Орон нутгийн иргэдийн дундах эерэг харилцаа.	- Эдийн засгийн тогтвортой байдал - Эцэг эхийн боловсролын түвшин - Хамаатан садан ах дүүгийн дэмжлэг - Хүмүүжлийн ур чадвар, дасан зохицох - Үе тэнгийнхний хоорондын сайн харилцаа - Өрхөд жендэрийн тэгш байдал байх.	- Өөртөө итгэх, өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр байх - Нийгмийн ур чадвартай байх.
---	--	---	---

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, СХЖСХ-ийг зогсоох чиглэлээр тодорхой арга хэмжээ авна гэдэг нь дараах алхмуудыг шат дараатай хэрэгжүүлэхийг хэлдэг.

Зураг 5. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломж²⁴

Аюулгүй, тогтвортой, өсөн дэвших боломжтой гэр бүлийн орчинг бүрдүүлэх, хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэл бүхий гэр бүлүүдэд дэмжлэг, тулалцаа үзүүлэх;

Бодит өөрчлөлтүүдийг хийх замаар аюултай орчин нөхцлийг өөрчлөх;

Хүчирхийллийн аюулыг багасгах үүднээс олон нийтийн газруудад (тухайлбал сургууль болон хүүхэд залуучууд цугладаг газар) эрсдэлийн хүчин зүйлүүдийг бууруулах;

Хүн хоорондын харилцаа, өрх гэр, сургууль болон ажлын байран дахь жендэрийн тэгш бус харилцааг шийдвэрлэх;

Хүчирхийлэл үйлдэхийг дэмжсэн соёлын хандлага болон уламжлалыг өөрчлөх;

Хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг хориглосон эрх зүйн орчинг баталгаажуулж, хүүхэд залуучуудад архи согтууруулах ундаа, галт зэвсэг зэрэг аюултай зүйлсийг авах боломжийг нь хязгаарлах;

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд чанартай хариу үйлчилгээг хүртээмжтэй хүргэх;

Хүчирхийлэлд нөлөөлдөг соёл, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг халж, баян ядуугийн заагийг багасгаж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, аливаа боломжуудыг тэгш хүртээмжтэй болгох;

Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд хариу үйлдэл үзүүлэх тал дээр тодорхой үүрэг бүхий олон салбарын харилцан уялдааг хангаж ажиллах

²³ Мөн тэнд, х-16

²⁴ INSPIRE Арга зүйн тойм: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 7 стратеги, х-18

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮР ДАГАВАР

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн туршлагатай байх нь хүүхэд, өсвөр үеийхэнд урт хугацааны сэтгэцийн болон биемахбодын сайн сайхан байдал, боловсрол, эрүүл мэндийн байдал, тэр дундаа ХДХВ-ийн халдвар, эрт жирэмслэлт зэрэг өргөн хүрээний үр дагаврыг дагуулдаг. Хүүхэд байхдаа хүчирхийллийн гэрч болох эсвэл хохирогч болох нь ирээдүйд хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх, ашиглах эрсдэлийг дагуулж болно.

Зураг 6. Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн үр дагавар²⁵


Бие махбодын эрүүл мэнд болон эрсдэлт зан үйлийн ◆ Хөхөрсөн, түлэгдэлт, хугарал, шарх, хутгалуулсан зэрэг гэмтэл ◆ Бугуйгаа зүссэн, эсвэл зүсэхээр оролдсон шарх ◆ Хөгжлийн бэрхшээлтэй болох ◆ Бэлгийн болон шээсний замын үрэвслийн шинж тэмдэг ◆ Хүсээгүй жирэмслэлт ◆ БЗХВ, түүний дотор ХДХВ ◆ Хооллох эмгэг ◆ Газ үнэрлэх, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ ◆ Эрсдэлт бэлгийн зан үйл	Сэтгэцийн эрүүл мэндийн ◆ Сэтгэл түгших ◆ Сэтгэлийн дарамт ◆ Уур уцаар, хонзон ◆ Өөртөө итгэлгүй байдал ◆ Амиа хорлох сэдэл, оролдлого, үйлдэл ◆ Өөрийгөө гэмтээх ◆ Ичгүүр ◆ Ой санамжаа алдах
Бусдын эсрэг үйлдэх хүчирхийллийн ◆ Дээрэлхэлт ◆ Давтан хүчирхийлэл ◆ Биедээ зэвсэг авч явах ◆ Хууль, дүрэм журамтай зөрчилдөх ◆ Дотно хамтрагчийн хүчирхийлэл ◆ Бэлгийн дарамт ◆ Хохирогчид үүсэх нөлөө нь үе дамжсан хүчирхийлэл үүсэх нөхцөл	Боловсролын ◆ Анхаарал төвлөрөл дутмагших ◆ Суралцах чадваргүй байх ◆ Дүн буурах ◆ Хичээл таслах ◆ Сургууль завсардах ◆ Сургуулиас гарах

Дээр дурдсан эрүүл мэнд, нийгэм, боловсролын үр дагавраас гадна Пинейро (2006) болон НҮБ-ын Хүүхдийн Сан эдийн засгийн ноцтой үр дагаврыг тодорхойлсон²⁶ байдаг. Тухайлбал, эмнэлэгт очих, эмчид үзүүлэх, эмчилгээ хийлгэх болон бусад эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой шууд зардал, хөдөлмөрийн бүтээмж алдагдах, хөдөлмөрийн чадвар буурах (боловсролд сурлагын амжилт буурах), хөгжлийн бэрхшээлтэй болох, өвчлөл нэмэгдэхтэй зэрэгцээд амьдралын чанар буурах, богино наслах зэрэг шууд бус зардал орно. Улмаар эдийн засгийн үр дагаварт гэмт хэрэг үйлдэгчдийг баривчлах, яллахтай холбоотой эрүүгийн эрх зүйн тогтолцооны зардал, засан хүмүүжүүлэх үйлчилгээтэй холбоотой нийгмийн халамжийн байгууллагуудад гарах зардал, суралцах чадвараа алдахаас үүдэн боловсролын тогтолцоонд гарах зардал, ажил таслах, хөдөлмөрийн бүтээмж багассанаас үүдэлтэй хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарах зардал зэрэг ордог байна.

25 UNICEF, 2024b

26 UNICEF, 2014b

Зураг 7: Хүчирхийллийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд учирч болох үр дагаварууд ²⁷



● Шууд үр дагавар

○ Эрсдэл өндөртэй зан үйлээс болж гардаг шууд бус үр дагавар

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

²⁷ INSPIRE Арга зүйн тойм: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 7 стратеги, х-18 х-108

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, АМЛАЛТУУД

Энд онцолсон хүний эрхийн түүхэн баримт бичгүүд нь сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхэд олон улсын болон бүс нутгийн түвшинд анхаарал хандуулж, улс орны Засгийн газрууд хүчин чармайлт гаргаж буйг илтгэнэ.

1960 он: ЮНЕСКО-гийн Боловсрол дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг конвенц батлагдсан. Энэхүү конвенцид нэгдсэн улс орнууд ялгаварлан гадуурхалтыг хориглох, хүн бүр боловсрол эзэмших эрхтэй байх зарчмыг хүлээн зөвшөөрсөн. Мөн аюулгүй, хүчирхийллээс ангид сургалтын орчин нь чанартай боловсролын чухал хэсэг болохыг конвенцид хүлээн зөвшөөрсөн.

1979 он: Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW) батлагдав (1981 онд хүчин төгөлдөр болсон). Охид, эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчиж, ялгаварлан гадуурхаж буйн нэг хэлбэр хэмээн буруушааж буй жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа тохиолдлоос урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, яллах, шийтгэх талаар гарын үсэг зурсан талууд эерэг арга хэмжээ авах ёстойг баталгаажуулсан.

1989 онд: Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990 онд хүчин төгөлдөр болсон) батлагдлаа. Хүүхдийг эцэг эх болон асран халамжилж буй хүмүүсийн зүгээс үйлдэгдэж буй аливаа хүчирхийлэл, үл хайхрах байдлаас хууль ёсоор хамгаалахыг улс орнуудад үүрэг болгов (19 дүгээр зүйл: Хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах), хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах (3-р зүйл).

2000 он: "Боловсролыг бүх нийтэд" Дакарын үйл ажиллагааны хүрээ – Энэхүү баримт бичиг дэлхийн бүх хүүхдэд сайн чанартай, үнэ төлбөргүй бага боловсролыг олгох хүрээнд батлагдаж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зургаан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан. Дакарын үйл ажиллагааны хүрээ нь хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй сургалтын орчныг бүрдүүлэх зэрэг "Боловсролыг бүх нийтэд!" зорилгод хүрэх гол стратегийг тодорхойлсон.

2006 он: Хүүхдийн эсрэг хүчирхийллийн дэлхийн тайлан (Пинхейро, 2006) хэвлэгдсэн бөгөөд энэ нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн цар хүрээ, түүний үр нөлөөг цогц байдлаар тодорхойлох гэсэн дэлхийн анхны оролдлогын үр дүн юм. Үүнд "Сургууль, боловсролын орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэсэн бүлгийг багтаасан (Бүлэг 4).

2015 оны 3-р сар: Бээжингийн үйл ажиллагааны тунхаглал (Бээжин+20) –НҮБ-ын гишүүн 189 улс нэгдэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоохыг дэлхий нийтээр уриалж, хүчирхийллийн асуудлыг дэлхий дахины 12 чухал асуудлын нэг болгон онцлон тэмдэглэв. Мөн хүчирхийллийг таслан зогсооход чиглэн эмэгтэйчүүдийн боловсрол, сургалтыг онцолсон.

2015 оны 4-р сар: 58 гишүүн орноос бүрдсэн ЮНЕСКО-гийн Гүйцэтгэх зөвлөл бүх хүүхдэд аюулгүй, тэгш хамруулсан, хүртээмжтэй, чанартай сургалтын орчныг дэмжих үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн "Айдасгүй суралцахуй" шийдвэрийг гаргасан. НҮБ-аас гаргасан энэхүү шийдвэр СХЖСХ-ийг хүлээн зөвшөөрч, хүүхдийн эрүүл мэнд, суралцахуй, сургуульд хамрагдах, сургуулиа төгсөхөд үзүүлэх сөрөг үр дагаврыг анх удаа хүлээн зөвшөөрсөн.

2015 оны 5-р сар: Инчеоны үйл ажиллагааны тунхаглал – Дэлхийн боловсролын чуулга уулзалтад оролцогчид (БНСУ-ын Инчеон хотод болсон) Инчоны тунхаглал – “Боловсрол 2030: Бүх нийтэд хүртээмжтэй, тэгш чанартай, насан туршийн боловсролын төлөөх” баримт бичгийг батласан. 8 дугаар зүйлд: “Бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангахад жендэрийн тэгш байдал чухал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Тиймээс бид жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, сургалтын орчныг дэмжих; багш бэлтгэх тогтолцоо, сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах; мөн сургуулиуд дахь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг арилгах чиглэлээр үүрэг хүлээнэ”.

2015 оны 9-р сар: Тогтвортой хөгжлийн зорилтууд – ТХЗ-ын 4-т “Бүх хүнд аюулгүй, хүчирхийлэлгүй, тэгш хамруулсан, ялангуяа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй боловсролын тогтолцоог бий болгох, үр дүнтэй суралцахуйн орчныг бүрдүүлэх” чиглэл багтсан. Мөн 4.7: Дэлхийн иргэний боловсролын агуулгад “... жендэрийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрх мэдэлжилт, хүчирхийллийг таних, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчил шийдвэрлэх”²⁸ агуулгуудыг тусгах зорилт багтсан. Зорилго 16-д “Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнтэй холбоотой нас баралтыг хаа сайгүй бууруулна” зорилтыг багтаасан болно. Зорилго 5-д жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг эрхмэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, олон нийтийн болон хувийн орон зай дахь эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах зэрэг зорилтууд багтсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

28 “ТХЗ 4 дүгээр зорилгын хэрэгжилт” Иргэний нийгмийн тодруулагч тайлан, Боловсрол эвсэл, 2019 он

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ЧИГЛЭЛЭЭРХ ХӨТӨЛБӨРТ БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

Бодлого, оролцооны арга хэмжээг боловсруулахдаа дараах зарчмуудыг үргэлж баримтлах ёстой бөгөөд тэдгээрийг үнэлэх, нягтлахдаа хангалттай хэмжээнд авч үзэж байгаа эсэхээ шалгах шаардлагатай²⁹ байдаг.

- ◇ **Сургууль бүхэлдээ ажиллах цогц арга хандлага** (энэ сэдвийн талаар дэлгэрэнгүйг 2.2-р хэсгээс үзнэ үү) – үр дүнтэй хөтөлбөрүүд нь аль болох сургуулийг бүхэлд буюу сургуулийн хамт олныг бүрэн хамарсан, салбар дундын хамтын ажиллагааны үзэл баримтлалд тулгуурлах бөгөөд урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах хүчин чармайлтыг цогц байдлаар агуулсан байх ёстой.
- ◇ **Нөхцөл байдалд тохирсон байх**– СХЖСХ-ийг бууруулахад чиглэсэн оролцооны бүхий л арга хэмжээ нь тухайн нөхцөл байдалд тохирсон байх ёстой бөгөөд бодит байдлын нарийвчилсан судалгаа, хэрэгцээний шинжилгээнд суурилсан байх шаардлагатай. Боломжтой бол өмнө хэрэгжиж буй хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.
- ◇ **Хүүхэд төвтэй, хүүхдэд хор хөнөөл учруулахгүй хандлага, арга зүйтэй байх**– сургалтын бүхий л үйл ажиллагаа, хөтөлбөр нь хүүхдийн эрх, хэрэгцээ шаардлага, аюулгүй байдал, хамгааллыг эн тэргүүнд тавих ёстойг шаарддаг.
- ◇ **Хөгжлийн онцлогт тохирсон байх** – Сургууль дээрх сургалтын хөтөлбөр болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах сэдэв, агуулгууд нь оролцогч хүүхдүүдийн нас болон сэтгэхүйн онцлог, хөгжлийн түвшинд тохирсон байх ёстой.
- ◇ **Утга учиртай оролцоог хангах** – Хүүхдүүдийг СХЖСХ-ийг шийдвэрлэх арга замыг боловсруулах гол оролцогч гэж хүлээн зөвшөөрөх ёстой.
- ◇ **Тэгш хамруулсан, хүртээмжтэй байх**– Оролцооны арга хэмжээ нь маргинал бүлгүүд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний болон бэлгийн цөөнхийн гээд бусад ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг оролцуулан бүх хүүхдийн оролцоог хангах, тэдний санаа бодлыг сонсох боломжийг бүрдүүлэх шаардлагатай.
- ◇ **Жендэрийн хувирган өөрчлөлт хийхэд чиглэх** – Хөтөлбөр, үйл ажиллагаа нь жендэрийн болон хүний эрхийн дүн шинжилгээнд суурилсан байх ёстой. Жендэрийн олон янзат байдлын хүрээнд авч үзэн, нас болон хүйсийн ялгаатай өгөгдлийг ашиглахыг эрмэлзэх хэрэгтэй. Мөн жендэрийн тэгш эрхийг дэмжих, хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд мэдлэг олгох, ур чадвар, үнэт зүйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэх ёстой.

29 Fancy and McAslan Fraser, 2014a; Greene et al, 2013

БҮЛЭГ II

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ЗОГСООХ ЦОГЦ АРГА
ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЛХАМ

UUMN
СҮДАЛГААНЫ САН

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЗОГСООХ ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХАМ

2.1 МАНЛАЙЛАЛ: ХУУЛЬ, БОДЛОГО БОЛОН БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ

Хууль тогтоомж, бодлогоор хамгаалагдсан байх нь СХЖСХ-тэй тэмцэх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах үндэс суурь. Эдгээр бодлогын зохицуулалтын хүрээ нь СХЖСХ-тэй тэмцэх Засгийн газрын амлалтыг илэрхийлдэг. Хууль тогтоомж гэдэг нь хууль батлахаас эхлэн хэрэгжүүлэх бүхий л үйл явц юм. Энэ нь эрх, эрх үүрэг, засгийн газрын үүрэг хариуцлагыг тогтоодог³⁰. Хууль тогтоомжийн хүрээ нь улс орнуудын олон улсын үүргээ биелүүлж, бүх хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай.

ЭРГЭЦҮҮЛЭХ АСУУЛТ:

Одоо хэрэгжиж буй Боловсролын багц хууль, хүүхэд хамгааллын хууль зэрэг эрх зүйн хүрээг үнэлж, СХЖСХ-тэй хэрхэн уялдаж байгааг нягтлан, эдгээр нь олон улсын стандартад нийцэж байгаа эсэхт шинжилгээ хийнэ үү. Шинэ хууль шаардлагатай юу, эсвэл холбогдох хууль эрх зүйн зүйл, заалтуудыг өөрчлөх боломжтой юу?

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 1. СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭ

Хэрэгжилтийг үнэлэх: Хууль тогтоомж дангаараа хангалтгүй, хуулиудыг заавал дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, зохих, пропорциональ шийтгэлийг багтаасан үр дүнтэй зохицуулалт, бодлогоор дэмжих ёстой (Greene et al, 2013). Хэрэгжүүлэхэд ямар сул тал байна вэ? Хуулийн хэрэгжилтийг хангахад ямар хөрөнгө оруулалт, төсвийн хуваарилалт шаардлагатай вэ? Сургуулийн боловсон хүчин, багш нарын боловсролыг хэрэгжүүлэхэд бэлэн үү, чадаж байна уу?

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн кейстэй одоо байгаа хууль тогтоомжийг уялдуулах: Янз бүрийн салбар дахь хууль тогтоомж, зохицуулалтыг нягт уялдаатай байлгах, СХЖСХ-г одоо мөрдөж буй хуулиудад тусгасан эсэхийг шалгах шаардлагатай. Гол нь боловсролын салбар, хүүхэд хамгааллын салбар хоорондын хамтын ажиллагаа, хэрэгжүүлэгч агентлагуудын дунд зөвшилцөл бий болгох, түүнчлэн бодлого боловсруулагчид СХЖСХ-ийг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байгааг мэдэж байх нь чухал. Одоогийн байдлаар олон улсад СХЖСХ-тэй холбоотой хууль тогтоомжийн дөрвөн үндсэн чиглэл байдаг:

- Хүүхдийн эрхийн хууль (жишээ нь, Либерийн Хүүхдийн тухай хууль (2010) нь бүх хүүхдийн үндсэн эрхийг хамгаалж, хүүхэд хамгааллыг багшийн сургалтын зайлшгүй элемент болгон тусгасан);
- Бие махбодын шийтгэлийг хориглох (жишээлбэл, Энэтхэгийн Боловсролын эрхийн тухай хуулиар (2009) 'Ямар ч хүүхдэд бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт үзүүлэх ёсгүй' гэсэн заалтаар сургуулиудад бие махбодын шийтгэлийг хориглосон байдаг);
- Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх (жишээ нь, Танзани улсын Хүүхдийн тухай хууль (2009) нь хүүхдийг бүх төрлийн бэлгийн хүчирхийллээс хамгаалдаг, тэр дундаа сургууль дээр);
- Дээрэлхэлтийг тусад нь хуульчлах (жишээ нь, Филиппин улс Дээрэлхэлтийн эсрэг хууль (2013) батласан бөгөөд бүх сургууль дээрэлхэхийн эсрэг бодлоготой байх, түүнийг мөрдөхийг шаарддаг)

Үндэсний боловсролын салбарын төлөвлөгөө, стратегийн хүрээнд СХЖСХ-ийг тодорхой тусгах: ахиц дэвшлийг хянах шалгуур үзүүлэлт, зорилтуудыг багтааж, хяналт-шинжилгээ, хэрэгжүүлэхэд хангалттай нөөцийг хуваарилах.

30 НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, 2013b

Мэдрэмжтэй байдал ба бодлогын нөлөөлөл: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч сургуулийн удирдлагууд, багш, хуульч, цагдаа гэх мэт тэргүүн эгнээний ажилтнууд хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй, хуулийг хэрэгжүүлэх чадвартай байх шаардлагатай. Иймд холбогдох салбарыг бэлтгэх, мэргэшүүлэхэд ихээхэн анхаарах шаардлагатай байна. Үүнд багш, сургуулийн захирлууд болон бусад оролцогч талууд асуудлыг бүрэн ойлгож, хэрэгжүүлэх үйл явцад өөрсдийн үүргээ биелүүлэхэд бэлэн байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Хууль тогтоомж, бодлогын талаарх мэдээлэл, мэдлэгийг хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр иргэд, олон нийт, хүүхдүүдэд хүргэх ёстой.

Бодлогын хүрээ нь үндэсний бодлого, үйл ажиллагааны чиглэл, холбогдох журмууд, стратеги төлөвлөгөө, хурлын тэмдэглэл болон бусад механизм зэрэг бодлого, хөтөлбөр боловсруулахад чиглүүлэх нэгдсэн баримт бичгүүд юм. СХЖСХ-ийн бодлогын үндсэн хүрээнд боловсролын тогтолцоо болон охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эмзэг болон цөөнхийн бүлгийн эрхийн талаарх аливаа бодлого, тогтолцоо, үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнүүд бүгд багтана.

Ихэнх улс орнууд Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын хууль, Боловсролын хууль, Ёс зүйн дүрмэндээ тусгах замаар СХЖСХ-ийг зохицуулах бодлогын арга хэмжээ авч байгаа ч цогц байдлаар шийдсэн улс хараахан алга байна. Энэ нь тухайн орны соёл, нийгмийн хүчин зүйлүүдтэй нягт холбоотой.

Манай улс сургуулийн орчинд (дотуур байрыг оролцуулан) аюулгүй байдлыг төрөөс тодорхой хэмжээнд анхаарч байгаа бөгөөд 2021 оноос хойш хэд хэдэн бодлогын баримт бичгийг боловсруулаад байна. Тухайлбал, Багшийн ёс зүйн дүрэм (2022), Боловсролын багц хууль (2023 оны 7 сард батлагдаж, 8 сараас хэрэгжиж эхэлсэн), Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2024 оны 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн), мөн “Тэгш хамруулах боловсролын бодлогын чиглэл” (2022-2024), “Хүүхдэд ээлтэй дотуур байр” үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028) зэргийг Боловсролын сайдын тушаалаар батлаад байна.

СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭ БА ШИНЭЧЛЭЛ

Боловсролын тогтолцоон дахь СХЖСХ-ийн шалтгаан, хариу арга хэмжээг тодорхойлохын тулд жендэрийн хувирган өөрчлөх хандлага, арга зүйгээр бүхэлд нь үнэлж, шинэчлэх нь цогц арга хэмжээг боловсруулах нь эхний чухал алхам юм. Боловсролын салбарын бүхэлд нь, өргөн хүрээнд авч үзсэн үнэлгээ, шинэчлэл нь боловсрол, сургалтын байгууллагуудыг СХЖСХ-тэй тэмцэх цогц стратегийг бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ. Энэ нь урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл хийх, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах үндэс суурийг тавина.

СХЖСХ-ийг шийдвэрлэх шинэчлэлийг цогц байдлаар хэрэгжүүлэх нь янз бүрийн түвшинд оршин буй боломжууд, сорилтуудыг харгалзан үзэхэд тусалж, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалах, жендэрийн тэгш байдлыг дэмжихтэй холбоотой өмнө нь батлагдсан бодлого, нөөц дээр суурилсан бодлогыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнээс гадна, системийн хүрээний хандлага нь СХЖСХ-тэй тэмцэхэд шаардлагатай түншүүдийг тодорхойлох, энэ чиглэлээр өмнө нь ажиллаж байсан талуудтай хамтран ажиллах боломжийг олгодог.

Багш, боловсролын салбарын бусад ажилтнуудтай хийсэн ярилцлагын үндсэн дээр СХЖСХ-тэй тэмцэх **гурван үндсэн зорилт³¹**ыг дараах байдлаар тодорхойлсон байна:

- **МАНЛАЙЛАХ:** Боловсролын яам бодлого, удирдамжийг боловсруулж хэрэгжилтийг хангахад дэмжих
- **ЗААХ:** Сургуулиуд сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, багшийг бэлтгэх сургалт зохион байгуулах зэрэг нөөцийг бий болгох

31 Global Guidance on addressing school-related gender based violence (2016), p-46

- ХАМТРАН АЖИЛЛАХ: Эцэг эх, орон нутгийн олон нийтийг татан оролцуулж, эерэг хандлага, дадлыг төлөвшүүлэх

Системийн хүрээний үнэлгээ, шинэчлэл нь боловсролын тогтолцооны олон түвшинд хэрэгжих стратегийг боловсруулахад тусалдаг. Эдгээр стратегиудыг **Практик үйл ажиллагаа** хэсэгт нарийвчлан авч үзэх бөгөөд тодорхой үйл ажиллагаануудыг санал болгохын зэрэгцээ энэхүү удирдамжийн холбогдох хэсгүүдтэй уялдуулан тайлбарлана.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 2: БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭ, ШИНЭЧЛЭЛЭЭР ДАМЖУУЛАН СХЖСХ-ИЙГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?		
Боловсролын салбар дахь байгууллагын шинэчлэл нь олон түвшинд хэрэгжиж болох бөгөөд дараах чиглэлүүдийг хамарна:		Дараах хэсгийг үзнэ үү:
Боловсролын яам	• СХЖСХ-тэй холбоотой хууль, үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хүрээний загварчлал, хэрэгжилт, жендэрийн шинжилгээг дэмжих	2.1 МАНЛАЙЛАЛ: ХУУЛЬ, БОДЛОГЫН ОРЧИН, БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ
	• Жендэрийн мэдрэмжтэй төсвийг баталж, шинэ бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхийг хангах	2.2 ЁС ЗҮЙН ДҮРЭМ
	• СХЖСХ, хүүхэд хамгаалал болон гэмт буруутай этгээдийг шүүхэд өгөх хууль, бодлогыг хэрэгжүүлж, зохицуулах. Ёс зүйн дүрмүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж, тохиромжтой ял шийтгэл хэрэглэхэд хянаж үнэлэх	
	• Боловсролын байгууллагын ажилтнууд, багш нар, сургуулийн удирдлагууд болон бусад хүмүүсийг СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх сургалтанд хамруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	2.3 СУРГАЛТЫН АРГА БА БАГШИЙН СУРГАЛТ, БАГШ БЭЛТГЭХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР, ДАХИН СУРГАЛТ
	• Насанд тохирсон СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх ойлголт, ур чадваруудыг үндэсний сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд нэгтгэх.	2.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХАНДЛАГА, АРГА ЗҮЙ
	• Үндэсний болон орон нутгийн түвшинд хууль, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ рүү шилжүүлэх тогтолцоог сайжруулах.	2.4 ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ, ХОЛБОХ
	• Багш нар, сургуулийн ажилтнууд болон сурагчдын (үе тэнгийн сургагч багш нар) мэдээлэх хэрэгсэл, механизмудыг боловсруулж хөгжүүлэх.	2.4 МЭДЭЭЛЭХ МЕХАНИЗМУУД (108 зэрэг)
	• СХЖСХ-ийн эсрэг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээнд бусад оролцогч талууд болон түншүүдтэй хамтран ажиллах.	2.5 ҮНДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БА УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙХ
	• СХЖСХ-ийн талаарх өгөгдлийг цуглуулах, тогтмол хяналт-шинжилгээ хийх болон хуваалцахад хөрөнгө оруулах.	2.6 ХЯНАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Багшийн сургалт	СХЖСХ-ийг багш бэлтгэх тогтолцоо, түүний сургалтын хөтөлбөрт багтаах, багш нарыг жендэрт суурилсан хүчирхийллийн шалтгаанууд, урьдчилан сэргийлэх боломжит үйл ажиллагаа, таслан зогсоох болон хариу арга хэмжээ авах, нийгмийн ажлын үйлчилгээнд холбон зуучлах тогтолцооны талаар сургах	2.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БА БАГШИЙН СУРГАЛТ
Багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбоод	• Боловсролын яамтай хамтран мэргэжлийн ёс зүйн дүрэм, жендэрийн тэгш эрхтэй хүний нөөцийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлж, шинэчлэх.	2.2 ЁС ЗҮЙН ДҮРЭМ
	• Багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдийн СХЖСХ-ийн талаарх ойлголт, мэдлэг дээшлүүлэх, мөн СХЖСХ-д өртсөн багш нарт дэмжлэг үзүүлэх.	2.3 СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БА БАГШИЙН СУРГАЛТ
Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагууд	Үндэсний удирдамжийн дагуу бүх нийтийг хамарсан, жендэрийн мэдрэмжтэй, ялгаварлан гадуурхах үзэлгүй сургуулийн дүрэм журам, горимыг боловсруулах	2.2 УДИРДАХ БАЙГУУЛЛАГА БА МЕНЕЖМЕНТ
	Аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх	2.2 АЮУЛГҮЙ, ДЭМЖЛЭГ БҮХИЙ СУРГУУЛЬ
	Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн хэм хэмжээ, ялгаварлан гадуурхахгүй байх үзэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, заах арга зүй бүхий сургалтын орчныг бүрдүүлэх	2.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АРГА ХАНДЛАГА 2.3 СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БА БАГШИЙН СУРГАЛТ
	Охид, хөвгүүдийн клуб байгуулах, сурагчдыг хувийн орон зай, хил хязгаар, зөвшөөрөл, хүчирхийллийг таних, мэдээлэх чиглэлээр үе тэнгийн сургагч багш эсвэл зуучлагчаар бэлтгэх замаар сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад сурагчдын оролцоог хангах механизмыг бий болгох, тэдний чадавхыг бэхжүүлэх	2.3 АЮУЛГҮЙ ОРЧИН БА ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨТӨЛБӨР 2.5 ЗАЛУУЧУУДЫН МАНЛАЙЛАЛ БА ОРОЛЦОО
	Сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг холбогдох байгууллагад шилжүүлэх болон зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх	2.4 ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭ БА ДЭМЖЛЭГ
	Эцэг эх-багшийн холбоо, сургуулийн удирдлагын зөвлөл, орон нутгийн иргэд болон бүлгүүд зэрэг байгууллагаар дамжуулан гэр бүл, олон нийттэй хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх	2.5 ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ 2.5 ГЭР БҮЛИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ

2.2 АЮУЛГҮЙ, ДЭМЖЛЭГИЙН ТОГТОЛЦОО БҮХИЙ СУРГУУЛИЙН ОРЧИН

Сургууль бол хамт олны манлайлал, хоршил, хамтын суралцахуйд суурилсан шударга, үл ялгаварлан гадуурхдаг, өсөлт хөгжлийг дэмжих орон зай.

Боловсрол сургалтын байгууллагын бүхий л үйл ажиллагаа буюу багшлахуй, суралцахуй, нийгэмшихүйн болон ажиллаж буй орчиндоо сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийллийг (СХЖСХ) хэрхэн шийдвэрлэж буйгаар нь хүүхдэд ээлтэй эсэхийг тодорхойлогддог.

Сургуулийн орчныг хүүхдэд ээлтэй, аюулгүй, сурахад таатай болгохын тулд сургууль бүхэлдээ ажиллах хандлага, арга зүй хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд нийгэм-экологийн загвараар сургуулийн түвшин, орон нутгийн иргэд, засаг захиргаа зэрэг олон талт оролцогчдыг хамруулсан төрөл бүрийн үйл ажиллагаа багтдаг³².

Үндсэн стратегиуд:

- ◇ Аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх;
- ◇ Сургуулийн зөвлөл болон удирдлага бүхэлдээ СХЖСХ нь хүлээн зөвшөөрөхгүй, ноцтой асуудал болохыг тодорхой илэрхийлдэг байх;
- ◇ Ёс зүйн дүрэм, зан үйлийн хэм хэмжээг мөрдөх;

АЮУЛГҮЙ, ТАВ ТУХТАЙ СУРГУУЛИУД



Аюулгүй, дэмжлэг бүхий сургууль нь зохих дэд бүтцийн хувьд хүртээмжтэй байх, тухайлбал; сургуулийн барилга байгууламж дэд бүтэц хүртээмжтэй, гадна талбай, зохистой ус ариун цэврийн байгууламжтай, гэрэлтүүлэг сайтай, тавилга хүүхдийн биемахбодод тохирсон, аюулгүй байдал хамгаалалтын системтэй байх хэрэгтэй. Хэдийгээр орчныг аюулгүй байлгах чухал ч сургуулийн орчин сурагчид, эцэг эхчүүд, орон нутгийн иргэдэд нээлттэй, тайван амгалан байх боломжийг хангах, тэдний утга учиртай оролцоо, хариуцлагыг дэмжихэд чиглэх хэрэгтэй.

Сургуулийн материаллаг орчин СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд сургуулийн барилга байгууламж, гадна талбай, мөн сургуульдаа ирэх, буцах зам, тээврийн хэрэгслийг хамруулан үздэг. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ихээр гардаг халуун цэгүүд болох ариун цэврийн өрөө, хоосон анги, коридор, шатны хонгил, сургуулийн автобус, тоглоомын талбай, биеийн тамирын заал, хувцас солих өрөө, дотуур байр, сургуулийн хашааны эргэн тойрон багтана. Зохион байгуулалт муутай, засвар үйлчилгээ хийгдээгүй дэд бүтэц — жишээлбэл бүдэг гэрэлтүүлэг, эвдэрсэн цоож, тусгаарлагдсан орчин, хангалтгүй хяналт зэрэг нь СХЖСХ-ийн эрсдэлийг улам нэмэгдүүлж болзошгүйг анхаарууштай.

³² Fulu et al, 2014, х.14

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 3: СУРГУУЛЬД АЮУЛГҮЙ МАТЕРИАЛЛАГ ОРЧНЫГ ХЭРХЭН БҮРДҮҮЛЭХ ВЭ — ЖИШЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Сургуулийн байршил, гадна талбай болон ирэх, явах замууд	- Сургуулийг орон нутгийн иргэдийн аюулгүй гэж үздэг байршилд барих (хөрсний эвдрэл бага, цэвдэггүй, үеийн амнаас хол, томоохон зам, цэнгээний газар, зочид буудал, гэмт хэрэг их гардаг бүсээс хол) - Сургуулийн барилга, гадна талбай, орох, гарах замд аюулгүй байдлын үнэлгээ хийх (үүнд: хөвгүүд, охид, цөөнхийн бүлгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй сурагчид зэрэг ялгаатай хэрэгцээтэй сурагчдын туршлагыг тусгах) - Сургуулийн орчин болон түүний эргэн тойрон дахь гэрэлтүүлгийг сайжруулах, тогтмол засвар, арчилгаа хийх - Хашаа, хяналтын цэгүүдийг байгуулах, орох гарах хэсгийг тодорхой болгох, тэмдэг тэмдэглэгээ хийх, бут сөөгийг тогтмол тайрах
Барилга байгууламж, анги танхимын зохион байгуулалт	- Сургуулийн дэд бүтцийг төлөвлөхдөө СХЖСХ болон аюулгүй байдлын асуудлыг тусгах - Анги танхим, лаборатори, бусад өрөөнүүдэд цонх, хаалганы тоо болон хэмжээг нэмэгдүүлж, гаднаас харагдах орчныг сайжруулах замаар аюулгүй байдлыг хангах - Багш нарын өрөөний хаалгыг шилэн байдлаар загварчлах
Ус, ариун цэврийн барилга байгууламж (WASH)	- Хөвгүүд, охид, эрэгтэй, эмэгтэй багш, сургуулийн ажилчид, жендэрийн ялгаатай хэрэгцээтэй бүлгүүдэд зориулсан тусгаарласан, цоожтой ариун цэврийн өрөөг хангалттай тоогоор, хүртээмжтэй байгуулах - Ариун цэврийн өрөө нь сургууль, дотуур байр дотроо нээлттэй, харагдахуйц тодорхой байршилд, тэмдэг тэмдэглэгээ тод байх ёстой. - Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй хог хаягдал боловсруулах байгууламжаар хангах - Сарын тэмдгийн үед хэрэглэсэн ариун цэврийн хэрэглэлээ солих, угаах зориулалттай тусгай орон зайг ариун цэврийн өрөөнд төлөвлөх
Хяналт болон засвар үйлчилгээ	- Сургуулийн харуул хамгаалалт, багш нар, сургуулийн ажилтан, жижүүр сурагчид (багшийн хяналт дор) нь хүүхдүүд СХЖСХ-д хамгийн өртөмтгий байдаг газруудыг (жишээлбэл, шатны хонгил, хоосон анги танхим, коридор, сургуулийн хашааны орчим) тогтмол хянадаг байх - Эвдэрсэн гэрэлтүүлэг, хяналтын камер, ариун цэврийн өрөө (хаалганы цоожийг оролцуулан), хамгаалалтын тоног төхөөрөмж зэргийг тогтмол шалгаж, засварлах
Тээврийн хэрэгсэл	- Сургуульд явах болон гэртээ харих замын аюулгүй байдлыг сайжруулах. Жишээлбэл, аюулгүйн гарц байгуулах, сургуулийн тээврийн хэрэгслээр зорчих боломжийг бүрдүүлэх, - Жолооч нарыг ЖСХ-ийн агуулгаар сургах, сургууль тусгайлан гэрээ байгуулах - Хүүхэд хамгааллын бодлогыг тээврийн хэрэгсэлд харагдахуйц газар байрлуулах, дээрэлхэлтийн талаар мэдээлэх сувгийн мэдээллийг байршуулах

Тав тухтай, ээлтэй сургууль гэдэг нь сургуулийн хамт олны гишүүн бүр — сурагч болон ажилтан хэн боловч — өөрийгөө үнэ цэнтэйгээр мэдэрдэг орчин юм. Энэ орчинд хүмүүс бие биетэйгээ хүндэтгэлтэй харьцдаг, тэсвэр тэвчээр, олон янзат байдлыг дэмжих соёл, харилцааны зарчим үйлчилдэг, сурагч бүр эрх тэгш суралцах, оролцох боломжоор хангагддаг, мөн сурагч ба багш нарын хооронд итгэлцэл, дэмжлэгийг бий болгодог тогтолцоо бүрдсэн байхыг ойлгоно.

Бүх сурагч, ажилтанд нээлттэй, тухтай орчин бүрдсэн сургуулийг “нийгмийн бүх гишүүнд хүртээмжтэй соёл бүрдсэн” гэж тодорхойлж болно. Үүнд:

- Сургуулийн удирдлагууд нь тэгш хамруулах үнэт зүйлсэд итгэдэг бөгөөд олон талын оролцоог дэмждэг манлайллын хэв маягийг баримталдаг.
- Ажилтнууд өөр хоорондоо өндөр түвшний асуудал шийдвэрлэх, хандлага, хамтын ажиллагаатай.

- Дээрх үнэт зүйлс нь зөвхөн сургуулийн захирал, багш, ажилтнуудаар хязгаарлагдахгүй, сурагчид, эцэг эх асран хамгаалагчид болон орон нутгийн иргэд, олон нийтэд ч хүрч байдаг.

Судалгаагаар, тэгш хамруулах соёлыг дэмжихийн тулд сургуулийн удирдлагууд дараах гурван үндсэн чиглэл³³д анхаарах шаардлагатай байдаг гэж үздэг. Үүнд:

1. Олон янзат байдлыг хүний эрхийн агуулгаар ойлгуулах,
2. Тэгш хамруулсан багшлахуй, суралцахуйн практикийг төлөвшүүлэх,
3. Сургууль ба орон нутгийн иргэд, олон нийтийн хоорондын холбоог бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргах

Ийм орчинд сурагчид хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах нөхцөл байдлыг илүү сайн таньж мэдэхээс гадна, итгэдэг багш, насанд хүрэгчдэд тохиолдсон болон харсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлын талаар илүү тайван, итгэлтэйгээр мэдээлэх боломжтой болдог.

НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдэд ээлтэй сургууль”-ийн загвар нь сургуулийг бүх талаас нь цогц байдлаар үнэлэх боломжийг олгодог бөгөөд дараах гурван үндсэн зарчимд тулгуурладаг: **хүүхэд төвтэй байх, ардчилсан оролцоотой, тэгш хамруулсан байдал**. Эдгээр зарчим бүр нь тодорхой онцлог шинжүүдийг агуулдаг.

Зураг 8. Хүүхдэд ээлтэй сургуулийн загвар

Зарчим	Хүүхдэд ээлтэй сургууль
Хүүхэд төвтэй	◆ Хүүхдүүд идэвхтэй оролцогч байдаг хүүхэд төвтэй сурган, заах арга зүй ◆ Архитектор зураг төслөөс эхлээд үзүүлж буй үйлчилгээ, үйлчилж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл, аюулгүй, хамгаалагдсан сургалтын орчин
Ардчилсан оролцоотой	◆ Сургуулийн шийдвэр гаргах үйл явцад хүүхдүүд, тэдний гэр бүлүүд, орон нутгийн иргэд идэвхтэй оролцогч байдаг. ◆ Гэр бүл, сургууль нь орон нутагтайгаа нягт холбоотой. ◆ Бодлого, үйлчилгээгээрээ дамжуулан шударга ёс, ялгаварлан гадуурхалтгүй, хамтын оролцоог дэмждэг
Тэгш хамруулсан	◆ Хүүхдэд анхаарал тавьдаг ◆ Бүх суралцагчдад тэгш хүртээмжтэй, найрсаг хандах ◆ Жендэрийн мэдрэмжтэй, охидод ээлтэй ◆ Бодлого, үйлчилгээ нь ирцэд анхаарч, сургууль дээрээ байхыг дэмждэг

САЙН ТУРШЛАГА: АЮУЛГҮЙ, СУРАХ БОЛОМЖООР ХАНГАСАН СУРГУУЛИЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР, ХОРВАТ УЛС³⁴

“Аюулгүй, дэмжигч сургуулийн орчин” гэдэг хөтөлбөрийг Хорват дахь НҮБ-ын Хүүхдийн Сан, Боловсрол шинжлэх ухаан, спортын яам, Багшийн сургалтын агентлагтай хамтран 2 үндсэн чиглэлээр хэрэгжүүлжээ.

1. Хүүхдүүдийн дундах хүчирхийллийг зогсооё! гэдэг нийтийг хамарсан аян өрнүүлсэн бөгөөд сургууль дээрх үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтийг зогсооход гол анхаарлаа хандуулж үг хэл, бие махбодын хүчирхийллийн талаар ойлголт нэмэгдүүлэх замаар нийгмийн өөрчлөлтийг хийх гол зорилготой байв.
2. Сургууль дээрх үе тэнгийнхний хүчирхийллийн тохиолдлыг бууруулах, аюулгүй, сурах боломжийг дэмжсэн орчин бүрдүүлэх, хүчирхийллийг зогсоох бүхий л үйл ажиллагаа,

33 UNESCO-IBE, 2015

34 INSPIRE АРГА ЗҮЙН ТОЙМ: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох долоон стратеги, х-69

бодлого шийдвэрт хүүхдийн оролцоог хангасан. Үр дүнд нь 2003-2011 онд Хорватын бага сургуулиудын 37%-д нь хүчирхийлэл 50 хувиар буурчээ. Энэ хугацаанд Хорватын 301 сургууль дээр (ихэвчлэн бага сургуулиуд) хөтөлбөр хэрэгжиж 163 сургууль нь хүчирхийлэлгүй сургууль цол авч 85 сургууль нь энэ цолоо 3 жилийн дараа дахин хамгаалжээ. Энэ хөтөлбөрийг 2005, 2008, 2012 онуудад үнэлсэн байна. 2008 оны үнэлгээгээр:

- о байнгын дээрэлхэлтийн тохиолдол 10%-иас 5% болж 2 дахин буурсан.
- о бусдыг дээрэлхдэг хүүхдийн хувь 13-аас 3% болж буурсан.
- о Хүүхдүүдийн 55 хувиас илүү нь сургууль дээрээ үргэлж аюулгүй байдлыг мэдэрдэг гэж хариулсан.

Хүүхдүүд 2004 онд багш нарынхаа дөнгөж 30 хувийг үе тэнгийн хүчирхийллийг зогсоох талаар анхаардаг гэж мэдээлж байсан бол тэд 2008 онд тэд багш нарын 63 хувь нь энэ талаар үргэлж анхаардаг гэж хариулжээ. 2005 оны үнэлгээгээр олон нийтийн аяныг судалгаанд оролцогчдын 95 хувь нь өндөр үнэлсэн бөгөөд 65 хувь нь хамгийн өндөр оноог өгч маш эергээр үнэлсэн. Хорватад ийм сайн үр дүн гарсны дараа НҮБ-ын Хүүхдийн Сан болон иргэний нийгмийн байгууллагууд “Хүчирхийлэлгүй сургууль” хөтөлбөрийг Болгар, Казакстан, Монтенегро, Серб, Словени улсуудад хэрэгжүүлсэн.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 4: СУРГУУЛИЙН ДОТОРХ АЮУЛТАЙ БАЙРШИЛ, ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭРҮҮДИЙГ ОРОЛЦОГЧДЫН ОРОЛЦООТОЙГООР ТОДОРХОЙЛОХ ГАЗРЫН ЗУРАГ ГАРГАХ АРГАЧЛАЛ

Хүүхдэд ээлгүй, аюултай гэж үзэж буй сургуулийн орчны газрын зургийг хийхэд ашиглаж болох нэг арга хэрэгсэл нь “Оролцоот газрын зураг” юм. Дараах 2 аргачлалаар ажиллаж болно.

А. ЗУРАГЛАЛ ХИЙХ



- Нэг хүйсээс бүрдсэн бүлэгтэй ажиллах нь үр дүнтэй байж болно. Эсвэл холимог бүлгээр ч ажиллаж болно. Хамгийн чухал нь оролцогч бүх хүүхэд, охид, хөвгүүдийг бүгдийг оролцуулан сургуулийнхаа гол онцлог (ангиа, тоглоомын талбай, ариун цэврийн өрөө, камер, хувцас солих өрөө гэх мэт), мөн сургууль руугаа ирэх, буцах замыг харуулсан ПЛАН зураг зурахыг хүснэ.
- ПЛАН зургийг зурж дууссаны дараа сурагчдаас аюулгүй гэж үзсэн газруудад ногоон цэг, аюултай гэж үзсэн газруудад улаан цэг тавихыг хүснэ (стикер, наадаг цаас ашиглаж болно).
- Эцэст нь хүүхдүүд яагаад тухайн газрыг аюулгүй, аюултай гэж тэмдэглэсэн тухайгаа хоорондоо ярилцана.

Б. АЖИГЛАЛТ ХИЙХ



Ажиглалт хийх аргыг хэрэглэхдээ материаллаг орчны аюулгүй байдлыг “Үнэлэх хуудас” боловсруулж ажиглалт хийх багт чиглэл өгч тараана.

Ажиглалт хийх баг нь эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл, сурагчдын төлөөлөл, орон нутгийн иргэд олон нийтийн төлөөллийг оролцуулсан байх шаардлагатай. “Үнэлэх хуудас”-ны дагуу тэмдэглэл хөтөлж, багаараа сургуулийн орчны аюулгүй байдалд үнэлэлт өгч, сургуулийн удирдлагуудад танилцуулан хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгах замаар сургуулийнхаа материаллаг орчныг сайжруулахад хамтран ажиллана.

СУРГУУЛИЙН УДИРДЛАГА БА МЕНЕЖМЕНТ

Улс орнуудад сургуулийн удирдлагын хяналт, зохион байгуулалтын үүргийг тодорхой нэг удирдлагын бүтцээр зохицуулсан байдаг. Энэхүү бүтцийн нэршил нь улс орон бүрт өөр өөр байж болох ч ихэвчлэн “Сургуулийн зөвлөл”, “Удирдах хороо”, “Сургуулийн менежментийн баг” гэх мэт нэртэйгээр оршдог.

Аюулгүй, бүгдэд ээлтэй сургуулиуд нь хүчирхэг менежмент, үр дүнтэй сургуулийн удирдлагын багтай байдаг гэж үздэг³⁵. Сургуулийн удирдлага болон засаглалын тогтолцоо нь сурагчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүрэг хүлээдэг. Тэд СХЖСХ-ийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ ил тод илэрхийлж, урьдчилан сэргийлэх болон тохиолдсон кейст хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Боловсролын байгууллагуудын удирдлагууд, багш нар өөр хоорондоо нягт хамтран ажиллахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно:

- Хүчирхийллийн тохиолдлыг бүртгэх, тайлагнах, холбогдох газарт шилжүүлэх дүрэм, журам боловсруулах,
- Сурагч эсвэл багш хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах тогтолцоог сургуульдаа бий болгох

Сургуулийн удирдлагууд ил тод байдал, хариуцлага, оролцоог дэмжих замаар СХЖСХ-ийн эсрэг засаглалын соёлыг төлөвшүүлж чадна. Энэ нь сургуулийн хамт олны бүх гишүүдийг хүчирхийллийг таслан зогсоох, хариу арга хэмжээ авахад идэвхтэй оролцох боломжоор хангах юм.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 5: СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛ БА УДИРДЛАГУУД СХЖСХ-ИЙГ ШИЙДВЭРЛЭХИЙН ТУЛД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Сургуулийн удирдлага юу хийж чадах вэ?

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ:

- ◆ Багш, сургуулийн ажилчдад СХЖСХ-ийн талаарх сургалт зохион байгуулж, жендэрийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэхэд чадавхжуулах;
- ◆ Сахилга бат тогтоох аргыг боловсруулж, хүмүүжлийн эерэг арга барилыг сургуулийн орчинд хэрэгжүүлэх;
- ◆ Сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулах, тэдэнтэй зөвлөлдөх;
- ◆ Гэр бүлүүд, иргэд, олон нийттэй хамтран ажиллаж, сахилга бат тогтоох, хүмүүжлийн эерэг арга барил, жендэрийн тэгш байдал, хүчирхийллээс ангид байх зарчмуудыг сурталчлах, мөн орон нутаг дахь хүүхэд хамгааллын тогтолцоотой нягт холбоотой байх;

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ:

- ◆ хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх, хохирогчдод тусламж үзүүлэх чиглэлээр тодорхой, аюулгүй, тэгш хүртээмжтэй журам, механизмыг бий болгох (кейсийг хэзээ, хэнд мэдээлэхийг ойлгомжтой болгох);
- ◆ зөвлөгөө өгөх болон дэмжлэгийн үйлчилгээнд холбох, шилжүүлэх тогтолцоо бүрдүүлэх;

ХАРИУЦЛАГА ТООЦОХ БАЙДАЛ:

- ◆ СХЖСХ-ийг хориглосон үндэсний хууль, бодлогыг хэрэгжүүлэх сургуулийн дүрэм, журам, заавар боловсруулах;
- ◆ Хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хариуцлага тооцох үр дүнтэй сахилгын журам боловсруулж хэрэглэх (насанд хүрэгчид болон сурагчдад), Хяналтын хороо зэрэг механизм бий болгох;

35 Dunne et al., 2005; Pinheiro, 2006

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Ёс зүйн дүрэм нь хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны үнэт зүйлс, зан үйлийн стандартыг тодорхойлсон заавар, удирдамжийн цогц юм. Ийм дүрмийг ихэвчлэн үндэсний түвшинд боловсруулж, сургуулиудад хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь хуулийн болон байгууллагын дэмжлэгийг хангах зорилготой. Ёс зүйн дүрэм нь гол төлөв багш, сургуулийн ажилчдад хамаарах боловч зарим тохиолдолд сурагчид, эцэг эхчүүдэд ч мөн үйлчлэх боломжтой.

Ёс зүйн дүрэмд зөрчил гарсан тохиолдолд мэдээлэх, зөрчлийг хянах, холбогдох хууль ёсны үйл явцыг хэрэгжүүлэх тодорхой, ил тод журам багтсан байх шаардлагатай.

Ёс зүйн дүрэм нь СХЖСХ-ийн (сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл)-тэй тэмцэхэд дараах шалтгаануудын улмаас чухал ач холбогдолтой:

Боловсролын салбарын мэргэжилтнүүдийг чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх:	Сурагч, багш, сургуулийн ажилчдыг хамгаалах:	Боловсролын мэргэжлийн өндөр түвшинг хадгалах, төлөвшүүлэх:	Боловсролын мэргэжлийн байдлыг дэмжих олон нийтийн итгэл
- Боловсролын салбарын ажилтнуудад тулгарч буй ёс зүйн сорилт, асуудлыг шийдвэрлэхэд туслах - Багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх тодорхой, мэргэжлийн хэм хэмжээг ил тодоор тогтоох, таниулах	- Сурагчдыг хор хохирол, ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлэлт, дарамт, доромжлол зэргээс хамгаалах - Багш, сургуулийн ажилтнуудын итгэлийг хадгалах, тэднийг эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэх - Ёс зүйн зөрчлийн үр дагаврыг онцлох, ухамсарлуулах	- Боловсролын ажилтнуудын нэр хүнд, өөртөө итгэх итгэл, нэр төрийг хамгаалах - Үүрэг хариуцлага, ажлын үр дүн, мэргэжлийн ёс зүйтэй хандлагыг нэмэгдүүлэх - Боловсролын салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн итгэл үнэмшил, ухамсрыг төлөвшүүлэх	- Боловсролын мэргэжлийн байдлын эерэг дүр төрхийг олон нийтэд харуулах, таниулах - Нийгмийн хариуцлага, эгэх хариуцлагын тогтолцоогоо сурагчид, эцэг эх, олон нийтийн өмнө мэргэжлийн түвшинд онцлох - Хамгийн сайн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Ёс зүйн дүрэмд суралцагчийн эсрэг аливаа хэлбэрийн (бие махбодын, үг хэл, сэтгэл зүйн болон бэлгийн) хүчирхийлэл, бэлгийн дарамт, сургууль доторх зүй бус үйлдэл, суралцагчидтай бэлгийн харьцаанд орох (албадсан эсвэл зөвшилцсөн аль аль нь) зэргийг хүлээн зөвшөөрөхгүй байх ёстой. Энэхүү дүрэмд хүчирхийлэлд өртсөн, гэрч болсон суралцагчдад үзүүлэх зохих хариу арга хэмжээ, зүй бус үйлдлийг мэдээлэх механизмыг тодорхой тусгасан байх ёстой. Мөн дүрэм зөрчсөн тохиолдолд гарах үр дагаврыг тусгаж, дүрмийн хэрэгжилтийг хуулиар хэрхэн дэмжиж байгааг тодорхой зааж өгөх ёстой.

САЙН ТУРШЛАГА: ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХЫН ТӨЛӨӨХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ, ТАЙВАНЬ УЛС³⁶

Мельбурн дахь Тайваны сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм нь (Child Safety Code of Conduct)³⁷ сургуулийн бүх ажилтнууд, сурагчдын аюулгүй байдал, үйл ажиллагаа, сайн сайхан байдлыг дэмжих зорилготой. Үүнд:

- Сургуулийн эрсдэлийн удирдлагын стратегийг үргэлж дагаж мөрдөх;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих;
- Сурагчийн аюулгүй байдлыг үргэлж хамгаалах бүх арга хэмжээг цаг тухайд авч хэрэгжүүлэх;
- Сурагчийн санаа зовнилыг сонсож, хариу өгөх; /ялангуяа тэд өөрсдөдөө болон өөр сурагчийн аюулгүй байдлын талаар санаа зовж байгаа бол/
- Бүх сурагчийн соёлын олон нийтийн оролцоо, чадавхыг дэмжих;
- Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх аливаа гомдлыг сургуулийн удирдлагын багт шуурхай мэдээлэхийн зэрэгцээ аливаа гомдлыг муж бүрийн цагдаа, хүүхэд хамгааллын агентлагт мэдээлсэн эсэхийг баталгаажуулах;
- Хүүхдийн аюулгүй байдлын талаарх аливаа асуудлыг сургуулийн удирдлагын багт мэдээлэх;
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн гэх мэдээлэл гарвал сурагч аюулгүй байгаа эсэхийг аль болох хурдан шалгах;
- Сурагчдын дунд үүсээд байгаа асуудлууд дээр анхаарал хандуулах;
- Үүрэг хариуцлагаа үнэнч шударгаар хамгийн сайнаараа гүйцэтгэх;
- Үйл ажиллагааны болон ажилтнуудтай холбоотой сургуулийн бүх бодлого, журмыг дагаж мөрдөх;
- Хүн бүртэй дарамт шахалтгүйгээр хүндэтгэлтэй, эелдэг харьцах;
- Хүүхэд залуучууд, гэр бүл, ажилчид, сайн дурынхны хувийн нууцыг чандлан хамгаалах;
- Холбогдох дүрэм, журам, байгууллагын бодлого, хүүхэд хамгааллын болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах.

Сургуулийн ажилтнууд, зочид, дадлагажигч оюутан болон сайн дурын ажилтнуудад дараах зүйлсийг хориглоно:

- Сурагчидтай аливаа "онцгой" харилцаа үүсгэх;
- Сурагчдын бие махбодтой холбоотой зан үйл, үйлдэл үзүүлэх;
- Сурагчдыг хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулах;
- Сурагчдыг насанд хүрэгчдийн шинж чанартай нээлттэй хэлэлцүүлэгт оролцуулах;
- Сурагчдын дэргэд зохисгүй үг хэллэг хэрэглэх;
- Сурагчдын дэргэд соёл, арьс өнгө, бэлгийн чиг баримжаа, бэлгийн амьдралын талаарх хувийн үзэл бодлоо илэрхийлэх;
- Аливаа сурагчийг ялгаварлан гадуурхах;
- Сурагчид эсхүл тэдний гэр бүлтэй цахим харилцаа холбоо үүсгэх (мэйл бичих, сошиал медиа дээр найз болох гэх мэт);
- Сэжигтэй эсхүл нийтэд ил болсон хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тоомсорлох

36 ЕБС-ийн ёс зүйн кодекс ба сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн хариу арга хэмжээний талаарх бусад орны туршлага, Парламентын судалгааны хүрээлэн, 2022 он

37 <https://www.taiwaneseschool.com.au/child-safety-code-of-conduct> Мельбурн дахь Тайваний сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм. 2021

САЙН ТУРШЛАГА: СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ СУРГУУЛЬ БҮХЭЛДЭЭ АРГА ХЭМЖЭЭ, ФИНЛЯНД³⁸

Финландын Боловсролын хуульд заасны дагуу боловсрол олгогч байгууллагууд нь сурагчдын аюулгүй орчин нөхцөлд суралцах эрхийг хангах үүднээс өөрийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан сурагчдыг хүчирхийлэл, дээрэлхэлт, дарамтлалтаас хамгаалах төлөвлөгөөг гарган, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Тэрхүү төлөвлөгөө нь хот тус бүрт харилцан адилгүй ялгаатай байхыг зөвшөөрөх боловч Финландын бүх суурь боловсролын сургуулийн 90% гаруй хувь нь KiVa Сургуулийн дээрэлхэлтийн эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

KiVa дээрэлхэхийн эсрэг хөтөлбөр³⁹ гэж юу вэ?

Финландын Боловсролын яам нь 2006 онд Турку их сургуультай хамтран суурь боловсролын (1-9 анги) сургуулиудад зориулсан дээрэлхэлтийн эсрэг хөтөлбөрийг боловсруулах, тус хөтөлбөрийн эхэн үеийн үнэлгээг хийх гурван жилийн гэрээг байгуулжээ. Хөтөлбөрийг боловсруулахдаа эхнээс нь улс орон даяар хэрэгжүүлэх алсын хараатай зорилт тавьж, өргөн хүрээнд боловсруулахыг зорьсон байна.

Тус хөтөлбөрийг Турку их сургуулийн Сэтгэл судлалын тэнхим, Суралцахуйн судалгааны төвүүд хамтран боловсруулжээ. Төсөлд сэтгэл судлал, боловсрол, социологи, статистик зэрэг хэд хэдэн салбарын мэргэжилтнүүд оролцон ажиллажээ.⁴⁰ Хөтөлбөр нь Финландын ерөнхий боловсролын сургуулиудад 2009 оноос албан ёсоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2017 он гэхэд Финландын ерөнхий боловсролын сургуулиудын 50 гаруй хувь нь (1400 сургууль, түүний дотор 300000 орчим сурагч) хөтөлбөрт хамрагдсан. Одоогоор тус улсын боловсролын байгууллагуудын 90 гаруй хувь, гадаад улс орнуудад тухайлбал, Европын 10 гаруй оронд албан ёсоор амжилттай хэрэгжиж байна. Мөн хөтөлбөр нь англи, герман, франц, япон зэрэг хэд хэдэн хэлээр орчуулагджээ.

KiVa хөтөлбөрийн зорилго: Үе тэнгийнхний дээрэлхэх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэхэд сургуулиудад туслах, сургуулийн ажилтнуудыг үүнд оролцож таслан зогсоох үр дүнтэй стратегиар хангах, улмаар сургуулийн аюулгүй, суралцах таатай орчныг нэмэгдүүлэх.

Хөтөлбөрийн агуулга: Анги хамт олны дунд биеэ хэрхэн авч явах, бусадтай хэрхэн харилцах, зан харилцаа, бусдыг хүндэтгэх, ёс суртахууны асуудлыг хамардаг бөгөөд үүнийг 1, 4, 7-р ангиудад насны онцлогт нь тохируулан давтамжтайгаар хичээлээр дамжуулан заадаг. Дээрэлхэлтийн ноцтой тохиолдлуудыг таслан зогсоох арга хэмжээг тухайн сургуулийн KiVa багийнхан (3 хүртэлх гишүүнтэй баг) хэрэгжүүлдэг байна.

Хөтөлбөр нь хичээлээс гадна дээрэлхэлтийн хохирогч болон дээрэлхсэн хүүхдүүдтэй бүлгийн ярилцлага хийх, сургалт зохион байгуулах, хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх, гарын авлага, нэгж хичээлийн удирдамж боловсруулах, эцэг, эх, багш сурагчдад зориулсан товхимол гаргах, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх цахим сургалт зохион байгуулах, KiVa эрдэм шинжилгээний хурлыг жилд хоёр удаа зохион байгуулах, хэрэгжилтийг улам бүр сайжруулах зөвлөмж саналыг тогтмол хүргүүлэх, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зэрэг ажлуудыг хэрэгжүүлдэг байна.

Хөтөлбөрийг боловсруулсан Турку сургуулийн багийнхан KiVa хөтөлбөр нь онол, практикийн суурь сайтай тул Финландаас өөр бусад газруудад ч хэрэглэх боломжтой юм гэж дүгнэжээ.⁴¹ Мөн Хууль зүйн яамны дэмжлэгээр байгуулагдсан Гэмт хэргийн хохирогчийг дэмжих төв нь веб сайтдаа сургуулийн дээрэлхэлтэнд өртсөн хүүхдүүд, тэдний эцэг эх, төрөл садан, ойр дотны хүмүүс, хэн бүхэнд тусламж, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор RIKU чат онлайн үйлчилгээ нэвтрүүлсэн. Чат нь ажлын өдрүүдэд 9-15 цаг, Даваа гаригт 17:00-19:00 цагийн хооронд нээлттэй байдаг.⁴²

38 ЕБС-ийн ёс зүйн кодекс ба сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн хариу арга хэмжээний талаарх бусад орны туршлага, Парламенын судалгааны хүрээлэн, 2022 он

39 <https://eucpn.org/document/kiva-koulu-kiva-anti-bullying-program>

40 GP_ECPA_2009_FI_KiVaKoulu-3.pdf

41 <http://www.kivaprogram.net/>

42 <https://www.riku.fi/en/guides-and-instructions/what-to-do-in-school-bullying-situations/>

2.3 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ БОЛОН СУРАХУЙ

Урьдчилан сэргийлэлт нь бодлогын хүрээ боловсруулах үеэс эхлээд гэр бүлтэй хамтран ажиллах хүртэл бүхий л үе шатанд хөтөч болох стратеги юм. Боловсролын тогтолцоонд урьдчилан сэргийлэх ажлын тулгуур нь сургалтын агуулга болон түүнийг сурагчдад хүргэх арга хэлбэр буюу — **сурагчдад юуг, хэрхэн заах вэ** — гэдэг асуудал юм.

СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой стратегид дараахыг багтаана:

- Хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, жендэрийн тэгш байдлыг дэмжих сургалтын хөтөлбөрийн арга хандлагууд,
- СХЖСХ-ийг таньж, хариу арга хэмжээ авах мэдлэг, ур чадвар олгох сургалтыг багш, ажилтнуудад тогтмол орох,
- СХЖСХ-ийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан зохион байгуулах, аюулгүй, итгэл төрүүлэх орчин бүрдүүлэх

ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХАНДЛАГУУД

ЮНЕСКО-гийн Олон улсын боловсролын товчооны тодорхойлсноор *“сургалтын хөтөлбөр гэдэг бол суралцагчид юуг, хэзээ, хэрхэн сурах вэ гэсэн асуултын дагуу боловсруулагдсан, заах аргазүй, суралцахуй, үнэлгээний тогтолцоо бүхий мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухамсартай, системтэй сонголтын үр дүн юм”*⁴³ гэжээ.

Сургалтын хөтөлбөрийн арга хандлага нь маш чухал бөгөөд өсвөр, залуу үеийг хүчирхийлэл, жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаар асууж тодруулах, эргэлзэх, түүнийг эсэргүүцэх чадварыг боловсролоор дамжуулан олгосноор СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үндэс суурь болдог. Өсвөр үе, залуус хүчирхийлэл, дарамтын хэлбэрүүдийг, өөрсдийгөө хэрхэн хамгаалах, бусдад гэм хор учруулахгүй байх арга замуудыг мэддэг байх шаардлагатай.

Мөн тэдэнд жендэрийн талаарх эерэг ойлголт — эрэгтэйлэг болон эмэгтэйлэг байдал, түүнчлэн хүйсийн хоёрдмол бус илэрхийллийн хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх, ойлгох, олон янзат байдлыг хүндэтгэх сэтгэлгээг хөгжүүлэх боломж олгох нь чухал.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 7: СХЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХАНДЛАГЫГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ? — ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөлт	○ Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжих, урьдчилж төлөвлөхөд зориулж оролцогч талуудтай зөвлөлдөх, таниулахад цаг гаргах замаар ойлголтоо нэгтгэх, ○ Нөөц бололцоонд нийцсэн (ажиллах хүн, хүчний нөөц ур чадвар, материалын нөөц) үйл ажиллагааны төлөвлөлт хийх ○ Сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулахдаа нийгмийн хэм хэмжээ болон жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг шүүмжлэлтэйгээр авч үзэх чадвартай мэргэжилтнүүдийг оролцуулах, зөвлөгөө авах ○ Өмнөх хөтөлбөрт үнэлгээ хийх болон шинээр хийгдсэн судалгаа, нотолгоонд суурилан харьцуулалт хийх
-----------	--

43 “Дэлхийн иргэний боловсрол” бодлогын нөлөөллийн баримт бичиг, Боловсрол эвсэл, 2025 он
https://www.uih.mn/upload/sudalgaa/files/632_5465370.pdf

Агуулга	○ Сургалтын хөтөлбөр ба хэрэглэгдэхүүн нь суралцагсдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх (жишээ: ахлах ангийнханд зөрчил маргаан шийдвэрлэх, дотно харилцаа, хэлэлцээр хийх ур чадвар, харилцаа холбоо; өсвөр насныханд хүндлэл, сэтгэл хөдлөлийг ойлгох; бага насны хүүхдэд биеийн хил хязгаар болон хүрч болох болохгүй биеийн хэсэг гэх мэт) ○ Эрэгтэйлэг байдлын эерэг, олон талт байдлыг таниулах чиглэлээр хөвгүүд, эрэгтэйчүүдтэй хамтран ажиллах ○ Зөвшөөрөл болон хүндлэл бүхий харилцаа холбооны ач холбогдлыг онцлох ○ Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, дотно харилцааг эерэг, зүй зохистой аргаар бий болгох загваруудыг таниулах ○ СХЖСХ-ийн бүх хэлбэрийн тухай мэдээлэл багтаах (үүнд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, хомофоб, трансфоб дээрэлхэлт) ○ Хувь хүний үнэт зүйлс, гэр бүл, үе тэнгийнхний хэм хэмжээ, хүлээлт, бэлгийн зан үйл, эрүүл мэнд, эрхийн талаарх ойлголтыг хөндөх ○ СХЖСХ-тэй холбоотой хуулийн мэдээлэл болон хүчирхийллийн талаарх мэдээлэл, хариу үйлчилгээ авах, дэмжлэгийн тогтолцооны талаарх цогц мэдээлэл багтаах
Хэрэгжүүлэх	○ Суралцагчдыг идэвхтэй оролцуулж, дамжуулж буй мэдээллийг өөртөө шингээж, нэгтгэн дүгнэхэд тусалдаг, оролцоонд суурилсан сургалтын арга зүйг ашиглах ○ Олон нийтийг хамруулсан хандлага, арга зүйг хөгжүүлэх - нийгмийн хэм хэмжээг өөрчлөхөд чиглэсэн СХЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ○ Сургалтын хөтөлбөрийг цогцоор нь хэрэгжүүлэх чадвартай, урам зоригтой багш, сурган хүмүүжүүлэгчдийг сонгон авч, тэдэнд бэлгийн болон цогц боловсрол, амьдрах ухааны сургалтын агуулгыг хөтөлбөрт ашиглахыг уриалсан оролцоонд суурилсан арга зүйгээр чадавхжуулах сургалт явуулах
Хяналт	○ Сургалтын хөтөлбөрийг заавал турших, энэ үйл явцдаа суралцагчдаас тогтмол санал хүсэлт авах ○ Байнгын удирдлагаар хангах, өргөн хүрээнд харах зөвлөн туслах үйл ажиллагааг оруулах

Сургалтын сэдэлжүүлэх үйл явц болон бусад арга хандлагууд

Хичээлийн хөтөлбөрт **сэдэлжүүлэлт** нь сурагчдын сониуч байдлыг өдөөж, сургалтын үйл явцад анхаарлыг татах зорилготой сургалтын эхэнд хийх сонирхолтой үйл ажиллагаа юм. Энэ нь суралцагчдыг хичээлд татан оролцох сэдэл төрүүлдэг бөгөөд зарим тохиолдолд суралцагчид өөрсдийн сонирхол, сурах арга барилд тулгуурлан шинэ агуулгад хандах арга барилаа олоход нь тусалдаг.

Хүүхдүүдийн насанд тохирсон, бүх түвшний боловсролын шатанд хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, жендэрийн тэгш байдлыг дэмжих олон төрлийн сургалтын хөтөлбөрийн “сэдэл төрүүлэх” арга хандлагууд байдаг. Үүнд:

- Бэлгийн цогц боловсрол
- Амьдрах ухааны боловсрол
- Иргэний боловсрол
- Уур, сэтгэл хөдлөлөө удирдах арга
- Хөндлөнгөөс ажиглагчийн ур чадвар эзэмшүүлэх
- Эрүүл хосын харилцааг заах
- Дээрэлхэлтээс хамгаалах мэдлэг, чадвар олгох зэрэг. Эдгээрийг хослуулан хэрэгжүүлбэл үр дүнтэй.

Доорх хүснэгтэд СХЖСХ-ийг шийдвэрлэхэд тодорхой нөлөө үзүүлсэн, үнэлгээ хийгдсэн хөтөлбөрүүдийн жишээг оруулсан.

СХЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ХОЛБОГДОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОН ХИЧЭЭЛҮҮД

Сургалтын хөтөлбөр, хичээл	Агуулга, суралцахуйн зорилт	Хөтөлбөр, хичээлийн жишээ
Бэлгийн цогц боловсрол ⁴⁴	Хүүхэд, өсвөр насныхан бэлгийн болон нийгэм, хүмүүс хоорондын харилцааны талаар мэдээлэлтэй, эрүүл сонголт хийх ур чадвар эзэмшүүлэх, хүйс, жендэр, бэлгийн амьдрал, хосын харилцаа, хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголт, ур чадвар олгох, үнэт зүйлс төлөвшүүлэх зорилготой.	Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж (нотолгоонд суурилсан аргачлал) ⁴⁵ 8-19 нас хүртэлх хүүхэд, өсвөр насныханд чиглэсэн найман үндсэн сэдвийн хөтөлбөр байдаг бөгөөд тэдгээр нь бүгд чухал ач холбогдолтой, харилцан бие биеэ бататгасан, нэг нь нөгөөтэйгөө хоршин заахад зориулагдсан. Сэдвүүд нь олон удаа давтагдах бөгөөд улам бүр нарийн төвөгтэй болох ба спираль хөтөлбөрийн арга барил ашиглаж шинэ хичээл нь өмнөх хичээлээр сурч мэдсэн зүйлс дээр тулгуурлана. 1. Хүмүүс хоорондын харилцаа 2. Үнэт зүйлс, хүний эрх, соёл ба бэлгийн амьдрал 3. Жендэрийн тухай ойлголт 4. Хүчирхийлэл ба аюулгүй байдал 5. Эрүүл мэнд, сайн сайхан амьдрах чадвар 6. Хүний бие махбод ба хөгжил 7. Бэлгийн амьдрал ба бэлгийн зан үйл 8. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндсэн ухагдахуун тус бүр дотроо ээлжит хичээлийн агуулга, дасгал ажлаас бүрдэнэ. Хичээл бүр дээр сэдвийн дагуу үлгэр зохиох, самбар бүтээх, урлагийн бүтээл хийх эсвэл дүрд тоглох зэрэг холбогдох даалгавартай байж болно.
Амьдрах ур чадвар олгох	Өсвөр үеийнхэнд үе тэнгийнхэнтэйгээ эрүүл харилцаа тогтоох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүн хоорондын харилцаанд сурах, даван туулах механизм, нөхөрлөл, үе тэнгийнхнийхээ дарамт шахалт, шүүмжлэлийг хэрхэн зохицуулах, бүтээлч сэтгэлгээ, шийдвэр гаргах зэрэг амьдрах ур чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.	Н ба М хөтөлбөрүүд (Бразил улс, олон улсад түгэн дэлгэрсэн) Испани, Португал хэлний Н (hombres, homes – эрэгтэйчүүд) ба М (mujeres, mulheres эмэгтэйчүүд) үсгээр илэрхийлэгдсэн уг хөтөлбөр нь ижил хүйсийн болон эсрэг хүйсийн бүлгүүдэд аль алинд туршигдсан, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр үлгэр болохуйц нотолгоонд суурилсан сургалтын хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн аргачлал нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг/эх байх, асран хамгаалагч байх талаар болон бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ зэрэг бусад холбогдох асуудлуудыг цогцоор багтаасан. Суралцагч охид, хөвгүүд хэрхэн нийгэмшсэн талаараа эргэцүүлэн бодох, нийгэмшлийн эерэг ба сөрөг талуудыг авч үзэх, зарим сөрөг зан үйлийг өөрчлөхийн ач тусыг үнэлэхэд туслах зорилготой дүрд тоглох, оюуны довтолгоо хийх болон бусад идэвхтэй оролцооны дасгалуудыг багтаасан. Хөтөлбөрийг дэлхий даяар хэд хэдэн байршилд, хагас туршилтад суурилсан судалгаагаар үнэлсэн бөгөөд хөтөлбөрт хамрагдсан оролцогчдын жендэрийн тэгш байдлын талаарх хандлага, зан үйлд эерэг өөрчлөлт гарч, жендэрт суурилсан хүчирхийлэл буурсан байжээ.

44 Бэлгийн цогц боловсрол (БЦБ) гэж бэлгийн амьдралын танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, бие махбодын болон нийгмийн талуудыг сургалтын хөтөлбөрт суурилан сургах ба суралцах үйл явцыг хэлнэ. Энэ нь хүүхэд залуучуудыг дараах чиглэлээр чадавхжуулах мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлэх зорилготой: эрүүл мэнд, сайн сайхан байдал, нэр төр эрхэм чанараа таньж мэдэх; харилцан бие биеэ хүндэтгэсэн нийгмийн болон бэлгийн харилцааг бий болгох; хийж буй сонголт нь өөрийнх нь болон бусдын сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлөхийг анхаарах; амьдралынхаа туршид эрхээ хамгаалахын чухлыг ойлгох, эрхээ хамгаалах. (Бэлгийн цогц боловсролын олон улсын арга зүйн удирдамж, НҮБ, монгол хэлээр)

45 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000370842>

Үерхэл нөхөрлөл, хайр дурлал романтик харилцаа	Хосын дотно харилцаа, хайр дурлалын харилцаан дахь үл хүндлэл, хүчирхийллийн шинж тэмдгүүдийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, өсвөр үе, залууст эрүүл харилцааны ур чадварт суралцахад нь туслах зорилготой. Ихэвчлэн дунд сургуулийн ахлах ангийн сурагчид (14-18 насны) болон коллеж/их дээд сургуулийн оюутнууд (18+) руу чиглэдэг.	Дөрөв дэх Р (Канад улс) Дөрөв дэх Р хөтөлбөр нь хосын харилцааны мэдлэг, ур чадварыг унших, бичих, арифметикийн нэгэн адил заах боломжтой бөгөөд заах ёстой гэсэн байр суурьтай. Уг хөтөлбөрийг 8-12-р ангийн хүүхдүүдэд анги танхимд нь заадаг. 5 жилийн турш хийсэн Дөрөв дэх Р хөтөлбөрийн хяналт-үнэлгээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 14-15 насны 9-10р ангийн сурагчид хамрагдсан. Үр дүнд уг хөтөлбөрөөр хичээллэсэн сурагчид (ялангуяа хөвгүүд) зөвхөн эрүүл мэндийн хичээлд хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад 11-р ангийн төгсгөл гэхэд болзож буй хамтрагчийнхаа эсрэг хүчирхийлэл үйлдэх нь хамаагүй бага байгааг тогтоожээ.
Дээрэлхэлт болон хүчирхийллийн бусад хэлбэрүүд	Сурагчид дээрэлхэлтийг өдөр тутмын хэрүүл маргаан, зөрчлөөс хэрхэн ялгах, дээрэлхэх үйлдэлд ямар хариу үйлдэл үзүүлэх талаар суралцахад гадна өсвөр үе, залууст чиглэсэн түрэмгийллийн зан үйлийг удирдах, амьдрах ур чадварыг заахад тусалдаг.	Хоёр дахь алхам, АНУ Хоёр дахь алхам хөтөлбөрийг АНУ-ын 32000 гаруй сургуульд 8 сая гаруй сурагчид ашиглаж байна. Энэ хөтөлбөр нь өсвөр үе, залууст үе тэнгийнхний дарамт, мансууруулах бодис хэрэглэх болон дээрэлхэлт зэрэг нийтлэг бэрхшээлүүдийг тойрон гарахад тусалдаг, харилцаа холбоо, даван туулах чадвар, шийдвэр гаргах зэрэг амьдрах ухааны ур чадварыг заадаг (биечлэн болон цахим). Иллинойс, Канзас мужийн 36 дунд сургуулийн 6, 7-р ангийн (11-13 насны) 3600 гаруй сурагчдын дунд хоёр жилийн турш хөтөлбөрийг туршсан. Хөтөлбөрийн төгсгөлд Иллинойс мужийн сургуулиудын сурагчдын дунд хомофобиа хэллэгээр доромжлуулж хохирсон тухайгаа мэдээлэх байдал 56 хувиар, бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэх байдал 39 хувиар буурсан байсан бол Канзасын сургуулиудын үе тэнгийнхний дунд мэдэгдэхүйц ялгаа гараагүй.
Жендэрийн тэгш байдал	Сургалтын хөтөлбөрөөр дамжуулан 12-14 насны охид, хөвгүүдийг эрх тэгш холбоо харилцааг дэмжих, жендэрийн үүргийг тодорхойлсон нийгмийн хэм хэмжээнд шүүмжлэлтэй хандах, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох замаар жендэрийн тэгш байдлыг дэмжих санаачилга	Сургууль дахь жендэрийн тэгш байдлын хөдөлгөөн, Энэтхэг улс (GEMS) GEMS төслийг Энэтхэг улсын Гоа, Кота, Мумбай зэрэг хотуудад улсын сургуулиудад хэрэгжүүлсэн. Мумбай хотод 45 сургуульд бие даасан туршилтын төсөл болгон хэрэгжүүлсэн. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, дүрд тоглох, тоглоом ашиглан GEMS нь 6-р ангиасаа эхэлж, улсын сургуулиудад 12-14 насны охид, хөвгүүдтэй хоёр жилийн турш ажилласан. Туршилтын хөтөлбөрийн үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан сурагчдын хувьд дараах үр дүн харагдсан. Охид дээд боловсрол эзэмших, гэрлэлтийг хойшлуулах зэргийг дэмжиж байсан бол хөвгүүдийн хувьд эрэгтэйчүүд гэр орны ажилд хувь нэмрээ оруулахыг илүү их дэмжиж байсан. GEMS-ийн гол бүрэлдэхүүн хэсэг болох хүчирхийллийг бууруулах талаар сурагчдын зан үйл, хандлага, практикт холимог үр дүн харуулсан. Анхны туршилтын хөтөлбөр амжилттай хэрэгжсэний дараа GEMS аргачлалыг Мумбай хотын 250 сургууль, Вьетнамын 20 сургуульд нэвтрүүлсэн байна.

Гэрч буюу хөндлөнгөөс ажиглагчийн арга, хандлага нь хүчирхийлэлтэй нөхцөл байдлыг таних, ил тод дуу хоолойгоо хүргэх, эсвэл бусдыг хамтрахаар уриалах зэрэг зохистой, аюулгүй байдлаа хангахад чиглэсэн ур чадварт суралцах, дадлагажих үйл явцыг хамардаг.

Зарим тохиолдолд гэрч/оролцогчийн үйлдэл нь хүчирхийллийн бодит нөхцөл байдалд шууд оролцох зорилготой байдаг ч, сургуулийн орчинд хэрэгждэг ихэнх хөтөлбөрүүд нь хувь хүн болон үе тэнгийнхний хандлага, зан үйлийг өөрчлөхөд чиглэдэг. Ийм төрлийн сургалтууд ихэвчлэн эрэгтэйчүүдийн бүлэгт хандсан байдаг бөгөөд зарим тохиолдолд эмэгтэйчүүд болон холимог бүлэгт ч хэрэгжүүлдэг. Гэрч буюу хөндлөнгөөс идэвхгүй ажиглаж байдаг хүмүүст чиглэсэн хөтөлбөрүүдээс анги удирдсан багш нарт чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанууд илүү үр дүнтэй⁴⁶.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT) ашиглан хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, дарамтаас хамгаалах нь тэдэнд цахим орчин дахь дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэл, бусдын буруутай үйлдэлд хэрхэн хариу үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэхэд чухал үүрэгтэй.

Хүчирхийлэл үйлдэгчид ихэвчлэн сургуулийн орчин дахь хүчирхийллийг цахим орчин руу шилжүүлдэг бөгөөд СХЖСХ-ийн тохиолдлуудыг бичлэг, зураг хэлбэрээр баримтжуулж, цахимаар түгээх явдал улам бүр нэмэгдэж байна.

Сургуулиуд цахим дээрэлхэлтийг дараах стратегиудаар шийдвэрлэхийг зорьж байна:

- Сурагчдын санаачилсан дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээнүүд
- Эцэг эхчүүдэд зориулсан сургалт, уулзалт
- Тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөрүүд

Эдгээр нь цахим орчны эрсдэлээс хамгаалах болон цахим дахь СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн чухал алхмууд юм.

САЙН ТУРШЛАГА – КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АВСТРАЛИ УЛС

Өмнөд Австралийн Засгийн газар хүүхдүүдийг “хариуцлагатай дижитал иргэн” болгон төлөвшүүлэхэд чиглэсэн удирдамж, сургалтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд энэ нь “Цахимд холбогдсон дэлхий ертөнцөд хүүхдийг аюулгүй байлгах нь” (Cyber-Safety: Keeping Children Safe in a Connected World) нэртэй.

Уг хөтөлбөр нь хүүхдүүдийг интернет ашиглан мэдлэг олж авах, дэлхий ертөнцийг судлах боломжоор хангахын зэрэгцээ, интернэтийг ёс зүйтэй, хариуцлагатай ашиглах ур чадвар, цахим орчны эрсдэл, аюул заналын талаарх ойлголтыг эзэмшүүлэхэд чиглэдэг.

Тус кибер аюулгүй байдлын хөтөлбөр нь багш, сурагчдад цахим дээрэлхэлт болон цахим орчин дахь хүчирхийлэлд хэрхэн хариу үзүүлэх талаар тодорхой, ойлгомжтой зааварчилгаа өгдөг. Энэ хөтөлбөр нь мөн “Аюулгүй байдалдаа анхаарах нь: Хүүхэд хамгааллын сургалтын хөтөлбөр” (Keeping Safe: Child Protection Curriculum – KS:CPC) хэмээх амьдрах ухаанд суурилсан өргөн цар хүрээтэй сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд цэцэрлэгийн наснаас эхлэн 12-р анги хүртэлх хүүхдүүдэд дараах чухал чадваруудыг олгодог. Үүнд,

- өөрийгөө аюулгүй байлгах арга зам
- хүчирхийлэл, дарамтыг хэрхэн таних
- итгэж болох насанд хүрсэн хүнд мэдээлэх
- хүрч болон хүрч болохгүй биеийн хэсэг, хил хязгаар, хүлээн зөвшөөрч болох болохгүй зан байдлыг ялгаж таних

Энэ хөтөлбөр нь хүүхдүүдийг зөв мэдээлэлтэй, аюулгүй, хариуцлагатай интернэт хэрэглэгч болгон төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

⁴⁶ Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь (сурах бичиг), ННФ, 2017 он

Энх тайван ба иргэний боловсролоор дамжуулан энх тайван, тэгш байдал, хүлээцтэй байдал, нийгмийн эв нэгдлийн зарчмуудыг ойлгох, суралцах нь СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ялгаатай байдлыг — тэр дундаа жендэрийн өнцгөөс — хүлээн зөвшөөрч, үнэлэн дэмжих, мөн хүчирхийллээс зайлсхийх, уур бухимдлаа зөв удирдах арга барил заах замаар боловсрол нь хүчирхийллийг бууруулахад шийдвэрлэх үүрэгтэй.

САЙН ТУРШЛАГА: ЭРТНИЙ ХЯТАДЫН ХӨЛӨГТ ТОГЛООМООР ДАМЖУУЛАН ЭНХ ТАЙВНЫГ ЦОГЦЛОХ НЬ, ВЕНЕСУЭЛ УЛС



Венесуэл улсын Миранда хотын нэгэн сургуулийнхан эерэг сахилга бат, шүүн тунгаах сэтгэлгээ эргэцүүлэлт чадварыг хөгжүүлэх замаар энх тайвныг дэмжих, хүчирхийллийг бууруулах зорилгоор эртний Хятадын хөлөгт тоглоомыг ашиглажээ. Уг төсөл нь 4-р ангийн 15-20 сурагчтай жижиг багаар хэрэгждэг. Багш нар сурагчдын сайн зан үйлийг таньж, бусдыг үл хүндэтгэсэн эсвэл түрэмгий зан авир гаргавал шийтгэхийн тулд эерэг сахилга бат тогтоох аргаар хөлөгт тоглоомыг ашиглажээ.

Уг тоглоом нь боловсролын хэрэглэгдэхүүн болох боломжтой учраас сонгогдсон аж. Энэ нь тоглогчийг шийдвэр гаргахын

өмнө олон янзын үзэл бодлыг эргэцүүлэн бодоход сургаж, бусдыг хүлээн зөвшөөрөх, ойлгоход тусалдаг. Урт хугацааны туршид энэхүү хөлөгт тоглоомыг тоглосон охид, хөвгүүдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, тэсвэр тэвчээр, сэтгэн бодох, эргэцүүлэн бодох чадвар, багт хэм хэмжээ тогтоох, бие биенээ хүндэтгэх чадвар нэмэгдсэнээс гадна сургуулийн гүйцэтгэл сайжирч буйг илтгэсэн⁴⁷.

СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БА БАГШИЙН СУРГАЛТ

Сургалтын арга зүй гэдэг нь сургалтын агуулгыг сурагчдад хэрхэн хүргэх тухай ойлголт бөгөөд үүнд хүүхэд бүрийг сургалтын үйл явцад идэвхтэй оролцуулах, үр дүнтэй суралцахад нь туслах төрөл бүрийн арга, аргачлалыг ашиглах явдал багтдаг. Учир нь хүн бүрийн суралцах үйл явц өөр гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Арга зүйн сургалтыг багш бэлтгэх сургуулиудын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаа болон багшаар ажиллах явцад ажлын байран дээр нь олгох, мөн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах зорилгоор бусад олон хэлбэрээр олгож болдог.

СХЖСХ (сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл)-тэй багшийн сургалт, сургалтын арга зүй онцгой ач холбогдолтой. Учир нь хүүхдүүд юу сурах, яаж сурах нь тэдний сургуулийн орчин дахь өдөр тутмын туршлагатай шууд холбоотой.

Хүчирхийлэлтэй тэмцэхийн тулд багш анги доторх олон талт харилцаа, ялгаатай хэрэгцээ- жендэр, эрх мэдэл, арьс, үндэс угсааны динамик болон өөрсдийн өрөөсгөл хандлага, зан үйлийг илүү сайн ухамсарлах шаардлагатай болдог.

Фрейрегийн зарчимд (Freire) тулгуурлан боловсруулсан тэгш хүртээмжтэй боловсролын зорилгуудын нэг нь **“далд хөтөлбөр”** буюу сурагчид өөрсдийн эргэн тойронд буй инстүүцийн бүтэц, хүмүүс хоорондын харилцаа, тогтолцоогоос сурдаг хандлага, үнэт зүйлс, хэм хэмжээг ил болгож, тэдгээрт шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийх чадварыг хүүхдүүдэд заах явдал юм.

Багш нарын арга зүй нь тэгш байдлыг үлгэрлэх ёстой. Энэ нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан охид, хөвгүүдэд эрх тэгш хүндлэлтэй хандахыг сургахын тулд жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид, үл ялгаварласан сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн ашиглан сурагч бүрийн олон янзат байдлыг эерэгээр тусгахыг хэлнэ.

⁴⁷ Red de Innovaciones Educativas, 2013

Сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр сайн аргачлалууд олон байдаг ч эдгээрийг системтэйгээр хэрэгжүүлсэн тохиолдол ховор. Ихэнх тохиолдолд багш нарын нөөц хязгаарлагдмал, сургуулийн захирал зэрэг албан тушаалтнууд эдгээр аргыг хэрэгжүүлэх нь өндөр зардалтай, төвөгтэй, цаг их шаарддаг хэмээн үздэгээс үүдэлтэй.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 8: ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ, ЭЕРЭГ ЭРЭГТЭЙЛЭГ БАЙДЛЫГ ЗААХ НЬ

One Man Can Action Toolkit (Sonke, 2012) нь багш нар эрэгтэйчүүд, хөвгүүдийг эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг зогсооход илүү идэвхтэй, хариуцлагатай оролцогч болгоход чиглэсэн дараах үндсэн санаануудыг санал болгодог. Үүнд,

1. Сурагчдад хүчирхийлэл хэрхэн нөлөөлж буйг ойлгох
2. Бие махбодын болон сэтгэл зүйн хувьд аюулгүй сургуулийн орчныг бүрдүүлэх
3. "Эр хүн байх" гэдэг нь юу гэсэн утгатай болох, үүнд нийгмийн хэвшмэл ойлголт, дарамт нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрч, энэ талаарх өөрийн байр суурийг тодорхой илэрхийлэх
4. Хүндэтгэл, шударга байдлыг үлгэрлэн үзүүлэх
5. Сурагчдыг бие биенээ дэмжихийг уриалах
6. Эцэг эхчүүдийг тэгш хамруулж, сургах
7. Хүчирхийлэлгүй, эерэг харилцааны чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн дэмжлэгийг авах
8. Сурагчид, эцэг эх, асран хамгаалагчид, хамтран ажиллагч багш нартаа хүчирхийлэлгүй, эерэг харилцааны талаарх сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг түгээх, хамтран ажиллах
9. Эрүүл, хүндэтгэлтэй хосын харилцааны талаар болон хүчирхийллийн бус аргуудын тухай заах

Сургалтын хөтөлбөрийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд багш нар жендэрийн асуудалтай нүүр тулах, хөвгүүд, охидын хоорондын эрх мэдлийн тэгш бус харьцааг ойлгож шийдвэрлэх чадвартай байх шаардлагатай. Ялангуяа, уламжлалт хоёр (эрэгтэй/эмэгтэй) хүйсийн илэрхийллээс өөрөөр өөрсдийгөө илэрхийлдэг хүүхдүүдийн эрх, оролцоог ойлгож, хамгаалах шаардлагатай. Энэ нь зөвхөн жендэрийн ялгаварлалаас зайлсхийх бус, жендэрийн хэм хэмжээ, хүлээлт, ЛГБТИК+ хүүхдүүдэд тулгардаг дарамт, ялгаварлалыг ойлгох, нийгмийн болон жендэрийн ялгаварлан гадуурхалтыг таньж, багасгах оролдлого хийхтэй холбоотой хүчин чармайлт юм. Хамгийн чухал нь ийм үзэгдлийг анги танхимдаа үл тэвчих, дахин давтагдахгүй байхад анхаарах нь чухал.

Багш нарт мөн хүндлэлд суурилсан, хүчирхийлэлгүй, үр дүнтэй анги удирдах ур чадварыг эзэмшүүлэх хэрэгтэй. Харамсалтай нь, олон анги танхимд **бие махбодын шийтгэл** болон сахилга баттай холбоотой арга барил нь жендэрт суурилсан хүчирхийллийн үндэс болж байна. Бие махбодын шийтгэл нь дэлхий даяарх сургуулиудад өргөнөөр тохиолддог хүчирхийллийн хэлбэрийн нэг бөгөөд анх хүйс харгалзахгүй ойлголтоор авч үзэж байсан ч, бодит байдал дээр жендэртэй нягт холбоотой байна. Сургуулийн сахилга, шийтгэл нь ихэнхдээ хөвгүүд, охидод нийгмийн хүлээлт болсон зан үйлийг улам баталгаажуулах, жендэрийн хэвшмэл ойлголт, үүргийг албадсан байдлаар хэрэгждэгээрээ асар хортой.

Мөн багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, хэм хэмжээ, хүлээлт нь тэдний өөрсдийнх нь амьдралын туршлага, үнэт зүйл, хандлагад гүн бат суусан байдаг учир тэдний ажилдаа хэрхэн хандах, сурагчидтайгаа хэрхэн харилцахад шууд нөлөө үзүүлдэг. Тиймээс багш руу чиглэсэн сургалтаар дамжуулан үүнийг өөрчлөх боломжтой. Ийм төрлийн сургалт нь багш нарт өөрсдийнх нь жендэрийн ойлголт сурагчдын хоорондын үл ойлголцол, ялгаварлал, улмаар жендэрт суурилсан хүчирхийллийн хөрсийг бүрдүүлж буйг ухамсарлахад тусална.

Тиймээс багш нарт **эерэг, дэмжих сахилгын аргуудыг** зааж өгөх хэрэгтэй. Энэ нь зөвхөн буруу үйлдлийг шийтгэх бус, зөв үйлдлийг урамшуулж, анги дотор сайн зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Багш нар сурагчидтайгаа хамт эерэг дүрэм, хүлээлтүүдийг хамтран боловсруулдаг бөгөөд сөрөг зан үйлийн үед хэрэглэгдэх арга хэмжээ нь сурагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, шийтгэх бус, тэдэнд суралцах боломж олгох зорилгод чиглэсэн байх ёстой.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 9: ЭЕРЭГ САХИЛГЫН АРГЫГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

ШАТАЛСАН ҮР ДАГАВАР

1. Сэтгэл зүйч/Зөвлөх рүү холбон зуучлах
2. Сургуулийн захиргаа/оффис руу холбон зуучлах
3. Тусдаа ангид 10-14 хоногийн хугацаанд хичээллүүлэх
4. Эцэг эхтэй нь уулзах
5. Зан төлөвийн гэрээ байгуулах
6. Зарим нэг үйл ажиллагаанд оролцох эрхийг хасаг (өөрийн нь дуртай)
7. Сургууль дээр нийтэд тустай ажил хийлгэх
8. Зохистой зан төлвийн талаар эссе бичих даалгавар өгөх

Шатлал 4: Маш ноцтой

Заавал гэр
лүү нь утасдах

1. Суудлыг солих
2. Ширээн дээр нь нийгмийн ажилтан руу холбон зуулах анхааруулга байрлуулах
3. Хичээлийн дараа авч үлдэн хичээл даалгавар хийлгэх
4. Зохист зан үйлийг давтуулах
5. Оноо, шагналыг өгөхгүй байх
6. Зарим нэг үйл ажиллагаанд оролцох эрхийг түр хасах
7. Өөрийн үйлдлээ эргэцүүлэх хуудас бөглүүлэх
8. Өөр газар хичээлийг хийлгэхээр ангиас гаргах

Шатлал 3: Дунд зэрэг

Зарим
тохиолдолд
гэр лүү нь
утасдах

1. Суудлыг түр сольж суулгах
2. Ганцаарчлан ярилцах
3. Түр завсарлага авах (өөр өрөөнд, коридорт)
4. Картны өнгийг солих
5. Сатааруулах (ус уулгах гэх мэт)
6. Туслах багшийн дэмжлэг авах

Шатлал 2: Бага зэрэг

Цөөн
тохиолдолд
гэр лүү нь
утасдах

1. Багш тухайн үйлдлийг дэмжихгүй байгаагаа харуулах
2. Ойртож очин хажууд нь зогсох
3. Гараараа дохио өгөх (сонс, төвлөр, ажигла гэх мэтээр)
4. Сурагчийг нэрээр нь дуудах
5. Хананд өлгөөтэй Ангийн дүрэм рүү заах
6. Хичээл даалгавраа гүйцэтгэж байгаа сурагчдыг дурдан ярих
7. Анги хамт олонд нийтэд нь Ангийн дүрмийг чангаар уншиж өгөх
8. Үгээр чиглүүлэх (зохисгүй аашлахаа боль гэх эсвэл зөв зохистой зан үйлийг хэлэх)
9. Сурагчаас гүйцэтгэж байгаа даалгаврын талаар асуулт асуух

Шатлал 1: Аядуу

Иймээс багш нарын сургалтын хөтөлбөр нь жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголт, жендэрийн ялгаварлан гадуурхлын суурь шалтгаан болох эрх мэдлийн динамиктай нь өргөн хүрээнд авч үзэж, СХЖСХ нь эрх мэдлийг тэгш бус байдлаас үүдсэн ялгаварлан гадуурхалт болохыг ухамсарлуулах, таних, урьдчилан сэргийлэх ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэх ёстой.

Багш нар болон сургуулийн ажилтан бүгд байгууллагынхаа ёс зүйн дүрэм-тэй танилцсан, ухаж ойлгосон байх, мөн хүчирхийлэлд өртсөн, гэрч болсон эсвэл хүчирхийлэл үйлдэж буй сурагчидтай хэрхэн зүй зохистой харьцах талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

Багш бэлтгэх болон ажлын байранд нь мэргэшүүлэх сургалтын чанарыг сайжруулж, багш нарт олон төрлийн анги танхимыг удирдах, зөрчилдөөн, ялгаварлан гадуурхал, арьс өнгө, үндэс угсаа, бэлгийн чиг баримжааны эсрэг үзэл зэргийг шийдвэрлэхэд хэрэгтэй хатуу (мэдлэг ойлголт, арга зүй) болон зөөлөн (харилцаа, хандлага, мэдрэмж) ур чадварууд-ыг олгох ёстой.

Багш нарын заах арга нь илүү харилцан үйлдэлтэй, хүүхдэд ээлтэй, идэвхтэй сургалтын аргаар оролцоог дэмжсэн байх хэрэгтэй бөгөөд үүнийг багш бэлтгэх хөтөлбөрөөр дамжуулан зааж өгөх нь маш чухал. Энэ шатанд сахилга бат тогтоох, анги танхимын менежмент, хичээл заах арга зүй багтдаг бөгөөд суралцахуйн түгээмэл загварууд, хүүхдийг багшлахуйн төвд тавьсан арга зүйг оюутнуудад заах нь чухал.

Харамсалтай нь багш бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд зөвхөн хичээлийн агуулгад төвлөрч, урьдчилан бэлдсэн хичээлийн төлөвлөгөө, зааварчилгаа ашигласнаар хүүхэд төвтэй, суралцахуйн идэвхтэй оролцоог дэмжсэн арга зүйг гүнзгий хөгжүүлэх боломж олгодоггүй. Тиймээс сургалтын хөтөлбөрийн нийцтэй байдал, уян хатан, уялдаа холбоо зайлшгүй шаардлагатай.

Судалгаагаар багш бэлтгэх сургуулиудын соёл, хандлага нь эрхмэдлийн тэгш бус байдал, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалыг дамжуулдаг болох нь тогтоогдсон. Жишээлбэл, багшийн коллежүүдэд эмэгтэй ажилтан, оюутнуудын эсрэг бэлгийн дарамт түгээмэл байдаг нь тогтоогдсон⁴⁸. Иймээс гомдол мэдээлэх механизм, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоо нь их дээд сургуулиуд, мэргэжлийн сургалтын байгууллагуудад ч мөн адил хэрэгжих шаардлагатай.

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн хувирган өөрчлөх агуулга багтсан байх ёстой. Энэ нь сургуулийн орчин дахь жендэрт суурилсан ялгаварлалыг хэрхэн илрүүлж, сорьж, өөрчилж болох талаар багш нарт ойлголт өгөхөд тусалдаг. Багш нар болон сургуулийн удирдлагуудын амьдралын түүх, итгэл үнэмшил, хувийн туршлага нь СХЖСХ болон жендэрийн ялгаварлалыг хэрхэн ойлгодогт нь шууд нөлөөлдөг тул эдгээрийг судалгаа, сургалтын суурь болгон ашиглаж болно.

Мэргэжлийн хөгжлийн сургалт нь багш нарыг дараах асуултуудын талаар өөртэйгээ болон хамт олонтойгоо нээлттэй ярилцахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд:

- Би эмэгтэй/эрэгтэй хүний хувьд ямар амьдралын туршлага туулсан бэ?
- Би жендэрийн талаар сурагчдадаа юуг, яаж зааж үлгэрлэдэг вэ?
- Би сурагч охид, хөвгүүдтэй болон эмэгтэй/эрэгтэй хамтран ажиллагсадтайгаа хэрхэн харилцдаг вэ? Ялгаатай харилцаж байна уу?

Ийм эргэцүүлэлт сургалт нь багш нарыг жендэрийн мэдрэмжтэй, хүчирхийлэлгүй, тэгш боломж бүхий сургалтын орчин бүрдүүлэхэд чиглүүлж чадна.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН МОДУЛЬ

Хүүхэд, өсвөр үе, залуучуудын талаарх хандлага	○ Би сурагчдадаа ямар хандлага гаргадаг вэ? ○ Үлгэр жишээ багшийн шинж чанарууд
Жендэр	○ Жендэрийн талаарх цогц ойлголт, ялангуяа бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл ○ Жендэр, боловсрол ба анги танхим ○ Нийгмийн болон жендэрийн хэвшмэл ойлголт, хэм хэмжээ, хүлээлтүүд ○ Соёл, нийгмийн өөрчлөлтийг ойлгох нь
Хүчирхийлэл ба СХЖСХ	○ Хүчирхийлэл болон СХЖСХ-ийн тодорхойлох ○ Эрх мэдэл, хүч хэрэглэлт болон зөвшөөрөл ○ СХЖСХ-ийн тохиолдолд гэрч болбол яах вэ? ○ Жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн хэм хэмжээ ба ХДХВ/ДОХ

48 Bakari and Leach, 2007

Хүний эрх	- o Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт - o Хүүхдийн эрхийн тухай конвенц - o Хүүхдийн эрхийг хамгаалах нь хэний хариуцлага вэ?
Аюулгүй, дэмжлэгтэй анги танхим бүрдүүлэх	- o Хүмүүжлийн эерэг арга - o Анги танхимын менежмент
Хариу арга хэмжээ – дэмжлэг, шилжүүлэх ба мэдээлэх	- o “Хариу арга хэмжээ” гэж юуг хэлдэг вэ? - o Сурагчдад шууд дэмжлэг үзүүлэх - o Багшийн ёс зүйн дүрмийг ашиглан СХЖСХ-тэй тэмцэх - o Хууль эрхзүйн тогтолцоог ашиглан СХЖСХ-тэй тэмцэх

САЙН ТУРШЛАГА: “DOORWAYS III” БАГШИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА: СХЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БА ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, ГАНА, БОЛОН МАЛАВИ УЛС

АНУ-ын USAID-аас санхүүжүүлсэн “Аюулгүй сургууль” хөтөлбөрийн таван жилийн хүрээнд (2003–2008) хэрэгжсэн Doorways сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгон багш нарт зориулсан сургалтын гарын авлагыг боловсруулсан. Энэхүү гарын авлага нь багш нарыг бүх сурагчдад зориулсан аюулгүй сургалтын орчинг бүрдүүлэх хандлага, арга зүйг дэмжих замаар СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилготой.

Багшийн сургалтыг сурагчид болон орон нутгийн зөвлөхүүдэд зориулсан сургалт, мөн дараах нэмэлт үйл ажиллагаануудтай хослуулан хэрэгжүүлсэн. Үүнд:

- o Радио, подкаст хөтөлбөрүүд
- o Жүжигчилсэн тоглолт
- o Жендэрийн клубууд
- o Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
- o Сургуулийн уулзалт, цугларалтууд орно.

2009 онд Гана, Малави улсад 400 багшийн дунд суурь болон эцсийн шатны судалгаанд үндэслэн хийсэн үнэлгээгээр (DevTech, 2008) жендэрийн хэвшмэл ойлголт, СХЖСХ болон анги танхимын практикийн талаар багш нарын хандлагад хэд хэдэн эерэг өөрчлөлт гарсныг тогтоосон. Жишээлбэл:

- o Гана улсад охид сургуулийн орчинд бэлгийн дарамтад өртөж болно гэж үзсэн багш нарын хувь 30 хувиас бараг 80 хувь болж өссөн. Үүнтэй адил хөвгүүд ч бэлгийн дарамтад өртөж болно гэж үзсэн багш нарын хувь нэмэгдсэн.
- o Бие махбодын шийтгэлийн талаарх багш нарын хандлагад өөрчлөлт гарсан бөгөөд хоёр улсад хоёуланд нь “хөвгүүдэд сахилга тогтооход ташуурдах нь зохисгүй” гэж үзсэн багш нарын хувь 20–30 - аар нэмэгджээ.

Гэсэн хэдий ч энэхүү хандлагын өөрчлөлт нь багш нарын зан үйлд бүрэн нөлөөлж амжаагүй байлаа. Судалгаагаар Гана улсад багш нарын гуравны хоёр нь, Малавид 14 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд сурагчдадаа ташуур хэрэглэсэн гэж хариулжээ.

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ ОРЧИН

Аюулгүй орчин гэдэг нь өсвөр үе, залуус бие махбодын болон сэтгэл зүйн хувьд аюулгүй, тайван, эрх чөлөөтэй байна гэж мэдэрдэг газар, орон зай эсвэл бүлгийг хэлнэ.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь сурагчдын албан ёсны хичээлээс тусдаа боловч түүний үр нөлөөг дэмждэг, амьдрах ухааны ур чадваруудыг хөгжүүлэх сургалт, бусад арга хэмжээнүүд юм. Эдгээр нь СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд маш чухал боловч ихэнхдээ албан ёсны сургалтын хөтөлбөрт орхигддог.

Сургууль дээрх клубууд болон бусад төрлийн аюулгүй орчин нь СХЖСХ-ийг шийдвэрлэх чухал эхлэл, нэвтрэх цэг болж чаддаг. Ихэнх тохиолдолд хөвгүүд, охидын оролцоог тус тусад нь хангаж, тэдэнд өөрийнхөөрөө чөлөөтэй байх, өөрийгөө илэрхийлэх, итгэлтэй байх, хүчирхийлэл ба тэгш бус байдлыг ойлгож, шийдвэрлэх мэдлэг, хандлага, чадвараа хөгжүүлэх орон зай олгодог.

Аюулгүй орчин нь хүүхэд, залууст өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, эмзэг сэдвээр асуулт асуух, шүүмжлэлээс айлгүй орших боломж олгодог итгэлтэй орчин байх ёстой. Эдгээр орчныг тодорхой зорилгоор нарийн төлөвлөж, зорилтот бүлэгт чиглүүлэн зохион байгуулах нь чухал. Жишээлбэл: ActionAid ТББ-аас Гана, Кени, Мозамбикт хэрэгжүүлсэн **“Сургуулийн орчин дахь охидын эсрэг хүчирхийллийг таслан зогсоох” (SVAGS)** санаачилгад охидыг чадавхжуулах зорилготой клуб байгуулж, охидыг хүчирхийлэл, түүнийг хэрхэн таньж, даван туулах тухай мэдлэгээр хангаж, хоорондоо ярилцах, бие биенээ дэмжих аюулгүй орчныг бүрдүүлсэн.

Эдгээр клубууд нь мэтгэлцээн, жүжиг, зуслангийн үйл ажиллагаа, орон нутагтай танилцах аялал зэрэг олон нийтийн арга хэмжээг ашиглан хүчирхийлэл болон түүнтэй тэмцэх арга замын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлдэг байв. Зарим сургуульд охидын клубын удирдагч, менторууд охидод албан бус зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг байсан.

SVAGS хөтөлбөрийн суурь судалгаагаар охидын эрхийг хангах зорилгод хүрэхийн тулд **хөвгүүдтэй ч мөн ажиллах хэрэгцээ** шаардлага байгаа нь тодорхой болсон. Үүний үр дүнд хөвгүүдийн клуб байгуулж, Мозамбик улсад хөвгүүдийг жендэрийн клубт хамруулах арга хэмжээ⁴⁹ авч эхэлсэн.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь ихэвчлэн хүүхдийн ур чадварыг хөгжүүлэх, аюулгүй орчин бүрдүүлэхэд төвлөрдөг бөгөөл мэтгэлцээн, жүжиг, спортын арга хэмжээнүүдийг гол нэвтрэх цэг болгодог. Эдгээр нь заримдаа сонголт бага, оролцоо хязгаарлагдмал байж болох бөгөөд **хамгийн үр дүнтэй хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь бүхэл бүтэн сургуулийн оролцоог дэмжиж, тогтолцооны болон соёлын түвшний өөрчлөлтөд хүргэх гүүр болдог.**

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 10: АЮУЛГҮЙ ОРЧИНГ ХЭРХЭН БҮРДҮҮЛЭХ ВЭ?
○ Бие махбодын болон сэтгэлзүйн хувьд аюулгүй, нууцлал хангасан, хялбар хүрч болохуйц, тухайн хөтөлбөртэй холбоогүй хүмүүс эсвэл дэмждэггүй удирдах албан тушаалтнуудын хөндлөнгийн оролцоонд өртөхгүй байршлыг сонгох ○ Уулзалтуудыг долоо хоног бүр тогтсон цаг, газарт тогтмол зохион байгуулах ○ Хүүхэд, залуучуудад манлайлах боломж олгож, тэднийг дотоод зохион байгуулалт, хөтөлбөрийн хэрэгжилтэд идэвхтэй оролцуулах
ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 11: СХЖСХ-ИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?
○ Сургуулийн дотоод бүтэц болон орон нутгийн өргөн хүрээний хамтын ажиллагааг бэхжүүлэх Хичээлээс гадуурх үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, сургуулийн бүхий л үйл ажиллагаа, соёлтой уялдуулсан байдлаар зохион байгуулах нь клубүүдийг “онцгой бүлэг” мэт харагдахаас сэргийлж, үр нөлөөг өргөжүүлдэг. ○ Менторууд болон дасгалжуулагчид (багш, ажилтан, сайн дурынхан) нь сурагчдын хандлага, зан үйлийг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй. Ялангуяа, нас ойролцоо, ижил хүйсийн, төстэй нийгэм-эдийн засгийн нөхцөлтэй менторууд нь сурагчдын хувьд эерэг үлгэр дуурайлал болж чаддаг.

⁴⁹ Parkes and Heslop, 2011, 2013

- Охидын клубтэй зэрэгцэн хөвгүүдэд зориулсан клуб байгуулах нь СХЖСХ-ийн талаарх хөвгүүдийн туршлага, хандлагыг хэлэлцэх, “эр хүн байх” гэж юу гэсэн утгатай, энэ нь СХЖСХ-тэй хэрхэн холбоотой болохыг ойлгоход тусалдаг. Мөн энэ нь зарим үед ажиглагдсан хөвгүүд охидын үйл ажиллагаанд саад болох, сатааруулах оролдлого хийхээс сэргийлэх ач холбогдолтой⁵⁰.
- Амьдрах ухааны ур чадваруудын бусад үйл ажиллагаануудтай холбох, ялангуяа спорт, нийгэм-эдийн засгийн эрхмэдэлжих зэргийг хослуулсан сургалтын хөтөлбөрүүд нь хичээлээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд өөр орчинд эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл (VAWG)-тэй тэмцэх, жендэрийн тэгш харилцааг дэмжих үр дүнтэй, идэвхтэй арга хэлбэр болж чадна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁵⁰ Plan Uganda төслийн жишээ, Leach et al., 2013

2.4 ХАРИУ ҮЙЛДЭЛ: СУРГУУЛИЙН ГАДНА БОЛОН ДОТОРХ ОРЧИНД

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа тохиолдолд энэ талаар мэдээлэх, хохирогчдод туслах, хэргийг холбогдох байгууллагад шилжүүлэх тодорхой, аюулгүй, тэгш хүртээмжтэй журам, механизмтай байх ёстой. Үндсэн стратеги:

- Ойлгоход хялбар, хүртээмжтэй, хүүхдэд ээлтэй, нууцлал бүхий, мэдээлэл өгөх тогтолцоогоор хангах
- Зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх
- Хууль сахиулах болон эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх

МЭДЭЭЛЭХ МЕХАНИЗМУУД

Мэдээлэх механизм нь хохирогч, гэрч болон тэдний төлөөлөгчид гэмт хэрэг эсвэл зөрчлийг мэдээлэх боломжийг олгодог тогтолцоо юм. Аюулгүй, хүртээмжтэй, нууцлалыг хадгалдаг мэдээлэх механизм нь СХЖСХ-ийг шийдвэрлэхэд маш чухал ач холбогдолтой. Ийм системийн тусламжтайгаар сурагч бүр айдасгүйгээр хүчирхийлэл, дарамтын талаар мэдээлэх бүрэн боломжтой болж, хүсвэл тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд даруй холбогдох боломжтой болдог.

Мэдээлэх механизм нь СХЖСХ үйлдсэн этгээдүүдэд хариуцлага тооцох, тэд дахин сурагч, хамт олон, орон нутгийн хүмүүст хохирол учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

СХЖСХ-ИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ СААД ТОТГОРУУД

UNESCO-ийн Ази-Номхон далайн бүс нутгийн СХЖСХ-ийн талаарх тойм судалгаа⁵¹нд дараах сорилтуудыг онцолсон байна:

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд болон багш, сурагчдын хоорондын эрх мэдлийн тэгш бус харьцаа.
- Хүчирхийллийг сургуулийн амьдралын “энгийн зүйл” гэж хүлээн зөвшөөрдөг хандлага, соёл.
- Хүчирхийллийг зөвтгөдөг, эсвэл үл тоомсорлодог гүн бат суусан нийгмийн болон соёлын хэм хэмжээ – энэ нь залуу хүмүүс, ялангуяа охидыг бие махбодын болон бэлгийн хүчирхийллийг таньж мэдэхэд хүндрэл учруулдаг. Зарим охид сэтгэл санааны дарамт, хяналт тогтоох байдлыг “хайртай” гэсэн дохио гэж андууран ойлгох нь элбэг.
- СХЖСХ-ийг мэдээлэх тогтолцооны дутмаг байдал – зарим тохиолдолд мэдээлэх систем огт байдаггүй.
- Сурагчид СХЖСХ-г мэдээлэх механизмд итгэдэггүй – өшөө авалт, ялгаварлан гадуурхалт, нэр төрд халдах, шийтгүүлэх, дооглуулах зэрэгт өртөхөөс айж, хүчирхийллийн талаар мэдээлэх нь эрсдэлтэй хэмээн үздэг.

СХЖСХ-ийг мэдээлэхэд ашиглаж болох төрөл бүрийн механизм байдаг. Үүнд:

- Тусламжийн утасны шугамууд (Хүүхдийн утас 108, гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх дугаар 107 зэрэг)
- Чат өрөө болон цахим мэдээлэх платформууд
- “Аз жаргал ба гуниг”-ийн хайрцаг (сурагчид сэтгэл хөдлөл, тулгарсан асуудлаа нэрээ нуун бичиж хийдэг хайрцаг)

⁵¹ UNESCO, 2014

- **Итгэл хүлээсэн хүн** (хүчирхийлэл, дээрэлхэлтийн мэдээллийг хэлэхэд нууц хадгалдаг, сурагчдын итгэлийг хүлээсэн багш, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч)

Эдгээр мэдээлэх механизм нь **бүх сурагчдад хүртээмжтэй** байх ёстой бөгөөд дараах бүлгийн сурагчдад тулгарч болох **онцгой саад бэрхшээлийг** харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- **Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид**
- **Цөөнхийн бүлэгт хамаарах сурагчид** (үндэстний цөөнх, арьс, байршлын ялгаатай хэрэгцээтэй суралцагчид)
- **Нийгэмд гадуурхагддаг бүлгүүд** (ЛГБТИК+, дүрвэгсэд, цагаачид гэх мэт)

Хамгийн тохиромжтой мэдээлэх механизмыг сонгохдоо дараах **гол асуултуудыг** харгалзан үзэх хэрэгтэй.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 12: СХЖСХ-ИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ МЕХАНИЗМЫГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ? (ХАРГАЛЗАН ҮЗЭХ ГОЛ АСУУДЛУУД)

- **Бүх сурагчид мэдээлэх үйл явцын талаар ижил мэдлэгтэй юу?** – Хүчирхийлэл, дарамт дээрэлхэлтийг мэдээлэх үед ямар үйл явц өрнөх, дараа нь юу болох талаар тэд ойлголттой юу?
- **Хүнд хэлбэрийн хүчирхийлэл, хууль зөрчсөн тохиолдлуудыг хэрхэн шийдвэрлэх вэ?** – Хүүхэд хамгааллын болон зөрчлийн болон эрүүлгийн хуульд зааснаар хүчирхийлэл, дээрэлхэлт гарсан нөхцөлд гомдлыг хэрхэн шийдвэрлэх, ямар шат дараалалтай байх вэ?
- **Мэдээлэх механизм нь орон нутгийн дэмжлэгийн тогтолцоотой хэрхэн холбогдох вэ?** – Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ, орон нутгийн нийгмийн ажлын үйлчилгээ зэрэг сүлжээнд хэрхэн холбох вэ?
- **Албан ёсны хамгааллын тогтолцоогоор тохиолдлыг хэрхэн хариуцлагатайгаар шийдвэрлэх вэ?** – Хохирогч болон мэдээлэгчийг өшөө авалт, ялгаварлалд өртүүлэхгүйгээр шийдвэрлэж чадах уу?
- **Мэдээллийн механизм нь хэрхэн сургалт, мэдлэг олгох ажлуудтай уялдах вэ?** – Сурагчдын дунд СХЖСХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд энэ тогтолцоог яаж ашиглах вэ?
- **Мэдээлэх тогтолцооны зохион байгуулалт, хэрэгжилтэд охид, хөвгүүдийг хэрхэн оролцуулах вэ?** – Хүүхдүүдийн дуу хоолой, санал санаачилгыг яаж тусгах вэ?
- **Нууц нэрээр мэдээлэх боломж байна уу?** – Хувийн нууцлал хамгаалагдах нь мэдээлэх эрмэлзлийг нэмэгдүүлж чадах уу?
- **Хэрвээ мэдээлэл нууц нэртэй бол, тухайн хүнийг хэрхэн дэмжих боломжтой вэ?** – Бодит дэмжлэг үзүүлэхэд хэрхэн хүрч очих вэ? нууцлалыг хадгалах нөхцөлд хэрхэн ажиллах вэ?
- **Сургуульд суурилсан мэдээлэх тогтолцоонд нууцлалыг хэрхэн хангах вэ?** – Тухайлбал, хайрцаг ашиглаж байгаа бол, хүчирхийлэл үйлдэгч тухайн хайрцгийг онгойлгож, бичсэн зүйлсийг уншихаас яаж сэргийлэх вэ?
- **Мэдээлэл, гомдлын тоо, хандлагыг хянах өгөгдөл боловсруулах тогтолцоо байгаа юу?** – Тогтмол шинжилгээ хийх, шийдвэр гаргахад ашиглах дотоод мэдээллийн менежментийн систем бий юу?
- **Орон нутгийн нэр хүндтэй иргэд болон шашны төлөөлөгчдийн үүрэг юу байх вэ?** –Тэдгээрийн оролцоог хэрхэн зохистой зохион байгуулах вэ?

СХЖСХ-ИЙГ МЭДЭЭЛЭХ МЕХАНИЗМЫН ЖИШЭЭНҮҮД

Мэдээлэл өгсөн сурагчдын итгэлийг хүлээхийн тулд хүчирхийллийн тохиолдлыг шударгаар, ил тод шийдвэрлэх журам зайлшгүй шаардлагатай.

Олон судалгаагаар сурагчид хүчирхийлэл, дарамтын талаар тун ховор мэдээлдэг нь ихэвчлэн дараах шалтгаантай байдаг. Үүнд,

- Ямар ч арга хэмжээ авдаггүйгээс үүдэн итгэлгүй болох
- Мэдээлсний дараа өөрсдөд нь сөрөг үр дагавар ирэхээс айх

Түүнчлэн, **Тайландад хийсэн судалгаагаар** ЛГБТИ сурагчид хэзээ ч хүчирхийлэл, гадуурхлын талаар мэдээлдэггүй нь нотлогджээ. Энэ нь тухайн бүлгийн сурагчдыг хамгаалах бодлого, бүтэц тогтолцоо хангалтгүй байгаатай, мөн асуудлыг “нуун дарагдуулдаг” соёл түгээмэл байгаатай холбоотой⁵²

Хүүхдийн хүчирхийллийн сэжигтэй тохиолдлыг мэдээлэх нь тухайн улс орны нөхцөлөөс хамааран сайн дурын эсвэл хуульчлагдсан заавал мэдээлэх үүрэгтэй байж болдог. Гэвч заавал мэдээлэх журмыг хэрэгжүүлэхэд болгоомжтой хандах шаардлагатай. Үүнд:

- Мэдээлсэн тохиолдолд урамшуулал өгөх
- Мэдээлээгүй бол хариуцлага тооцох
- Үргэлж хүүхдийн эрх, аюулгүй байдал, сэтгэлзүйн сайн сайхан байдлыг тэргүүнд тавих хэрэгтэй.

Олон оронд сургуулиуд болон захирал, багш нарын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний систем нь **бугшсан асуудлыг нуун дарагдуулахыг урамшуулсан** байдаг. Ийм тогтолцоог дахин хянах шаардлагатай. Жишээлбэл, 108 тусгай дуудлагад хүчирхийлэл мэдээлэгдэхгүй байх, кейс огт гараагүй хэмээн мэдээлэх гэх мэт.

Мөн хүчирхийлэл, дарамт дээрэлхэлтийн талаар эцэг эх сургуульд мэдээлэх, эргүүлээд эцэг эх асран хамгаалагч нарт хариу арга хэмжээгээ мэдээлэх үйл явц багш, захиралуудад маш хүндрэлтэй байдаг тул энэ чиглэлээр сургуулиудад чадавхжуулах **сургалт, дэмжлэг** үзүүлэх нь зайлшгүй хэрэгцээтэй.

ЗӨВЛӨХ БА ДЭМЖИХ

СХЖСХ-ийн тохиолдолд хохирогч, гэрч эсвэл хүчирхийлэл үйлдэгчид **зөвлөгөө өгөх** болон **сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл явцыг** нийтэд нь **зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээ** хэмээн нэрлэнэ. Гэхдээ “**зөвлөгөө өгөх**” гэдэг ойлголт улс орон, соёл бүрт өөр өөр утгатай. Ихэнх тохиолдолд энэ нь тухайн хүн **асуудал, мэдрэмжийнхээ талаар итгэлтэй, нууцлалтай орчинд ярилцах боломж** бүхий ярианы сэтгэл заслын арга зүй юм.

НҮБ-ын Хүүхдийн Сан (2011)-ийн зөвлөмжийн дагуу, СХЖСХ-ийн тохиолдлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд дараах нөхцөлийг хангасан **зөвлөгөө, мэдээлэх тогтолцоог** онцолсон.

- **аюулгүй**
- **хүртээмжтэй**
- **хүүхдэд ээлтэй**
- **нууцлалтай**
- **бие даасан, хараат бус**

Дэмжлэг⁵³ зөвхөн хохирогчид бус, гэрч болон хүчирхийлэл үйлдэгчид, ялангуяа сурагчдад (насанд хүрээгүй хүмүүс) ч чиглэсэн байх ёстой. Учир нь эдгээр хүүхдүүд өөрсдөө сэтгэл зүйн болон бусад асуудалтай давхар тулгарсан байдаг бөгөөд энэ нь тэднийг хүчирхийлэл үйлдэхэд хүргэсэн байж

⁵² UNESCO / Mahidol University / Plan International / Sida, 2014

⁵³ Хүүхэд хамгааллын хуулийн (шинэчилсэн найруулга)-аар Боловсролын салбар дараах үүргийг хүлээнэ. Үүнд,
23.4.2.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдээлсэн суралцагчийн мэдээллийн нууцыг хадгалах, цаашид хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
23.4.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй уулзалт зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;
23.4.4.хохирогч хүүхдийг сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд нэн даруй хамруулах;
23.4.5.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхдэд дараах арга хэмжээг шат дараалан хэрэглэх:
23.4.5.а.суралцагчид өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах;
23.4.5.б.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.

болзошгүй. Иймд тэдэнд ч мөн адил мэргэжлийн тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээ шаардлагатай.

Анхаарахад багш нар болон сургуулийн ажилтнууд өөрсдөө ч хүчирхийлэл, дарамтад өртөж болдог бөгөөд тэднийг ч энэ тогтолцооны хүрээнд хамгаалж, дэмжих хэрэгтэй байдаг.

Зөвлөгөө өгөх болон хохирогчийг дэмжих чиглэлээр улс орнуудад янз бүрийн үндэсний стратеги хэрэгждэг. Үүнд:

- Багш нарыг анхан шатны холбоо тогтоогч болгон бэлтгэж, зөвлөгөө өгөх ур чадвартай болгох (жишээлбэл: “хамгаалагч” эсвэл “ментор” багш нар)
- Мэргэжлийн зөвлөх багш, сэтгэл зүйчдийг сурган ажиллуулах
- Орон нутгийн сайн дурынхныг чадавхжуулах
- Хүүхэд, залуучуудын өөр хоорондын харилцан дэмжлэг, зөвлөгөөний тогтолцоо (peer counseling, peer support) хөгжүүлэх

Африк тивд хийсэн харьцуулсан судалгаанд охид хүчирхийлэлд өртсөн тохиолдолд бараг хэзээ ч мэдээлдэггүй нь тогтоогджээ.

- Мозамбикт хүчирхийлэлд өртсөн охидын ердөө 6 хувь нь мэдээлсэн
- Гана улсад 15 хувь
- Кени улсад 35 хувь мэдээлсэн байна.

(Parkes and Heslop, 2011)

Дээр дурдсанчлан, зөвлөгөө, дэмжлэгийн тогтолцоог зохион байгуулахдаа ялгаатай хэрэгцээтэй бүлгүүдийн онцлогийг заавал харгалзан үзэх нь чухал.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 13: СХЖСХ-ИЙН ХОХИРОГЧДОД ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ (ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ)	
ОРЧИН	○ Сурагчид СХЖСХ-ийн талаар аюулгүй, нууцлалтайгаар ярилцах боломжтой, тухтай, тохирсон орчин бүрдсэн байх
НӨӨЦ	○ Зөвлөхүүд хичээлийн цагаар зориуд цаг гарган ажиллах боломж, нөхцөлөөр хангагдсан байх ○ Хэрэв багш сурагчдад зөвлөгөө өгч байгаа бол, сургалтын үйл ажиллагааны ачааллыг бууруулах нөхцөл бүрдүүлж, мэргэжлийн сургалтанд заавал хамруулсан байх
МЭДЭЭЛЭЛ, ИТГЭЛЦЭЛ	○ Сурагчид зөвлөгөө, дэмжлэг авах чиглэлээр хэрхэн хаанаас, яаж авах, хаана, хэнд хандахаа мэддэг байх ○ Сурагчид уг үйлчилгээг нууцлалтай, аюулгүй гэж итгэж мэддэг байх
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, ДЭМЖЛЭГ, ШИЛЖҮҮЛЭЛТ	○ Зөвлөх нь зөвлөгөө өгөх үндсэн ур чадвартай, мөн СХЖСХ-ийг мэдээлэх дотоод, гадаад журам болон орон нутгийн хууль тогтоомжид нийцүүлэн хэрхэн хариу арга хэмжээ авахыг мэддэг байх ○ Зөвлөхүүд сурагчдыг шаардлагатай үед мэргэжлийн хүн, байгууллагад хэрхэн, хэзээ шилжүүлэхээ мэддэг байх
ЭРСДЛИЙН УДИРДЛАГА	○ Хүүхэд, залуусын сэтгэл зүйн болон биеийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэх протокол, дүрэм журам бүрдсэн байх ○ Үйлчилгээний үеэр гарсан гомдол, өргөдөл, мэдээллийг зохистойгоор шийдвэрлэх дүрэм, журам байх

АНХААРАХ БУСАД ЗҮЙЛС	○ Нэг сурагч хэдэн удаа зөвлөгөө авах боломжтой байх вэ? Хязгааргүй эсвэл тодорхой тоотой байх уу? ○ Хүлээлгийн жагсаалт үүссэн үед ямар сурагчдыг тэргүүн ээлжинд оруулах вэ? ○ СХЖСХ-д өртсөн сургуулийн ажилтан, багш нарт энэхүү үйлчилгээ нээлттэй юу? ○ Энэ үйлчилгээ зөвхөн хохирогч сурагчдад уу, эсвэл гэрч болсон эсвэл хүчирхийлэл үйлдсэн сурагчдад ч мөн хамаарах уу? ○ Сурагчдын амралтын үеэр сурагчдад дэмжлэгийг хэрхэн үргэлжлүүлэх вэ?
-------------------------	---

Бүх шатны боловсрол, сургалтын байгууллага дараахыг мэдэх шаардлагатай. Үүнд,

- Сурагч, багш, сургуулийн ажилтнуудыг СХЖСХ-ээс ямар хууль тогтоомжоор хамгаалдаг вэ?
- Сургуулийн ёс зүйн дүрэм нь сурагч, багш, сургуулийн ажилтнуудыг СХЖСХ-ээс хэрхэн хамгаалдаг вэ?
- СХЖСХ-ийн хохирогч/даван туулагчид нэмэлт тусламж авах боломжтой орон нутгийн ямар үйлчилгээ, байгууллагууд байдаг вэ?

2.5 ТҮНШЛЭЛ: ҮНДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙХ


СХЖСХ гэх мэт хүнд, олон талт асуудлыг үр дүнтэй, тогтвортой шийдвэрлэхийн тулд олон чиглэлийн, нөхцөл байдалд нийцсэн, иж бүрэн хандлага шаардлагатай бөгөөд үүнд олон төрлийн оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй.

Эдгээр талуудын хандлага, сорилт, боломж, тэдэнд хэрэгтэй дэмжлэг, сургалт, нөөцийг ойлгохын тулд бүх түвшинд зохион байгуулалттай, уялдаа холбоотой ажиллах шаардлагатай.

Гол оролцогч талууд нь СХЖСХ-ийг зогсооход хамтран ажиллах түнш байх ёстой. Үүнд дараах чиглэлүүд багтана:

- Салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа (жишээ нь: боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, нийгмийн хамгаалал)
- Багш нарын холбоотой түншлэх
- Орон нутгийн хамтын оролцоог дэмжих
- Гэр бүлийн оролцоог идэвхжүүлэх
- Залуучуудын манлайлал ба оролцоог хангах

Зураг 9. Түншлэл, хамтын ажиллагаа⁵⁴



САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

СХЖСХ-ийг олон салбарын оролцоотойгоор шийдвэрлэх нь зөвхөн боловсролын салбарт хязгаарлагдахгүй, харин олон түвшинд, урт хугацаанд хамтарч ажиллах шаардлагатай **интеграцчилсан хандлага** юм.

⁵⁴ <https://www.ungei.org/publication/school-related-gender-based-violence-global-guidance-infographic>

Зураг 10. Боловсролын салбарын манлайлал дор СХЖСХ-ийн хариу арга хэмжээнд оролцдог олон талт түншүүд⁵⁵
Түншлэл дараах байдлаар хэрэгжиж болно.



- **Үндэсний түвшинд:** Салбар хоорондын хууль, бодлогын уялдааг бий болгох зорилгоор боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хууль зүй, дотоод хэрэг, хүүхэд, гэр бүл хариуцсан яамд хооронд хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах,
- **Дунд түвшин:** Үүнд сургуулийн захирал, дүүрэг/аймгийн боловсролын газар, хэлтэс, Багш нарын мэргэжлийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, сургуулийн зөвлөлүүд зэрэг үндэсний болон сургуулийн түвшний хооронд орших бүтэц багтдаг. Энэ түвшинд бодлогын уялдаа, хамтын ажиллагаа нь амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг зохицуулах чухал гүүр болно.
- **Сургуулийн түвшин:** Бодлогыг хэрэгжүүлэх шууд орчин. Багш нар, сургуулийн удирдлагын баг, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид хамтран ажиллах хэрэгтэй.

САЙН ТУРШЛАГА: СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС⁵⁶

Эрүүл мэндийн яам

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хохирогчдыг эмчлэх;
- Хохирогчийг хамгаалах байгууллага ажиллуулах;
- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тусгай хөтөлбөр боловсруулахад хамтран ажиллах

Гэр бүл, жендэрийн эрх тэгш байдлын яам

- Хохирогчид зөвлөгөө өгөх;
- Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх;
- Хохирогчид сэтгэл заслын эмчилгээ үзүүлэх төвүүдийг хариуцан ажилладаг.

⁵⁵ Global Guidance on addressing school-related gender based violence, UNGEI, 2016

⁵⁶ ЕБС-ийн ёс зүйн кодекс ба сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн хариу арга хэмжээний талаарх бусад орны туршлага, Парламены судалгааны хүрээлэн, 2022 он

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүүхэд хамгааллын Үндэсний газар (National Center for the Rights of the Child)⁵⁷

- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тал дээр салбар хоорондын уялдааг бий болгох;
- Хүчирхийллийн эсрэг хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх;
- Хүүхдийн хүчирхийллийн талаарх нэгдсэн мэдээллийн санг удирдах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, тайланг нийтэд мэдээлэх;
- Хүчирхийлэл хайхрамжгүй байдлын эсрэг арга хэмжээг олон нийтэд сурталчлах;
- Хүүхэд хамгааллын шуурхай утас ажиллуулах;
- Хүүхэд хамгааллын олон аргаар хүүхдийн эрхийг дэмжин нягт хамтран ажиллаж байна.

WEE төсөл (We, Education, Emotion)⁵⁸

2008 онд Боловсролын яамнаас сургуулийн орчинд дээрлэхэлт түүний сөрөг үр дагаврыг таслан зогсоох зорилгоор WEE төслийг оношилгоо, зөвлөгөө, эмчилгээ гэсэн 3 үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр санаачлан ажиллаж байна.



Оношилгоо-анхан шатны нэгж болох анги бүлэгт сургуулийн хүчирхийлэлд өртсөн, цахим орчинд донтсон, сахилгын шийтгэл хүлээсэн сурагчдыг илрүүлж ганцаарчилсан зөвлөгөө өгөх, бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн эмчилгээний төрөл бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

Зөвлөгөө- орон нутгийн боловсролын газрууд нэгдэж тусгай зөвлөгөө өгөх төвд мэргэжлийн сэтгэл зүйч, шинжээч зөвлөх, эмнэлгийн ажилтан, нийгмийн халамжийн ажилтнуудаас бүрдсэн багийг ажиллуулан хохирсон сурагчдад зөвлөгөө өгөх, сургуулийн хүчирхийлэл үйлдсэн сурагчтай уулзаж нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Эмчилгээ-мэргэжлийн байгууллагуудтай хамтран урт хугацааны сэтгэл зүйн эмчилгээ болон шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг.

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

Үйлдвэрчний эвлэл (ҮЭ) нь багш нарыг ажилтан талаас төлөөлдөг хамтын удирдлагын байгууллага юм. Үйлдвэрчний эвлэл нь багш нарын дунд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд ажлын байрны стандарт, ёс зүйн дүрмийн практик хэрэглээ, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Багш нар нь сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл (СХЖСХ)-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул Үйлдвэрчний эвлэл нь гишүүддээ СХЖСХ-ийн талаарх сургалт өгч, дэмжлэг авахад туслах, СХЖСХ-ийн талаар цогц арга хэмжээ, Ёс зүйн дүрэм, хүмүүжлийн эерэг арга барилын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний түвшинд, бодлогын орон зайд дуу хоолойгоо хүргэхэд чухал нөлөө үзүүлж чадна.

Багш нар өөрсдөө боловсролын орчинд жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамтад өртөх нь ихэнхдээ анхаарлаас үлддэг тул асуудал байсаар ирсэн. Багш нарын эсрэг хүчирхийллийн талаарх судалгаагаар шинэ, залуу эмэгтэй багш нар хамгийн өндөр эрсдэлд байдаг нь тогтоогдсон.

Мөн хэд хэдэн судалгаагаар багш бэлтгэдэг байгууллагуудад эмэгтэйчүүд болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх буруу хандлага, зан үйл сурч, хэвшмэл болдог нь тогтоогдсон. Зарим нөхцөлд багш нар өөрсдөө СХЖСХ-ийн үйлдэгч байж болдгийг судалгаанууд харуулсан. Иймээс багш нарын зан үйлийг өөрчлөх, хяналтын механизмыг сайжруулах нь СХЖСХ-ийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд нэн чухал юм.

⁵⁷ National Center for the Rights of the Child <http://korea1391.go.kr/new/page/eng/welcoming.php>

⁵⁸ Wee project [file:///Users/uurtsaikh/Desktop/9_Analyzing_the_effectiveness_of_the_Korean_National_anti-bullying_program\(Cho\).pdf](file:///Users/uurtsaikh/Desktop/9_Analyzing_the_effectiveness_of_the_Korean_National_anti-bullying_program(Cho).pdf)

Иймд Үйлдвэрчний эвлэл нь багш нарын зан үйлийг болон тэдний ажлын байр болсон боловсролын орчныг хувирган өөрчлөх, СХЖСХ-ийг шийдвэрлэхэд боловсролын тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх, чадавхжуулах, бэлэн байдлыг нь нэмэгдүүлэхэд стратегийн чухал түнш юм.

Дэлхий даяар багш нарт элсэлт, ирц, сурлагын амжилт гэх мэт хязгаарлагдмал хэмжүүрээр тэдний гүйцэтгэлийг үнэлэх дарамт нэмэгдэж байгаа нь сурагчдын сэтгэлзүйн болон нийгмийн сайн сайхан байдлыг хойш тавихад хүргэж байгаа талаар багш нар мэдээлдэг Үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажиллах нь багш нарт сурагчдын нийгэм-сэтгэлзүйн сайн сайхан байдлыг дэмжих, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр дэмжлэг болж, хичээл зүтгэл гаргахад нь тусална.

Тиймээс Үйлдвэрчний эвлэл гишүүдийнхээ дунд СХЖСХ-ийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах, аргачлал боловсруулах, багш нарыг чадавхжуулах ажилд идэвхтэй оролцох ёстой.



ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 15: БАГШ НАРЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮД СХЖСХ-ИЙГ ШИЙДВЭРЛЭХИЙН ТУЛД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?⁵⁹

2013 оны арваннэгдүгээр сард НҮБ-ын Охидын Боловсролын төлөөх Санаачилга (UNGEI) болон Олон Улсын Боловсролын Холбоо (EI) хамтран багш нарыг СХЖСХ-ийг шийдвэрлэхэд манлайлан оролцуулах талаарх уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтаар багш нарын хэрэгжүүлж болох тодорхой үйл ажиллагааг санал болгосон байна. Үүнд:

- Багш нарыг СХЖСХ-ийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр гол манлайлагч буюу "жолооны ард" байлгах;
- Багш нарыг тунхаг/тангараг өргөх/амлалтад гарын үсэг зуруулах;
- "Энэ бол хүчирхийлэлгүй анги/сургууль" гэдгийг илэрхийлэх бэлгэ тэмдэг, туг, лого боловсруулах;
- СХЖСХ-ийг урьдчилан сэргийлэх мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хичээлийн төлөвлөгөө, хэрэглэгдэхүүн, зуны сургалтын хөтөлбөр бүхий цогц хэрэглэгдэхүүн боловсруулах;
- Сургууль бүрт хамгийн багадаа хоёр багшийг энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулан, манлайлагч болгон бэлтгэх, харилцан дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Багш, сургууль, хамт олны манлайллыг үнэлсэн олон нийтэд чиглэсэн урамшуулал, "Хичээлийн шинэ жил" кампанит ажил, үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсооё! аян, уралдаан тэмцээн, мэтгэлцээн зохион байгуулах;

Багшийн мэргэжлийн холбоодод СХЖСХ-ийн талаар өгсөн зөвлөмжүүд

2014 онд болсон Education International (Боловсролын олон улсын холбоо)-ийн Эмэгтэйчүүдийн Дэлхийн Бага Хурал дээр СХЖСХ-ийн асуудал үндсэн сэдвүүдийн нэг байв. Тус хурлаас дараах гол зөвлөмжүүд гарсан. Үүнд:

- **Мэргэжлийн ёс зүйн талаарх EI-ийн Тунхаглал**-ыг шинэчлэн боловсруулж, сургуулийн орчин дахь бүтцийн болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой заалтуудыг тодорхой тусгах; энэхүү тунхаглалыг бүх багш нарт хүртээмжтэй байдлаар таниулах, түгээх
- **EI-ийн гишүүн байгууллагууд** улс орныхоо сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг тусгахын төлөө манлайлан ажиллах.
- **EI нь бүх бүс нутагт СХЖСХ-ийн тархалт, хэлбэрүүд, мөн үүний эсрэг багш нарын гүйцэтгэх үүргийн талаар судалгаа хийх**; энэхүү судалгаанд улс орнуудын боловсролын Үйлдвэрчний эвлэлүүдийн СХЖСХ-ийн эсрэг хэрэгжүүлж буй шилдэг туршлагуудыг багтаах ба охид, хөвгүүдийг сургууль завсардахгүй байхад чиглэсэн орон нутгийн болон хамтын нийгэмлэгүүдийн шилдэг санаачлагуудыг түгээн дэлгэрүүлэх.

НИЙГЭМ, ХАМТ ОЛНЫГ ДАЙЧЛАХ

СХЖСХ-ийг таслан зогсоох чиглэлээр олон нийтийг татан оролцуулах нь энэ асуудлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, "аниргүйг эвдэх" төдийгүй бодлогын нөлөөллийг идэвхжүүлэхэд тусалдаг. Хүчирхийллийг хөхиүлэн дэмждэг, хүлээн зөвшөөрдөг нийгмийн хэм хэмжээг өөрчлөхийн тулд өөрчлөлтөд чиглэсэн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийг дайчлах, бодлогын нөлөөлөл маш чухал юм. Олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр нь сургууль болон хамт олныг бусад оролцогч талуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ мэдээллээр хангах, практик үйл ажиллагаатай холбох болон үйлчилгээ авахад тусалдаг.

Ялангуяа "халдлагад өртөж" байгаа сургуулиудад, сургуульдаа очих замд хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, охидын боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах зэрэг асуудлыг улс төржүүлж, бодлого болгон

⁵⁹ UNGEI (2013)

хэрэгжүүлэхэд олон нийтийг дайчлах нь чухал үр дүнтэй. Нийгэм, хамт олныг дайчилснаар эрэгтэйчүүд болон хөвгүүдтэй нягт холбоо тогтоож, эцэг эх, багш, шашны болон уламжлалт удирдагчид гэсэн эрэгтэйчүүдийн гүйцэтгэдэг цөөн хэдэн үүргээр тодорхойлогдсон нийгмийн хэм хэмжээг эрэгтэйчүүдийн дунд өөрчлөх, ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдалд хүргэдэг жендэрийн хор хөнөөлтэй хэм хэмжээг эсэргүүцэх олон боломж олгосон.

Үр дүнтэй нийгмийн хөдөлгөөнийг бий болгохын тулд тухайн орон нутагт аль хэдийнэ үйл ажиллагаа явуулж, хамт олны дэмжлэг авч ажилладаг **хүүхэд хамгааллын тогтолцоо** зэрэг одоо байгаа нөөц, чадавх дээрээ тулгуурлах нь чухал. Ийм механизм нь хүүхдүүдийг хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн эрхийн талаар олон нийтэд мэдлэг олгоход чиглэдэг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

САЙН ТУРШЛАГА: АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ АРГАЧЛАЛ НУТАГШСАН НЬ, МОНГОЛ УЛС⁶⁰

Нийгэм, хамт олныг дайчилсан үр дүнтэй жишээ бол Угандагийн "Raising Voices" хэмээх ашгийн бус байгууллагаас хэрэгжүүлдэг **Сайн сургууль аргачлал** юм. Энэ аргачлал нь Уганда дахь 600 сургуульд нэвтэрсэн бөгөөд дараах зорилготой:

- Сургуулийн хамтын алсын харааг хөгжүүлэх
- Эв найртай, халамжтай, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх
- Орчин үеийн, сурагч төвтэй сургалтын арга зүйг хэрэгжүүлэх
- Сургуулийн засаглалыг бэхжүүлэх

Энэ санаачилга нь **багш, сурагч, сургуулийн удирдлага, эцэг эх, нутгийн захиргаа болон орон нутгийн иргэд** хамтран хэрэгжүүлдэг бөгөөд 6 үе шат бүхий үйл явцыг дамжин сургуулийн соёлыг өөрчлөхөд чиглэгддэг байна. **Багш, сурагчид** гол үүрэг гүйцэтгэж, **орон нутгийн удирдлагууд баталгаажуулж, эцэг эхчүүд болон хамт олон дэмжлэг үзүүлдэг.**

Монгол улсад МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ 2014 оноос эхлэн "Аюулгүй сургууль" нэртэйгээр дээрх аргачлалыг ЕБС-ууд дээр хэрэгжүүлж байна. Нийт 15 ЕБС хамрагдсанаас 14 нь орон нутагт байрладаг. Аюулгүй сургууль аргачлал нь хүүхэд нэг бүрийн оролцоог нэмэгдүүлж, багш нарын бүтээлч заах арга барилыг дээшлүүлж, сургуулийн хамт олон хамтдаа суралцан хөгжихөд ээлтэй орчин бүрдүүлэхийг зорьдог. Уг аргачлал нь нийгмийг эерэгээр өөрчлөхөд хамгийн их нөлөө үзүүлэх, найдвартай суваг нь сургууль хэмээн үздэг. Хандлага, сэтгэлгээний өөрчлөлтийг бий болгох гол хүч нь сургуульд буй тул аливаа ялгаварлан гадуурхал, хүчирхийллээс ангид хүмүүнлэг нийгмийг бүтээхэд энэ аргачлал тусалдаг. Сургуулиуд нь хүмүүнлэг, ардчилсан, хүүхдийн эрх, жендэрийн тэгш эрхийг хангасан бичил орчныг бүрдүүлж, сурлагын амжилтыг дээшлүүлэхийн зэрэгцээ хүүхдүүдэд үнэнч, шударга, энэрэнгүй сэтгэлтэй, бүтээлч, чөлөөтэй, хариуцлагатай, өөртөө итгэлтэй, бусдад тусархаг хүн болон төлөвшихөд нь тус болж чадна. Мөн багш, ажилчдынхаа ч мэргэжлийн болон хувийн хөгжлийг дэмжиж, хүчирхийллээс ангид хүчтэй орон зайг бүрдүүлж чадна.

Аргачлалын онцлог

Сургуулийн хэрэгцээ, онцлог, сургуулиудын гаргаж буй санаачилгуудаас шалтгаалж аргачлал нь сургууль бүр дээр өөр өөрөөр хэрэгждэг. Аргачлал нь тоглоом болон оролцоонд тулгуурлаж, нэмэлтээр урлагаар дамжуулан багш сурагчдын хооронд ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж, бие биенээсээ харилцан суралцах боломжийг олгон сурагчид өөрсдөө бие даан аливааг эргэцүүлэн бодож, задлан шинжлэх, бүтээлчээр сэтгэх орон зайг бий болгодог.

Ингэснээр хүүхэд НЭГ бүрийн оролцоо нэмэгдэж, багш нарын бүтээлч заах арга барил дээшилж сургуулийн хамт олон ХАМТДАА хөгжиж суралцахад ээлтэй орчин бүрддэг.

"АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ" АРГАЧЛАЛЫН ХҮРЭЭ

Багшийн бүтээлч хамтын ажиллагааг дэмжих	Суралцахад ээлтэй орчин бүрдүүлэх	Сургуулийн засаглалыг бэхжүүлэх
Багш олон талт оролцооны аргад суралцан, хичээл үйл ажиллагаанд аргачлалын арга зүйг тусган ажилладаг.	Сургуулийн материаллаг болон сэтгэлзүйн орчныг сайжруулахад сургуулийн хамт олонд агуулга, аргазүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг	Сургуулийн материаллаг болон сэтгэлзүйн орчныг сайжруулахад сургуулийн хамт олонд агуулга, аргазүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг

ГЭР БҮЛҮҮДТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ

Сургуулиуд нийгмээс тусгаар оршдоггүй. Сургуулийн орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл нь олон тохиолдолд эцэг эх болон гэр бүлийн бусад гишүүдийн харилцаа, зан үйлээр дамжин бүрэлддэг өргөн хүрээний нийгмийн хэм хэмжээ, хүлээлтүүдийн тусгал байдаг.

60 "Дэлхийн иргэний боловсрол" бодлогын нөлөөллийн баримт бичиг, Боловсрол эвсэл, 2025 он

Зарим хүүхдүүд **гэр бүлийнхээ онцлог**— ганц бие эцэг эхтэй байх, ЛГБТИ гэр бүлд харьяалагдах, нийгмийн цөөнх бүлгийн гишүүн байх эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхтэй байх зэргээс үүдэн хүчирхийллийн бай болох эрсдэлтэй байдаг.

Гэр бүлийн бүтэц, харилцааны динамикийг ойлгох нь хүүхдүүдийг СХЖСХ-д өртөх эрсдэлийг тодорхойлох, түүнээс сэргийлэх, бууруулахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн, хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд—хүчирхийллийн гэрч болсон ч бай, өөрсдөө хохирогч байсан ч бай—насанд хүрээд өөрсдөө хүчирхийлэл үйлдэх магадлал өндөр байдаг нь олон судалгаагаар нотлогдсон. Зарим судалгаагаар хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөх нь охидын хувьд насанд хүрэх үедээ дахин хүчирхийллийн золиос болох эрсдэлийг нэмэгдүүлдэг болох нь батлагдсан.

Хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөх эсвэл тогтмол давтамжтай хүчирхийлэлд байх нь удаан хугацааны архаг стресс үүсгэж, энэ нь хөгжиж буй тархинд хортой нөлөө үзүүлдэг. Насанд хүрсэн хүний дэмжлэг, хамгаалалтгүй нөхцөлд энэ стресс нь тархины бүтэц, хөгжлийн явцад нөлөөлж, улмаар:

- Насан туршийн турш **бие махбодын өвчинд өртөмтгий болох,**
- **Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд** үүсэх (жишээлбэл: сэтгэл гутрал, түгшүүрийн эмгэг, мансууруулах бодисын хамаарал) зэрэг сөрөг үр дагаварт хүргэх боломжтой болохыг судалгаанууд харуулсан (Landers, 2013).

Мөн зарим судалгаанаас харахад гэр бүлийн хүрээнд тохиолддог хүчирхийлэл, хүндрэл бэрхшээлүүд нь ихэвчлэн өөр хоорондоо давхцаж, зэрэгцэн оршдог. Тиймээс хүүхдийг эрсдэлд оруулж буй гэр бүлийн орчныг сайжруулах замаар, тухайн хөтөлбөрүүд зөвхөн нэг төрлийн бус, өөр олон төрлийн хүчирхийллийг давхар бууруулах боломжтой гэсэн үг юм.

Гэр бүлийнхэнтэй холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлснээр дараах ач холбогдолтой. Үүнд,

- Жендэрийн тэгш бус байдал, хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг үнэт зүйлс, хандлагыг өөрчлөх,
- Хүүхэд бүрийн өмнө тулгарч буй эрсдэлийн мөн чанарыг ойлгох,

Үүний үндсэн дээр тухайн орон нутгийн нөхцөлд тохирсон, иргэд олон нийтэд нь хүлээн зөвшөөрөгдөх СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, хариу үйлчилгээ үзүүлэх механизм боловсруулах боломж бүрдэнэ.

Өнөөдрийг хүртэл эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлүүдийг сургууль дээрх жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд холбон оролцуулсан хөтөлбөрүүд маш цөөн байсан бөгөөд ялангуяа АНУ болон цөөн тооны өндөр орлоготой улс орнуудаас бусад газарт бараг хэрэгжээгүй. Ийм төрлийн хөтөлбөрүүд нь ихэвчлэн **хүүхдээ хүчирхийлсэн, үл хайхарсан**⁶¹, эсвэл **эрсдэлт** эцэг эхчүүдэд чиглэдэг бөгөөд **зөрчил, хүчирхийллийг шууд бууруулах** зорилготой нь маш цөөн байдаг. Ихэнх эцэг эхийн хөтөлбөрүүд нь:

- Гэрээр айлчлах,
- Орон нутгийн хөгжлийн төв дээр суурилсан,
- Эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан хэрэгждэг бөгөөд боловсролын байгууллагад суурилсан нь маш цөөн.

Эдгээр хөтөлбөрүүдэд нийтлэг ордог үйл ажиллагаанд— ганцаарчилсан зөвлөгөө өгөх эсвэл бүлгээр хэлэлцэх, дүрд тоглох (role play), эерэг хүмүүжлийн аргууд, зан үйлийг харуулсан видео бичлэг үзүүлэх, эцэг эхийн эерэг хандлагыг сурталчилсан сургалтын материал тараах, удирдамжийн дагуу эцэг эх,

61 4.1.6."хүүхдийг үл хайхрах" гэж хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг (Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2024 он)

хүүхдэдтэйгээ хамт тоглох үйл ажиллагаа зэрэг ордог. Хамгийн өргөн хэрэгжиж буй эцэг эхэд чиглэсэн хөтөлбөрүүдийн үнэлгээнээс үзэхэд үр дүн нь харилцан адилгүй байдаг бөгөөд үүний тод жишээг **Fast Track** эцэг эхийн хөтөлбөрийн туршлагаас харж болно.

САЙН ТУРШЛАГА: “FAST TRACK” ЭЦЭГ ЭХИЙН ХӨТӨЛБӨР, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

“Fast Track” нь АНУ-д хүн ам зүйн 4 өөр байршилд хүүхэд, өсвөр насныхан болон тэдний эцэг эхчүүдэд чиглэн 10 жилийн турш хэрэгжсэн урт хугацааны хүүхэд хамгааллын эрсдлээс урьдчилан сэргийлэх цогц хөтөлбөр юм. Fast Track нь багш бэлтгэх үйл явц, сургалтын хөтөлбөрт нэгтгэх болон эрсдэл өндөр хүүхдүүд болон тэдний гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зэрэг хэд хэдэн дэд бүрэлдэхүүн хэсэгтэй.

Fast Track-ийн нэг хэсэг болгон гэр бүл, сургуулийн зэрэг харилцааг хөгжүүлэх, эцэг эхчүүдэд зан үйлээ удирдах ур чадвар, ялангуяа магтаал урамшуулал хэрэглэх, зөрчлөөс завсарлага авах, өөрийгөө хязгаарлах арга барилд сургах зорилгоор эцэг эхэд чиглэсэн сургалт хийж, дэмжлэгийн бүлгүүдийг байгуулсан. Хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүд гэр бүлийн хурал (жилийн турш 5-22 удаа), эцэг эх, хүүхдэдтэйгээ ярилцах 30 минут, эцэг эх байх ур чадварыг сайжруулахад чиглэсэн хоёр долоо хоногт нэг удаа гэрээр айлчлах зэрэг үйл ажиллагаанд оролцсон.

Fast Track хөтөлбөрийн хөндлөнгийг хяналтыг санамсаргүй түүврийн аргаар хүүхдүүдийн бүлгүүдтэй хэд хэдэн удаагийн үнэлгээг хийхэд дараах үр дүн гарсан.

- ◇ Fast Track хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүд хяналтын бүлгийнхтэй харьцуулахад сахилга бат тогтоох хатуу аргуудыг бага ашиглаж байсан.
- ◇ Хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд өсвөр нас хүртлээ гэртээ болон сургууль дээрээ бусдын эсрэг түрэмгий зан авир гаргах нь хамрагдаагүй хүүхдүүдтэй харьцуулахад бага байсан.
- ◇ Хөтөлбөрийн хүүхдүүд өсвөр насандаа хяналтын бүлгийхэнтэйгээ харьцуулахад үе тэнгийнхнээсээ доогуур түвшинд баривчлагдсан.
- ◇ Хөтөлбөрийн хүүхдүүдийн хэт идэвхжил бага байсан бөгөөд өөрийгөө гэмтээх зан үйл багатай байсан.

Гэвч зарим үнэлгээнээс харахад, Fast Track-д хамрагдсан хүүхдүүд хяналтын бүлгийг бодвол “хэцүү” гэгддэг үе тэнгийнхэнтэйгээ илүү их холбогдсон байсан. Интервенцийн бүлгийн хувьд нийгмийн ур чадвар, зан үйл, нийгмийн эсрэг зан үйлд нөлөөлөл үзүүлээгүй боловч янз бүрийн үнэлгээгээр аль хэдийн “эрсдэлтэй” гэж тооцогддог хэсгийн хамгийн өндөр “эрсдэлтэй” 3 хувийн хүүхдүүдийн “дэд бүлгийг” авч үзэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн нь тогтоогдсон.

ЗАЛУУЧУУДЫН МАНЛАЙЛАЛ БА УТГА УЧИРТАЙ ОРОЛЦОО

Залуучуудын манлайлал ба утга учиртай оролцоо нь сургууль дээрх жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд маш чухал. Учир нь залуус өөрсдөө энэ асуудлын шууд нөлөөнд өртөгчид байдаг бөгөөд шийдлийн нэг хэсэг байх эрхтэй, бас чадавхтай. СХЖСХ-тэй тэмцэх цогц арга хэмжээний загвар, бүтэц, бодлого, хэрэгжилтэд залуучуудын манлайлал, оролцоог хангах нь эдгээр арга хэмжээг илүү ач холбогдолтой, үр дүнтэй, хүртээмжтэй болгоход тусалдаг.

Залуус дараах түвшинд СХЖСХ-ийн урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хяналт тавих үйл ажиллагаанд үр дүнтэй оролцдог.

- **Дэлхий болон бүс нутгийн түвшинд:** Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд залуу идэвхтнүүд НҮБ-ын “UNiTE” Залуучуудын Глобал Сүлжээг боловсруулж, жендэрийн тэгш бус байдал, эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг зогсоохын төлөө манлайлан ажиллаж байжээ.

- **Орон нутгийн түвшинд:** СХЖСХ-ийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, дуу хоолойгоо хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж байсан туршлага байна.
- **Сургуулийн түвшинд:** Сургуулийн удирдлагын бүтцэд орох, СХЖСХ-ийг хянах механизмуудад идэвхтэй ажиллаж чадна.

САЙН ТУРШЛАГА: “PURPLE MY SCHOOL” АЯН, АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ⁶²

Сургуулийн орчин нь ЛГБТИ сурагчдын хувьд дайснагасан, аюул занал учруулдаг орчин байх тохиолдол олонтой. Тэд багш нар болон ангийнхнийхаа зүгээс доромжлол, хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт ялгаварлан гадуурхалт зэрэгт өртөх нь түгээмэл.

2015 оны 6-р сард UNESCO, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) болон “Азид ЛГБТИ байх нь” хөтөлбөр (UNDP, USAID болон Бангкок дахь Шведийн Элчин сайдын яамны хамтын санаачилга) хамтран #PurpleMySchool хэмээх аяныг эхлүүлсэн. Энэхүү аяны зорилго нь сургуулийн орчинг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн доромжлол, ялгаварлан гадуурхлаас ангид, аюулгүй болгох явдал юм.

Аян нь сурагчид, багш нар, эцэг эхчүүдийг ЛГБТИ сурагчдын хамтрагч, дэмжигч болохыг уриалдаг. Дэмжигчид нил ягаан өнгийн хувцас өмсөх, зураг зурах, эсвэл ямар нэгэн бүтээл хийх байдлаар оролцож, бүтээлээ аяны вэбсайт руу илгээх, эсвэл #PurpleMySchool хаштаг ашиглан олон нийтийн сүлжээнд нийтэлж оролцдог.

Дунд сургуулиуд болон их, дээд сургуулиуд аяныг олон төрлийн бүтээлч арга хэмжээгээр дэмжин өргөжүүлсэн. Жишээлбэл:

- Спортын тэмцээн, тоглоом зохион байгуулах
- Нил ягаан өнгийн хувцас өмсөх өдөр
- Нил ягаан өнгийн наалт, лаа, сурталчилгааны хуудас, бөмбөлөг тараах
- Нэр алдартай ЛГБТИ хүмүүс, хүний эрхийн тэмцэгч, активистуудыг урьж уулзалт хийх зэрэг багтдаг.



#MyPurpleSchool campaign

62 Purple My School: <https://medium.com/being-lgbti-in-asia/purplemyschool-campaign-making-education-safer-for-lgbti-students-9060a05413f4>

2.6 БАРИМТ НОТОЛГОО: СХЖСХ-ИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ТОГТМОЛ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Сургууль дээрх жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг үндэсний түвшний үйл ажиллагаа нь дараах судалгаа, мэдээлэлд үндэслэсэн байх шаардлагатай. Үүнд:

- СХЖСХ-тэй холбоотой арга хэмжээг хянах, үнэлэх хяналт, үнэлгээний (M&E) хүрээ
- Ахиц дэвшлийг хэмжих үзүүлэлтүүд
- Үндэсний хэмжээний иж бүрэн дата мэдээлэл цуглуулах систем болон боловсролын салбарын системийн түвшний хяналт (EMIS)
- СХЖСХ-ийн талаарх суурь судалгаа, бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглах
- Нөлөөлөл болон хэрэгжилтийн үйл явцыг үнэлэх судалгаа
- Арга зүйн болон ёс зүйн аюулгүй байдлын асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай.

СХЖСХ-ИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ (Monitoring and Evaluation Frameworks)

Сургууль дээрх жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ (цаашид M&E гэх) хийхэд хөрөнгө оруулах нь тухайн хөтөлбөрүүдийг зорилгоо тодорхой болгоход тусалж, асуудлыг шийдвэрлэх чиглэлээр гарч буй ахиц дэвшлийг хянах боломж олгодог. Сайн M&E систем нь хөтөлбөрүүдийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлдэг. Ийм систем нь өндөр эрсдэлтэй хүүхдүүдэд чиглэсэн арга хэмжээг оновчтой төлөвлөж, үр дүнтэй дэмжлэг үзүүлэхэд тусалдаг. Хөтөлбөр хэрэгжих явцад гарч буй өөрчлөлтүүдийг шууд ойлгох боломж бүрдүүлдэг бөгөөд энэ нь СХЖСХ-тэй холбоотой бодлого боловсруулах, нөөц (санхүүжилт, хүний нөөц) дайчлалтыг сайжруулна.

Нарийн нягт боловсруулсан M&E систем нь хамгийн амжилттай, үр дүнд хүрч болохуйц арга хэмжээ, туршлагуудыг илрүүлэхэд оролцогч талуудад тусалдаг. Амжилттай болон амжилтгүй туршлагуудын талаар мэдээлэл хуваалцах, сургалт хийхэд дэмжлэг болдог. СХЖСХ-ийн хор уршгийн талаарх **нотолгоонд суурилсан мэдээлэл** өгөх замаар бодлого боловсруулагчдыг СХЖСХ-г бууруулахад хөрөнгө оруулахад уриалдаг.

Хэдийгээр улс орнуудын түвшинд СХЖСХ-ийн хяналт үнэлгээ хийх туршлага хязгаарлагдмал, мөн нэгтгэсэн олон улсын үзүүлэлт хараахан байхгүй ч бага хэмжээний СХЖСХ хөтөлбөрүүд болон сургуулийн хүчирхийллийг хянах боловсролын салбарын нийтлэг арга барилаас сургамж авч болох юм.

Бат бөх M&E хүрээ нь хөтөлбөрийн юу хийхээр зорьж байгааг болон үүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг урьдчилан тодорхойлох шаардлагатай. Тогтмол хяналт ба тусгай судалгаанууд (жишээ нь: суурь судалгаа, үнэлгээ) хоёрын ялгааг гаргаж ойлгох нь чухал бөгөөд энэ нь янз бүрийн түнш байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах шаардлагатай болдог.

Мөн M&E хүрээ нь сургуулийн түвшинд (жишээ нь: эерэг сахилгын хэрэглээ, хүчирхийллийг мэдээлэх тогтолцоо), дүүрэг, үндэсний түвшинд (жишээ нь: багшийн сургалт, бодлого боловсруулах ажил) хэрэгжих хяналтын янз бүрийн түвшингүүдийг хамрах ёстой.

СХЖСХ-ийн АРГА ХЭМЖЭЭН ДЭХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ СОРИЛТУУД

Concern Worldwide байгууллагын захиалгаар хийгдсэн СХЖСХ-ийн долоон хөтөлбөрийн үнэлгээ (Leach нар, 2013) дараах гол бэрхшээлүүдийг тодорхойлсон. Үүнд:

- Хүүхдүүдтэй хүчирхийлэлд өртсөн талаарх туршлагыг ярилцахад тохирсон арга зүйг тодорхойлох нь хүндрэлтэй байдаг, ялангуяа албан байгууллагын орчинд.
- Нөлөөллийг хэмжих үзүүлэлтүүдийг боловсруулах – жинхэнэ, удаан хугацааны өөрчлөлт гарсныг хэмжихээс гадна төслийн зорилгыг хангаж буй байдлыг (жишээ нь: шилжүүлсэн кейсүүдийн тоо, сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо гэх мэт) хэмжих үзүүлэлт шаардлагатай. Нэг хөтөлбөрийн хувьд, ашигласан үзүүлэлтүүд нь хэт ерөнхий байсан тул үр дүнг бодитой хэмжих боломжгүй байжээ.
- Зан үйлийн өөрчлөлтийг хэмжих – хандлагын өөрчлөлтийг дангаараа зан үйлийн өөрчлөлтийн илрэл гэж үзэж болохгүй.
- Удаан хугацаанд сургуулийн орчинд ажиглалт хийх нь хүндрэлтэй, цаг их шаарддаг, өндөр зардалтай, зарим тохиолдолд халдлага мэт хүлээн зөвшөөрөгдөж болох ч бодит нотолгоонд суурилсан үнэлгээнд зайлшгүй хэрэгтэй бүрэлдэхүүн хэсэг юм.
- СХЖСХ-ийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний урт хугацааны үр нөлөөг хянах боломж нь хязгаарлагдмал, ихэвчлэн богино хугацаатай төсөл, санхүүжилтийн тогтолцоогоор хязгаарлагддаг.
- СХЖСХ-ийн хүрээнд хяналт, үнэлгээ хийх ажлын зорилгыг ойлгохгүй байх, тогтолцоо, чадавх дутмаг байх, институцийн хэмжээнд системтэйгээр хэрэгжүүлдэггүй нь томоохон бэрхшээл болдог.

Хүрээнд аль бүрэлдэхүүн хэсгийг хэн хариуцах вэ гэдгийг тодорхой заах хэрэгтэй. Мөн СХЖСХ-ийн хяналт, үнэлгээ хийх үед үүсэх ёс зүй, аюулгүй байдлын сорилтууд, эрсдэлүүдийг сайтар харгалзан үзэх шаардлагатай ба ажилтнуудыг энэхүү асуудлыг зохицуулах сургалтанд бүрэн хамруулсан байх ёстой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АХИЦ ДЭВШЛИЙГ ХЯНАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (INDICATORS TO TRACK PROGRESS)

СХЖСХ-ийн шалгуур үзүүлэлтүүдийг дараах зорилгоор ашиглаж болно:

- Хууль тогтоомж болон бодлогын шинэчлэлд чиг баримжаа өгөх
- Зорилтот, үр дүнтэй үйлчилгээний хүртээмжийг баталгаажуулах
- СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, түүнд хариу арга хэмжээ авах чиглэлээрх **хандлага, ахиц дэвшлийг хянах**
- Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр **нөлөөг үнэлэх**

Шалгуур үзүүлэлт боловсруулахдаа:

- СХЖСХ-ийн талаарх **олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн**, тухайн орон нутгийн онцлог байдлыг тусгасан **тодорхой, ойлгомжтой тодорхойлолттой** байх нь нэн чухал.
- **Цөөн шалгуур үзүүлэлт** нь СХЖСХ-ийн дэд бүрэлдэхүүн хэсгийг хянахад зориулагдаж болох ба жишээлбэл:
 - **Бие махбодын шийтгэл,**
 - **Бэлгийн дарамт** зэрэг тус бүрийн хүчирхийллийн төрлийг нарийн тодорхойлох нь маш чухал юм.

ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА 16: СХЖСХ-ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЖИШЭЭ

Чанарын шалгуур үзүүлэлтүүд (Qualitative Indicators)	Баталгаажуулах аргууд (Means of Verification)
1. Сургуулийн орчинд хүмүүжлийн зэрэг аргыг ашиглах нь нэмэгдсэн (багш, сургуулийн ажилтан, удирдлагын зүгээс) • Анги дотор зэрэг дүрэм журам боловсруулж, ил тод байршуулсан. • Хичээлийн үеэр багш нар сайшаал магтаал, зэрэг урамшууллын аргуудыг ашигладаг болсон. • Биемахбодын шийтгэлийг бүрэн халсан. • Сургуулийн түвшинд тодорхой, ойлгомжтой сахилгын бодлого боловсруулж, талуудад ойлгуулсан.	Ангийн ажиглалт, ярилцлага, фокус бүлгийн ярилцлага
2. Багш нарын хүүхэд төвтэй, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүнийг ашиглах байдал нэмэгдсэн	Ангийн ажиглалт, ярилцлага, фокус бүлгийн ярилцлага
3. Эцэг эх, орон нутгийн иргэдийн хөвгүүд, охидын боловсролыг эрх тэгш, ижил үнэ цэнтэй гэж үзэх мэдлэг, ойлголт нэмэгдсэн. • Орон нутгийн олон нийт СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, аюулгүй сургуулийн орчин бүрдүүлэх механизм тодорхойлж, арга хэмжээ авдаг болсон.	Орон нутгийн түвшний төлөвлөгөө, эхний ба эцсийн үнэлгээ (элсэлт болон хичээлийн ирцтэй уялдуулсан)

4. Сургуулийн хамт олны (багш, сурагч, ажилтан, дэмжлэг үзүүлэгч ажилчид) дунд хүйс болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадал зуршил нэмэгдсэн. • Хүчирхийллийг мэдээлэх механизмыг ойлгох мэдлэг нэмэгдсэн, ашиглах итгэл нэмэгдсэн. • Эхний үнэлгээтэй харьцуулахад тохиолдлыг мэдээлэх байдал нэмэгдсэн. • Мэдээлэгдсэн тохиолдлууд дээр арга хэмжээ авах хугацаа богиносж, чанар сайжирсан. • Хэн мэдээлэл өгч байгааг хянах – орон нутгаас ирүүлсэн тохиолдлуудыг хянадаг болсон.	Мэдлэг, хандлага, дадлын судалгааны эхний ба эцсийн үнэлгээ, эцсийн шатны нөлөөллийн үнэлгээ, ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, сургуулийн бүртгэл мэдээлэл, тохиолдлуудын баримтжуулалт
--	---

Чанарын шалгуур үзүүлэлтүүдэд дараах зүйлс багтана: охидын элсэлт, ирц, сургуульдаа үлдэх байдал болон сургуулиа төгсөх хувь нэмэгдсэн байх; охидын сурлагын амжилт сайжирсан байх. *(Тайлбар: Энэ тохиолдолд тоон үзүүлэлтүүд охидод төвлөрсөн байгаа ч, СХЖСХ-д өртөмтгий бусад бүлгүүдэд — жишээлбэл, хөвгүүд, ЛГБТИ хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэх мэт — тохируулан өргөжүүлэн ашиглах боломжтой.)*

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ДАТА МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БА СИСТЕМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТ

Нэгдсэн мэдээллийн систем нь зөвхөн өгөгдөл мэдээлэл цуглуулах, хадгалах, боловсруулах зорилготой байхаас гадна боловсролын бодлого боловсруулах, удирдах, үнэлэхэд туслах ёстой. UNESCO (2015b)

Сургуулийн түвшинд өгөгдөл цуглуулж, цаасан дээр эсвэл цахим хэлбэрээр төв систем рүү дамжуулдаг найдвартай, тогтвортой мэдээлэл цуглуулалтын систем нь үндэсний боловсролын тогтолцоог үр дүнтэй удирдах, төлөвлөх, хянах үндэс суурь болдог.

Олон орон **Боловсролын Мэдээлэл, Удирдлагын Систем (EMIS)**-ийг байгуулан, Боловсролын яамны хэрэгцээнд зориулсан үндсэн мэдээллийг удирдаж, түгээж байна. EMIS-ийн мэдээлэл нь:

- Судалгаа хийх
- Бодлого боловсруулалт ба төлөвлөлт
- Хяналт, үнэлгээ хийх бөгөөд энэ нь боловсролын нөөц, үйлчилгээний хуваарилалттай холбоотой шийдвэр гаргах үйл явцад ихээхэн ач холбогдолтой.

Одоогийн байдлаар цөөн хэдэн орон л СХЖСХ-ийн талаарх мэдээлэл болон үндсэн үзүүлэлтүүдийг үндэсний мэдээллийн системдээ нэгтгэж чадсан бөгөөд энэ нь СХЖСХ-ийн чиглэлээрх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад чухал алхам юм.

Түүнчлэн, сургуулийн, дүүргийн болон үндэсний түвшинд өгөгдөл цуглуулах, шинжилгээ хийх чадавх сул хэвээр байна. СХЖСХ-ийн талаарх өгөгдөл цуглуулахад тулгарч буй хүндрэлүүд нь I.соёл, шашны үнэт зүйлийн нөлөөн дор СХЖСХ-г хүлээн зөвшөөрөхгүй байдал, II. асуудлыг хүлээн зөвшөөрөх, хэлэлцэхээс зайлсхийх хандлага юм. Мөн энэхүү хүндрэлүүд нь эмзэг нөхцөлд болон зөрчилдөөнд буй улс орон, бүс нутгуудад илүү хүчтэй ажиглагддаг.

СХЖСХ-ийн гол шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд хэдийнэ оршин байгаа системүүдэд нь нэгтгэх явдал бол энэ асуудлыг тогтвортой байдлаар хянах, хариу арга хэмжээ боловсруулах **тогтвортой шийдэл** юм.

СХЖСХ-тэй холбоотой цуглуулж буй шалгуур үзүүлэлтүүд (жишээ нь: сургуулийн хүчирхийллийн тоон үзүүлэлтүүд) нь **EMIS** эсвэл сургуулийн эрүүл мэндийн судалгаа зэрэг бусад хэрэгслээр дамжин цугларч болох бөгөөд эдгээр өгөгдлийг сургуулийн орчин дахь хүчирхийллийг, охид, хөвгүүдийн дунд тархсан байдал гэх мэтийг ялган ойлгох анхны алхам болгон ашиглаж боломжтой.

СХЖСХ-ийн шинж чанар болон цар хүрээний талаарх мэдээлэл нь олон талт салбарууд хамтран хариу арга хэмжээ авахад бусад салбарын яамд (жишээ нь: хууль зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал) ч мөн ашиглах чухал эх сурвалж болдог.

План Интернэшнл байгууллагын хийсэн нэгэн судалгаа⁶³гаар, тус байгууллагын үйл ажиллагаа явуулдаг 49 орноос ердөө 7 л сургуулийн хүчирхийллийн тохиолдлуудыг бүртгэдэг системтэй байсан бөгөөд энэ мэдээллийг олон нийтэд нээлттэй болгодог орнуудын тоо бүр ч цөөн байжээ. Судалгааны хүрээнд тухайн орнуудад буй системүүд болон тэдгээрийн ашиглалтыг дараах төрлүүдээр ангилан зурагласан байна.

- Сургуулийн хүчирхийллийн тохиолдлыг бүртгэх үндэсний дата мэдээлэл цуглуулах систем
- Сургуулийн хүчирхийлэлтэй холбоотой цагдаагийн бүртгэл
- Сургуулийн хүчирхийлэлтэй холбоотой шүүхийн тогтолцооны бүртгэл
- Сургуулийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүл мэндийн тогтолцооны бүртгэл
- Сургуулийн хүчирхийлэлтэй холбоотой цагдаа, шүүх, эсвэл эрүүл мэндийн байгууллагуудын хоорондын мэдээлэл хуваалцах тогтолцоо
- Сургуулийн хүчирхийллийн талаарх нийтэд нээлттэй мэдээлэл

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ / ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ (Суурь судалгаа)

Нөхцөл байдлын шинжилгээ⁶⁴

Нөхцөл байдлын шинжилгээ нь олон талт нөхцөл байдлыг ойлгоход тусалдаг. Үүнд дараах зүйлс хамаарна:

- СХЖСХ-ийн шинж чанар, цар хүрээ, түвшин
- Үндсэн шалтгаан, эрсдлийн хүчин зүйлс
- СХЖСХ-тэй холбоотой гол оролцогчдын (охид, хөвгүүд, бэлгийн болон хүйсийн цөөнх) мэдлэг, хандлага, зан үйл
- Хүчирхийллийг мэдээлэх болон шилжүүлэх тогтолцоо
- СХЖСХ-тэй холбоотой хариу арга хэмжээ авах эсвэл мэдээллийг шилжүүлэх уялдаа холбоотой тогтолцоо байгаа эсэх, түүний хэрэгжилт
- Хүртээмжтэй дэмжлэгийн үйлчилгээ (албан ёсны болон албан бус)
- СХЖСХ-тэй холбоотой хууль, бодлого, төлөвлөгөө
- Боломжтой байгаа нөөц бололцоо
- Боловсролын салбар болон холбогдох бусад салбар дахь гол албан тушаалтнуудад зориулсан чадавх болон сургалтын боломжууд
- Хэрэгжиж буй сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөр, багш бэлтгэх тогтолцоо
- СХЖСХ-ийн чиглэлд ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагууд болон донор байгууллагууд

63 Global Guidance on addressing school-related gender-based violence, UNGEI, 2016, p-99

64 Fancy ба McAslan Fraser, 2014; UN Women, 2013b

Суурь судалгаа нь нөхцөл байдлын шинжилгээ, хэрэгцээний үнэлгээ, эсвэл тандалтын судалгаа гэж нэрлэгддэг бөгөөд СХЖСХ-ийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын талаарх суурь мэдээлэл ба өгөгдлийг цуглуулж, бодлого эсвэл хөтөлбөр боловсруулахад ашиглагддаг. Энэ хэсэгт авч үзсэн асуудал, үйл явц нь зөвхөн суурь судалгаанд бус, өөр олон төрлийн судалгаанд ч мөн адил хэрэглэж болно. Суурь судалгаа нь бодлого боловсруулагчид болон хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд дараах чиглэлээр тус болдог:

- СХЖСХ-ийн шинж чанар ба цар хүрээг ойлгох
- Үндсэн шалтгаан, эрсдэлд хамгийн их өртөж буй бүлгийг тодорхойлох
- Нөхцөл байдлын нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжлэх
- Боломжит сорилтуудыг урьдчилан харж, одоо байгаа боломжууд дээр тулгуурлан **бодлого, хөтөлбөр боловсруулах**

Мөн суурь судалгааг тоон судалгааны хэрэгсэл боловсруулахын өмнө (жишээ нь: асуулга, үндэсний мэдээллийн систем) ашиглаж болно. Энэ нь тухайн улсын нөхцөл байдалд онцгой хамааралтай СХЖСХ-ийн хэлбэрүүдийг илрүүлж, тэдгээрт чиглэсэн асуулгыг боловсруулахад тусалдаг.

ҮЙЛ ЯВЦ БОЛОН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ (EVALUATING IMPACT AND PROCESS)

Үнэлгээ нь бодлого боловсруулагчид болон хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд СХЖСХ-ийг таслан зогсоох арга хэмжээ нь нөлөө үзүүлсэн эсэхийг тодорхойлохоос гадна, тухайн арга хэмжээ нь холбогдолтой, үр ашигтай, үр дүнтэй, тогтвортой байсан эсэхийг үнэлэхэд тусалдаг⁶⁵.

Үйл явцын үнэлгээ нь хөтөлбөр зөв чиглэлд явагдаж байгаа эсэхийг шалгаж, засвар, сайжруулалт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлж, хэрхэн өөрчлөх талаар зөвлөмж өгч болдог. Үнэлгээний төрөл нь дараах хүчин зүйлээс хамааран ялгаатай байж болно:

- Үнэлж буй арга хэмжээний шинж чанар
- Үнэлгээний зорилго
- Нөхцөл байдал болон боломжит нөөц

Үнэлгээ нь дараах хэлбэрүүдтэй байж болно:

- **Суурь (formative) үнэлгээ** – хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө эсвэл хэрэгжилтийн явцад хийгддэг бөгөөд зорилго нь загвар, гүйцэтгэлийг сайжруулах
- **Дүгнэлтийн (summative) үнэлгээ** – хэрэгжүүлэлт дууссан хөтөлбөрөөс сургамж, туршлага гаргаж авахад зориулагддаг

ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРЛҮҮД БА СХЖСХ-ИЙН ХӨТӨЛБӨРТ АШИГЛАХ БАЙДЛЫН ТОЙМ		
Үнэлгээний төрөл	Тайлбар	СХЖСХ-ийн хөтөлбөрт яагаад хэрэглэх шаардлагатай вэ?
Загварын буюу урьдчилсан үнэлгээ (Design or ex-ante evaluation)	СХЖСХ-ийн хөтөлбөрийг төлөвлөх шатанд хийгддэг. Хөтөлбөрийн бодитой зорилгыг тодорхойлох, зардлын үр ашигтай байдал, хэрэгжих боломжийг үнэлдэг.	СХЖСХ-ийн хөтөлбөрүүд нь ихэвчлэн нарийн төвөгтэй нөхцөлд хэрэгждэг тул хөтөлбөрийн зорилт, хүлээгдэж буй үр дүнг бодитой тогтоох, төлөвлөлтийг дэмжихэд тусалдаг.

65 OECD DAC, 1991

Үйл явцын үнэлгээ (Process evaluation)	Хөтөлбөр болон бодлогын хэрэгжилтийн явцыг үнэлдэг.	СХЖСХ-ийн хөтөлбөр “яагаад” болон “хэрхэн” ажиллаж байгаа эсвэл ажиллахгүй байгааг тодруулахад тусална.
Гарц-зорилгын нийцэл буюу дунд шатны үнэлгээ (Output-to-purpose or mid-term evaluation)	Хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд шатанд хийгддэг. Хүрсэн үр дүн нь зорилтот түвшний үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг үнэлдэг.	Дунд шатанд эргэн харах, шаардлагатай тохиолдолд чиглэлээ өөрчлөх боломжийг олгодог. Туршлагыг бодит хэрэгжүүлэлт болгон хувиргахад тохиромжтой. Хөтөлбөрийн загварыг баталгаажуулахад бага тохиромжтой.
Үр дүнгийн үнэлгээ (Outcome evaluation)	Хөтөлбөрийн төгсгөлд СХЖСХ-ийн талаарх мэдлэг, хандлага, зан үйлийн богино болон дунд хугацааны өөрчлөлтөд төвлөрдөг.	Шуурхай шийдвэр гаргах шаардлагатай үед (жишээ нь: хөтөлбөрийг сунгах эсвэл бодлого боловсруулах) ашигтай. Үр дүнгийн түвшинд гарч буй өөрчлөлтийг ойлгоход дэмжлэг үзүүлдэг.
Үр нөлөөний үнэлгээ (Impact evaluation)	Хөтөлбөр, төсөл, бодлого зэрэг тодорхой оролцооны улмаас гарсан өөрчлөлтүүдийг үнэлдэг. Ихэвчлэн эсрэг нөхцөлийг харьцуулан шинжилдэг (бодит байдалд юу болсон болон уг арга хэмжээг хийгээгүй тохиолдолд юу болох байв).	Ихэвчлэн урт хугацааны нөлөөлөлд чиглэнэ (жишээ нь: СХЖСХ-ийн тархалт, нийгмийн хандлагын өөрчлөлт). Гэсэн ч дунд хугацааны үр дүнг хамрах тохиолдол элбэг, ялангуяа 3–5 жилийн дараа үнэлэхэд тохиромжтой.

Одоогийн байдлаар сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг арга хэмжээний судалгаа, үнэлгээний ихэнх нь бага хүрээнд чанарын судалгаа байсаар ирсэн. Эдгээр нь голчлон тухайн арга хэмжээний үр нөлөөг дүгнэхэд чиглэж, өргөн цар хүрээтэй бодлого боловсруулах эсвэл хөтөлбөрийг өргөжүүлэхэд хангалттай ашиглагдаж чаддаггүй байна. Энэ нь зарим талаар дараах шалтгаантай холбоотой:

- Нарийн, чанартай үр нөлөөний үнэлгээ хийхэд их хэмжээний хугацаа, зардал шаардлагатай байдаг.
- СХЖСХ-ийн судалгаанд зайлшгүй шаардагддаг нэмэлт арга зүйн, ёс зүйн болон аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнүүд-тэй холбоотой.

АРГА ЗҮЙ, ЁС ЗҮЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРГАЛЗАХ АСУУДЛУУД

(СХЖСХ-ийг хэмжих арга зүйд харгалзан үзэх асуудлууд)

Сургууль дээрх жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх судалгаа нь арга зүйн хандлагад маш эмзэг байдаг. Иймд СХЖСХ-ийн талаарх өгөгдөл цуглуулж буй судлаачид дараах арга зүйн асуудлуудыг заавал харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд,

- СХЖСХ-ийн тодорхойлолтууд: Судалгааны аль ч загварт, “дайрах”, “хүчирхийлэл”, “бие махбодын шийтгэл” гэх мэт өргөн хүрээтэй, олон янзаар тайлбарлагдаж болох ойлголтуудаас зайлсхийх. Үүний оронд, тодорхой, бодит үйлдлүүдийг нэрлэн бичих нь илүү үр дүнтэй байдаг. Энэ нь

тайлбарлах хэлбэрийн ялгааг багасгаж, судалгааны үнэн зөв байдлыг сайжруулна. Жишээлбэл, дараах үйлдлүүдийг шууд нэрлэх нь илүү ойлгомжтой:

- “Миний хөхөнд хүрсэн”
- “Гадаад төрхийг минь дооглон доромж үг хэлсэн, доог тохуу хийсэн”
- “Найзгүй болгож ганцаардуулна гэж айлгасан”
- “Намайг алгадсан”
- “Бэлгийн харьцаанд орвол сайн дүн өгнө гэж санал тавьсан”
- **Цаг хугацааны хүрээг тодорхой болгох:** СХЖСХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархалтыг үнэлэх судалгаанууд нь янз бүрийн цаг хугацааны хязгаарыг ашигладаг. Жишээлбэл:
 - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн олон улсын судалгаа (VACS) нь янз бүрийн төрлийн хүчирхийлэлд өртсөн “сүүлийн 12 сарын хугацаанд” ямар туршлага байсан болон анх хэдэн настайд өртсөн талаар асуудаг.
 - План Интернэшнл болон Эмэгтэйчүүдийн Судалгааны Олон Улсын Төв-өөс (2011 онд) Азийн таван улсад хийсэн СХЖСХ-ийн судалгаа нь “сүүлийн 6 сарын хугацаанд” сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн эсэхийг асуусан байдаг.

Мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөл – Суурь зарчмууд

Gallagher (2009)-ын тодорхойлсноор мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрлийн дараах суурь зарчмууд байдаг:

1. Зөвшөөрөл нь илэрхий байх ёстой — жишээлбэл аман эсвэл бичгээр өгсөн зөвшөөрөл.
2. Зөвшөөрөл нь оролцогчид судалгааны талаарх мэдээлэлтэй, ойлгож байгаа тохиолдолд л хүчинтэй байна.
3. Зөвшөөрөл нь албадлагагүй, сайн дурын үндсэн дээр өгсөн байх ёстой.
4. Зөвшөөрлийг дахин хэлэлцэх боломжтой байх ёстой — өөрөөр хэлбэл, хүүхэд судалгааны аль ч шатанд оролцохоос татгалзах эрхтэй.

СХЖСХ-ийг хэмжихэд баримтлах ёс зүй, аюулгүй байдлыг харгалзан үзэх асуудлууд

СХЖСХ-ийн судалгаа болон хяналт-шинжилгээ, үнэлгээ (M&E) хийх нь хүчирхийлэлтэй холбоотой эмзэг сэдвүүд, хүйс болон бэлгийн чиг баримжаатай холбоотой гүнзгий тогтсон хандлагууд, өрөөсгөл ойлголтуудын хүрээнд хүүхэд, өсвөр үе, залуустай ажиллахад тулгардаг ёс зүй ба аюулгүй байдлын олон сорилтыг үүсгэдэг.

Хүүхэд, өсвөр насныхныг хамарсан судалгаа нь заавал Олон улсын хүүхэд оролцуулсан судалгааны ёс зүйн дүрэм⁶⁶-ийн дагуу явагдах ёстой.

Хүүхэдтэй судалгаа хийхэд тулгардаг нийтлэг ёс зүйн асуудлуудаас гадна, хүчирхийлэлтэй холбоотой тусгай нөхцөл, эрсдэлийг заавал харгалзан үзэх шаардлагатай. Хэдийгээр СХЖСХ-ийн судалгаанд зориулсан тусгай удирдамж одоогоор байхгүй ч, эмэгтэйчүүд ба охидын эсрэг хүчирхийллийн судалгаатай холбоотой дараах хэрэгцээтэй эх сурвалжуудыг СХЖСХ-ийн M&E болон судалгаанд нийцүүлэн ашиглаж болно. Үүнд:

- ДЭМБ-ын “Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл”-ийн талаарх ёс зүйн болон аюулгүй байдлын зөвлөмж (2001)
- “Онцгой байдлын үед гардаг бэлгийн хүчирхийлэл”-ийн талаарх зөвлөмж (2007) зэрэг орно.

Жишээлбэл, ДЭМБ (2001)-д дараахыг зөвлөмж болгосон байдаг:

⁶⁶ UNICEF: <http://childethics.com/charter/>

“Судалгааны талбар дээр ажиллаж буй судлаачид тусламж хүсэж буй эмэгтэйчүүдийг орон нутгийн боломжит дэмжлэгийн үйлчилгээ, эх сурвалж руу чиглүүлж чадах чадвартай байх ёстой. Хэрэв боломжит дэмжлэг байхгүй бол судалгааны баг богино хугацааны дэмжлэгийн механизм бий болгох шаардлагатайг үгүйсгэхгүй.”

Энэхүү агуулгыг “эмэгтэйчүүд” гэдгийг “хүүхдүүд” болгон өөрчилж, СХЖСХ-ийн судалгаанд тохируулан хэрэглэх боломжтой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ III

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЭНГИЙН АРГА ХЭМЖЭЭ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭНГИЙН АРГА ХЭМЖЭЭ

АНГИ ТАНХИМД САХИЛГА БАТ ТОГТООХ ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГУУД

Хэцүү хүүхэдтэй ажиллах нь: Ангид сахилга бат тогтоох аргууд⁶⁷

(Жастин Лим, Рөүзменд ахлах сургууль, АНУ, Өмнөд Калифорни)

Худал хэлэх, хулгай хийх, зодолдох, зугатах, хараал хэлэх, бусдыг санаатайгаар гэмтээх, өшиглөх, уурсаж орилох гээд “зан төлөвийн асуудалтай” хэмээн үзсэн хүүхэдтэй өдөржин зууралдсаар байгаад багш таны тэвчээр алдагдаж байв уу? Жастин Лим багш ийм байдалд орж үзсэн ба багш нарт болон зан төлөвийн өөрчлөлттэй хүүхдэд хичээлийн жилээ үр бүтээлтэй болгоход нь туслах үүднээс зарим зөвлөмжийг хуваалцжээ. Зан төлөв, харилцааны асуудалтай хүүхэд хэзээд байдаг, багш нар тэргүүн шугаманд зогсож өдөржингөө тэдэнтэй нүүр тулдаг. Ийм хүүхдүүд багшийг толгойныхоо үсийг зулгаахад хүргэдэг, уйлуулдаг, ажлаасаа гарах хүртэл тэвчээрийг нь бардаг. Гэвч хүнд бэрх хэдий ч олон жилийн дараа таныг өөрийнхөө ажлыг хүндэтгэн үздэг нэгэн болгох, багшлах ажилд өөрийгөө зориулсан шалтгааныг тань танд сануулах хүмүүс бол чухам тэдгээр хүүхдүүд юм. Учир нь та энэ хүүхдүүдэд асуудлаа шийдвэрлэхэд нь тусалсан, тэднийг хайрласан нэгэн байсан гэсэн үг. Та ангийнхаа хүүхдүүдийн зан байдлыг зохицуулахдаа хэрэглэдэг аргатай байж магадгүй. Жастин Лим багш ангидаа цаасан тавгаар хийсэн гэрлэн дохио ашигладаг байна. Энэ бол сайн зан чанарыг бататгаж, дүрэм журам эвддэг зан байдлыг илрүүлдэг арга юм. Хүүхдүүдийн нэрсийг хувцасны хавчаар дээр бичээд ногоон тавганд хавчдаг. Дүрэм зөрчсөнийхээ дараа хүүхдүүд өөрсдийнхөө нэрийг шар гэрлэн дохио руу нүүлгэж хөдөлгөнө, өөрөөр хэлбэл, тэд үүргээ зөрчсөн тул надад 10 минутын завсарлага өгөх үүрэгтэй. Хэрвээ тэд улаан гэрэл рүү нүүвэл надад 20 минутын завсарлага өгөх үүрэгтэй ба гэр рүүгээ санамж бичиг авч явна. Ерөнхийд нь хэлэхэд, ангийн 80 орчим хувьд энэхүү арга сайн үйлчилдэг. Ойролцоогоор хүүхдүүдийн 10 хувь нь сургууль дээрх бүх хугацаандаа сахиусан тэнгэр мэт төгс байдаг. Тэдэнд энэ арга онцын хэрэгцээгүй. Үлдэх 10 хувийн хүүхдэд харин энэ арга төдийлөн цогц биш учраас зан байдлаа бүрэн дүүрэн зөөлрүүлэхэд хангалтгүй, нөгөө талаар тэдний зан байдал нь маш хурц тул тэдэнд илүү хурдан, онцгой үр дүнд хүрэх хөхиүлэн урамшуулах систем хэрэгтэй болдог. Тэр бэрхшээл үүсгэдэг 10 хувийн хүүхдүүдийн талаар ярилцъя.

“Хэцүү” сурагчдад зан араншин, зан үйлээ засахад туслахын тулд БАГШ таны хийж болох 10 зүйл

Хүүхдийн талаарх нэгдсэн тайланг хянаж үзэх.

Заримдаа өмнөх багшийн үлдээсэн тэмдэглэл, хүүхдийн зан байдлын тодорхойлолт, гаргаж буй зан араншингийн шалтгаан юу болох, бусад санамж зөвлөмж бүхий хувийн нууцлалтай хавтас хэрэглэж болно.

⁶⁷ “Тэгш хамруулах боловсрол, хүүхэд хамгааллын сайн туршлага”, “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он

Зан үйлийг баримтжуулах

Энэ нь таныг хүүхдийн зан байдлын хэв маягийг илрүүлсэн тодорхой баримттай болгохоос гадна ихэвчлэн ямар төрлийн ааш авир гаргаж буйг харах боломж олгоно.

Хүүхдийн өмнөх багш нартай ярилцах.

Өмнөх багш нарт нь хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын талаар зарим санаа бодол, мөн хүүхэдтэй ажиллахад юу нь сайн байсан талаар ашиг тустай зөвлөмж байж магадгүй.

Захиралтайгаа нөхцөл байдлын талаар ярилцах.

Танай ангид юу болоод байгаа, цаашид танд дэмжлэг хэрэг болж магадгүйг захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтандаа урьдчилж хэлж мэдэгдээрэй. Манай сургуулийн захирал манай ангид хичээл заах, сурагчийг ангиас хэсэг хугацаагаар гаргахаас эхлээд тус болох зөвлөгөөг сэтгэл харамгүй өгч, урам хайрладаг юм.

Эцэг эхтэй нь уулзах

Хааяа эцэг эхчүүд хүүхдийн зан байдлыг засах таны томоохон холбоотон, хааяа тэд нөгөө “болохгүй” асуудлыг үүсгэж буй эх үүсвэр байдаг. Ихэвчлэн эцэг эхчүүд ТАНД болон хүүхдэдээ туслахыг хүсдэг! Тэдний туслалцаа, оролцоо бол хүүхдээ өөрийгөө хянаж сурахад туслах маш хүчирхэг хэрэгсэл юм. Гол нь харилцаа холбоо!

Бататгал, үр дагавар болон хөхиүлэн дэмжих талаар туйлын тууштай байх.

Эдгээр төрлийн хүүхдүүд ихэвчлэн улаан шугам давах, хил зааг зөрчих, багшийг сорихдоо үнэхээр чадварлаг байдаг. Хана шиг бат бэх байгаарай.

Сургуулийн захирал, зөвлөх, бусад багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг хүмүүсээс тусламж эрж утасдахад бэлэн байх.

Зарим зүйлс таны ганцаараа учрыг нь олж чадах, зохицуулах чадварын хүрээнээс хэдий нь хальсан байдаг.

Зан байдлын гэрээ хийх эсвэл одны хүснэгт зохиох

Эцэг эхтэй нь уулзах үедээ би “Зан байдлын гэрээ” байгуулахыг санал болгодог. Өдөр бүр гэр, сургууль хоёрын хооронд явдаг энэ цаас (гэрээ) бол үндсэндээ сурагчийн эерэг, сөрөг зан чанарыг баримтжуулахад ашиглагдах бөгөөд хүүхдүүдэд урам өгч хөхиүлэх эсвэл сөрөг үйлдээ тунгаахыг сануулдаг. Мөн “Харилцах дэвтэр”-ийг санал болгодог. Энэ нь эцэг эхчүүдээс сурагчийнхаа талаарх дараах зүйлийг мэдэж авахад ихээхэн дөхөмтэй байдаг. Үүнд:

– Өглөө хэрхэн яаж эхлэв?

– Бүтэлгүй эсвэл зарим нэг онцгой зүйлс тохиолдсон уу? “Харилцах дэвтэр” нь өдрийн турш сурагчдад тохиолдсон эерэг хийгээд сөрөг үйл явдал, тэдгээрийн үр дагавар, цаашдаа тухайн хүүхдийн урам зоригийг хөхиүлэн дэмжихэд туслах мэдээлэл өгдөг. Миний хувьд, сайшаал магтаал болон эерэг, сөрөг зан чанаруудыг нь баримтжуулж бичих зэргээр дэвтрийг ашигладаг. Эцэг эхчүүд өдөр бүр “Харилцах дэвтэр”-тэй танилцан хүүхэдтэйгээ тухайн өдрийнх нь зан зан үйлийн талаар ярилцсаны дараа гарын үсгээ зурдаг. Цахим шуудангаар харилцаж болох ч, тэр нь хэдий хялбар ч гэлээ би хүүхдэд “чи өөрөө сонголт хийдэг, түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг юм шүү!” гэсэн санааг сурагчдад ойлгуулахыг хүсдэг.

Урамшуулал болоод үр дагаврын талаар хэлэлцэхдээ хүүхдүүдийг оролцуулж байх

Эерэг эсвэл сөрөг үр дагаварт хүргэдэг хүн нь хүүхдүүд өөрсдөө байдгийг тэд ойлгож байгаа эсэхийг баталгаажуулаарай. Хүүхдүүдийг урамшуулахдаа өөрсдөд нь чухал, урам өгөхүйц аргыг сонгох хэрэгтэй. Дараа нь тэд өөрийн хийж буй сонголтынхоо төлөө санаа тавьж хичээх магадлалтай. Ихэнх хүүхдүүдийн хувьд гэртээ байх нь том асуудал биш ч гэлээ ТВ, компьютер, видео тоглоомгүйгээр тэд гэрээ төсөөлөхгүй байж мэднэ. Хүүхдэд хамгийн үнэ цэнтэй зүйл юу болохыг олж мэдээрэй.

Эхлээд томоохон сөрөг зан авирыг шийдвэрлэж, жижиг ааш занг үл хэрэгсэх

Энэ маш хэцүү. Манай ангид нэг сурагч байлаа. Тэрээр бараг өдөр бүр бусад сурагчтай зодолддог тэгээд ч зогсохгүй багшийгаа өшиглөж, цохисон. Би түүний ямар ч бодолгүй чалчих, алиалах, анхаарал татах гэсэн бусад ааш занг нь хайхрахгүй байх ёстой байсан л даа. Эхлээд би түүний гар, хөл, эд зүйлсээ хянаж, хөдөлгөөнгүй байлгаж, өөрийгөө хянасан өдрүүдийг тэмдэглэсэн. Тэгээд тэр үүндээ нэлээн тууштай болж эхлэнгүүт бид тохирсон хариу үйлдэл хийхээр ажилласан юм. Хэдийгээр би түүний тал дээр маш хатуу байр суурьтай байсан ч жилийн эцэст тэр намайг чанга тэвэрсэн юм даа. Тэр намайг “хамгийн сайн багш байсан” гэж хэлээд, миний тэвчээр гаргаж байсанд, мөн түүнд өөрийгөө хянаж сурахад нь тусалсанд талархсан.

ШАГНАЛЫН 11. СТРЕССЭЭ ТАЙЛАХ, ДОТРОО ОНГОЙЛГОХ, ТАЙВШРАХ АРГА ЗАМ ҮРГЭЛЖ БАЙДАГ

Багшийн ажил бол нэг талаараа гайхалтай, нөгөө талаараа стресстэй ажил. Хэрвээ танай ангид ааш зангийн өөрчлөлттэй хүүхэд байгаа бол улам л их стресстэнэ. Нэг жил би бусад багш нараас хэрвээ манай ангид намайг 30 минут орловол оронд нь биеийн тамир, зургийн хичээл заах санал хүртэл тавьж байв. Зарим жилүүдэд биеийн тамир, зургийн ангид өөрийгөө хөгжүүлэхийн тулд орж байлаа. Хааяадаа кино үзэж эсвэл номын ертөнцөд татагдан орж өөрийгөө умартан бухимдлаа тайлж байв. Ингэснээр сэтгэлийн зовууриасаа салж дараагийн өдөрт арга барил, хандлагаа өөрчилж, эрч хүчээ сэлбэсэн хүн сургуульдаа ирж чаддаг байлаа. Та юунд тайвширч байгаагаа олж мэдэн, ядарч туйлдсан өдрөө өөрийгөө хайрлах, эмчлэх арга хэмжээ авч байгаарай. Та ганцаараа биш шүү.

ҮЕ ТЭНГИЙХНИЙ ДУНДАХ АСУУЛГА (Korean-Peer Nomination Inventory)⁶⁸

Солонгос Улсад сургуулийн орчин дахь дээрэлхэлтийг илрүүлэхэд АСУУЛГА ашигладаг. Уг санал асуулга нь хүүхдүүдийн нийгэмд дасан зохицох чадваргүй байдлыг шалгах ажлын нэг хэсэг болдог бөгөөд үе тэнгийнхний дунд ил болон далд хэлбэрийн гадуурхалтыг илрүүлэх зорилгоор үе тэнгийнхний санал асуулгад суурилсан байна. Хүүхдүүд санал асуулгыг бөглөхдөө сэдэв тус бүр дэх зан төрхийн тодорхойлолтод нийцэх ижил хүйсийн сурагчдын нэрсийг дурдах боломжтойн зэрэгцээ сэдэв тус бүр дээр хэд хэдэн сурагчийн нэрийг дурдахыг зөвшөөрдөг. Үе тэнгийнхний санал асуулгын дундаж оноо нь өгөгдсөн категорид нэр дурдагдсан сурагчдыг илрүүлэх төдийгүй гадуурхалтын өнгө аясыг тодорхойлох ач холбогдолтой. **Бид ч бас нэгдэж байна хөдөлгөөн (Me too)** хөдөлгөөн нь олон улсад жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, кейсээ хуваалцах хөдөлгөөн болон өрнөсөн. БНСУ-д олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиал медиа ашиглан санал асуулга явуулах хэлбэрээр сургуулийн орчинд үе тэнгийнхэндээ дээрэлхүүлсэн болон сургуулийн хүчирхийллийн талаарх мэдээллийг ил тод болгох хөдөлгөөн болгон зохион байгуулсан. Уг хөдөлгөөнийг өрнүүлсээр Солонгосын урлаг, соёл, спортын олон одуудын өсвөр насандаа үйлдсэн дээрэлхэлтийн тохиолдлууд ил болж, нэр хүнд, карьерт нь сөрөг үр дагаврыг авчирснаар бусад улс орнуудад ч cancel culture болон өргөжин тэлж байна.

68 Korean-Peer Nomination Inventory <https://jamanetwork.com/journals/jamapediatrics/fullarticle/485789>

АНГИ ТАНХИМААС ГАДУУР ХҮРЧ АЖИЛЛАХ⁶⁹

АНУ-ын Калифорни мужийн Оукленд хотын Лайф Академи хэмээх улсын жижгэвтэр ахлах сургуулийн багш Дебби 20 орчим сурагчтай холимог ангийг хариуцан зөвлөгөө өгч ажилладаг аж. Тэрээр сургууль дээр зөвлөгөө өгдөг багш байхаас гадна сурагчдынхаа ахуйн орчинтой танилцан илүү дотно холбоо тогтоохын тулд сурагчдын гэрээр явж эхэлжээ. Хичээл заадаг багшаас ялгаатай нь зөвлөх багш бол сурагчдын тодорхойлолт бичих, бусад багш нараас өмгөөлж хамгаалах, өдөр бүрийг хэрхэн өнгөрөөснийг нь асууж санаа тавьдаг чухал хүн юм. Эхний удаад Дебби шинэ элссэн 4-5 сурагчийн гэрт очиж уулзжээ. Анхандаа сурагчдын эсэргүүцэлтэй тулгарсан ч хойтонгоос нь сурагчид зөвөөр ойлгож эхэлсэн байна. Энэ нь сурагчдын итгэлцлийн харилцаатай холбоотой байлаа. Тэрээр тулгарч асан бэрхшээлийнхээ талаар хуваалцахдаа: *“Мэдээжийн хэрэг, сурагчдынхаа гэрт очих нь тэр болгон амар байгаагүй. Би нэг удаа ээж нь хурал дээр хувирамтгай, бүр дайсагнах янзтай байдаг Пейтоны гэрт очсон юм. Пейтон бага ангиасаа эхлэн олон удаа асуудалд орж байсан тул ээжтэй нь урьд хэд хэдэн удаа уулзаж байв. Түүний гэрт намайг албан ёсоор хүлээн авсан боловч биднийг дөнгөж уулзангуут Пейтоны олон дүү нь ээжийнхээ анхаарлыг татах гэж шуугилдаж эхэлсэн. Сүүлийн жилүүдэд Пейтоны үлгэр дууриалаа болгодог эрчүүдийн гурав нь бусдын гарт амиа алдсаныг ээж нь надад ярьсан юм. Бодит байдалтай нүүр тулснаар надад урьд өмнөхөөсөө илүү хүч чадалгүй болсон мэт мэдрэмж төрсөн хэдий ч, би түүний гэр бүлийн амьдралыг зэрвэсхэн ч гэсэн харсандаа баяртай байсан. Би түүний гэрт тавгүй байсан шиг, ээжид нь сургууль дээр ирэхэд мөн адил таагүй мэдрэмж төрдөг байх даа гэж би төсөөлж байлаа. Өөр үр дүн гараагүй ч энэхүү уулзалт надад Пейтон болон түүний гэр бүлийн зовлонг түр ч гэсэн мэдрэх боломж олгосон юм”* гэжээ. Ялангуяа “хэцүү” гэгддэг сурагчдын гэрээр очиж уулзах нь ихээхэн үр дүнтэй бөгөөд энэ талаар, *“Сурагчдынхаа гэрээр явахын ач тусыг би энэ жил дахин мэдрэсэн. Учир нь манай хамгийн хэцүү сурагчдын нэг хэдэн долоо хоног сургуульдаа ирэхгүй байлаа. Сургуульдаа явахгүй байгаа учрыг олж мэдэх гэж цахим шуудангаар харилцсан боловч гэр бүлтэй нь холбогдож чадаагүй. Сурагчид ч түүний хаана байгааг, яагаад багш нарын нэг нь ч мэдэхгүй байгааг асууж эхлэв. Яг тэр үдэш түүний хичээлээс гадуурх ажлын гурван удирдагч/ментор гэрт нь хамт очиж, маргааш нь тэр хичээлдээ буцаж ирсэн юм. Гэрээр нь очсон явдал залуу хүүд илэрхий эерэг нөлөө үзүүлсний зэрэгцээ энэ нь сургууль даяар тархсан.”* гэв. Энэ явдал бусад сурагчдад хамгийн их төвөг учруулдаг сурагчдын төлөө зөвхөн ангийн багш нар бус сургуулийн бусад хүмүүс буюу удирдлагууд анхаарал тавьдаг төдийгүй сургуульдаа ирэхгүй байх нь энгийн үзэгдэл биш, ямар ч асуудалтай сурагч байсан сургууль бол “ээлтэй орчин” гэдгийг ойлгоход тус болжээ.

СУРАГЧИЙН ГЭРЭЭР ЯВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

(гэрээр явахад үр дүнд хүрч мэдэх зөвлөмж)

1. Нэг ч сурагчид ялгаварлагдсан мэт мэдрэмж төрүүлэхгүйн тулд гэрээр нь явахыг ангийнхаа эсвэл сургуулийнхаа соёлын нэг хэсэг болгоорой.
2. Багш та өөртөө хэт ачаалал үүсгэхгүйн тулд хэний гэрээр явахаа урьдчилж журамлаарай.
3. Гэрээр явах хугацааг хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөндөө тодорхой тусгаарай.
4. Гэрээр явахдаа өөртөө ч өрөөлд ч уян хатан хандаарай. Эцэг эх, асран хамгаалагчдад өдөр, цагийг тогтоох, сонгох боломж олгоорой.
5. Сурагчийн гаргасан амжилтын (сурлага, хүмүүжлийн, оролцооны) талаар тодорхой нэг жишээг гэр бүлтэй нь хуваалцахдаа үргэлж бэлэн байгаарай.
6. Сурагчийн хичээлийн дүн, гаргасан бүдүүлэг зан авирын тухай гэр бүлд нь зочлохдоо огт ярих хэрэггүй. Энэ бол гэр бүлтэй нь танилцах цаг гэдгийг санаарай. Тэднээс хүүхдийн сонирхол, мөрөөдлийг нээлттэй асуугаарай.
7. Сурагчаасаа гэрийн даалгавраа гэрийнхээ хаана хийдгийг асууж, харуулахыг хүсээрэй.
8. Гэр бүлд нь гэртээ ирэхийг зөвшөөрсөнд заавал талархал илэрхийлээрэй.

⁶⁹ Тэгш хамруулах боловсрол, хүүхэд хамгааллын сайн туршлага”, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД ЗОРИУЛСАН ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГУУД

ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ТАНЫ ХУВЬ НЭМЭР⁷⁰


Таны ХҮҮХЭД хэрхэн том болж байгааг харуулахын тулд цөөн сонирхолтой баримт дурдъя. Үүнд:

- Хүүхэд эхийн хэвлийгээс төрсөн эхний 1000 хоног амин чухал. Уураг тархи ид хөгждөг үе.
- Эхээс мэндлэхдээ 100 сая орчим тархины эстэй мэндэлдэг. Дахиж төлжиж бий болохгүй, харин хөгшрөх тусам улам багасч буурдаг.
- Амьдралын эхний 1000 хоногт үлдсэн амьдралдаа ямар хүн болох мэдээлэл, дадал хэвшлийн 80 хувийг олж авдаг.
- Эхний 10 жилд насанд хүрсэн хүнээс 2 дахин илүү хурдан өсөж томордог.
- Секунд тутам 700–1000 эсийн холбоос (шинэ мэдлэг) үүсдэг.
- 3 настай хүүхдийн уураг тархи насанд хүрсэн хүнийхээс 2 дахин илүү идэвхтэй байдаг.
- 3 настай хүүхэд хоол тэжээлээр олсон энергийнхээ 50–75 хувийг өөрийнхөө уураг тархийг тэжээхэд хэрэглэдэг.

Бага насны хүүхэд улам өсөж дэвжих үндэс нь боловсрол юм. Ази Номхон далайн бүсийн Бага насны хүүхдийн сүлжээнээс хүүхдийн хөгжлийг дараах багц шалгууруудаар үнэлдэг. Үүнд,

- Танин мэдэхүйн
- Нийгэмшихүй-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил
- Булчин, хөдөлгөөний хөгжил
- Хэл яриа-бичиг үсгийн бэлтгэл
- Эрүүл мэнд, эрүүл ахуйн, аюулгүй байдал
- Соёл, зан заншлын мэдлэг, оролцоо
- Сурах хандлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан, Монгол Улс нэгдэн орж дагаж мөрддөг Хүүхдийн эрхийн тухай Конвенцид хүүхдэд олгох боловсролын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Иймээс таны хүүхэд ямар хүн болж байгааг мэдэхийн тулд энэ дөрвөн чиглэлээр боловсрол эзэмшиж байгаа эсэхийг ямагт нягталж байгаарай.



Та хүсвэл хүүхдэдээ дараах шинж байгаа эсэхийг нягтлаарай.

⁷⁰ “Эцэг эхэд зориулсан аяны богц”, Боловсрол эвсэл, 2017 он <https://www.uih.mn/sudalгаа/s/397>

- **Орчин цагийн нүүдэлчин** – Байгальтай эвсэн амьдарч, орчин цагийн шинжлэх ухааны ололт, дэвшлийг амьдрал, аж ахуйдаа нэвтрүүлэн ашигладаг, нүүдлийн соёлын өвийг тээгч байна.
- **Тэсвэртэй хүй олны гишүүн**– Нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг давж, эргэн амьдрал ахуйгаа сэргээн босгох чадвартай нийгмийн бүлгийн төлөөлөл байна.
- **Эгэх хариуцлагатай, идэвхтэй иргэн** – Төрийн үйл хэрэгт хуулийн дагуу хүчирхийллийн бус аргаар сайн дураар чөлөөтэй оролцож, өөрийн амьдралд хамаарах шийдвэр гаргахад утга учиртай шууд оролцдог иргэн байна.
- **Хүлцэн тэвчдэг хувь хүн** – Ялгаатай байдлыг ямар нэгэн ташаа бодол, ялгаварлан гадуурхалтгүйгээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, бусадтай зэрэгцэн амьдарч чаддаг нэгэн байна.

Эцэг эх, гэр бүл нь хүүхдүүдийн сурч боловсрох үндсэн суурь орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Тиймээс эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн сургуульд суралцах бүхий л явцад боловсролын байгууллагын амин чухал бөгөөд зайлшгүй хамтран зүтгэгчид юм.

ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ АРГУУД⁷¹

Бид хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй. Хүүхдийг хэзээ ч айлгаж, сүрдүүлж, ичээдэггүй. Хүүхдүүдийг зодохгүй бол тэд хүмүүжилгүй болно, тэд ямар сонголт хийхээ мэдэхгүй, тэднийг ямагт хянаж байх хэрэгтэй гэж зарим хүмүүс боддог. Эерэг сахилга бат/хүмүүжлийг төлөвшүүлнэ гэдэг нь хүүхдийг хийсэн үйлдлийнх нь үр дагавраас мултална гэсэн үг биш. Эерэг хүмүүжлийн үр дагавар нь үйлдэлдээ тохирсон шударга, тууштай байх бөгөөд зорилго нь хүүхдийг доромжлоход бус, биеэ авч явах байдлыг нь засаж залруулахад чиглэсэн байна гэсэн үг. Хүүхдүүдийг шийтгэхэд биш гаргасан алдаанаасаа суралцах боломж олгоход чиглэдэг. Хүүхдийг зодох, загнах нь илүү амархан, тэр дор богино хугацаанд үр дүнгээ өгдөг: хүүхэд таны үгэнд орно, хийж байсан үйлдлээ зогсооно. Гэхдээ... таныг хараагүй үед нөгөө үйлдлээ хийж магадгүй, танаас юм нууж, магадгүй худлаа хэлж сурна. Эерэг сахилга батыг төлөвшүүлэх нь илүү хэцүү, илүү их хичээл зүтгэл шаардана, гэхдээ үр дүн нь тогтвортой бөгөөд хүүхдийн амьдралд чанарын ялгаатай.

Эерэг сахилга батыг төлөвшүүлэхэд туслахын тулд 4 түвшний арга хэмжээ ашигладаг	
Эргэцүүлэл	Өдөр тутмын жижиг сажиг асуудал гарахад: ○ хүүхдүүдэд хийсэн зүйлийнхээ тухай эргэцүүлэн бодоход туслах
Торгууль	Давтагдаад буй асуудалд: ○ Хүүхдүүдэд үйлдлийнхээ үр дагаврыг ойлгоход нь туслах
Залруулга	Хохирол гэмтэл учруулсан үйлдэлд: ○ Хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээж сурахад нь туслах
Эцсийн арга хэмжээ	Ноцтой зөрчил гаргахад: ○ Хүүхдүүдээ зан үйлээ засахад шаардлагатай туслалцаа авахад туслах

1. Эргэцүүлэл

Өдөр тутмын жижиг асуудлууд гарахад хүүхдэд хийсэн буруу зүйлийнхээ талаар бодож, эргэцүүлэхийг санал болгоно. Хийсэн зүйл нь яагаад буруу байсныг ойлгох юм бол, мөн хийсэн үйлдлийнх нь талаар эргэцүүлж бодох боломж олговол хүүхдүүд алдаанаасаа суралцдаг. Энэ ангилалд дараах сахилга бат\хүмүүжлийн арга хэмжээнүүд багтана.

71 “Эцэг эхэд зориулсан аяны богц”, Боловсрол эвсэл, 2017 он <https://www.uih.mn/sudalгаа/s/397>

- a. Аман анхааруулга. Хүүхэдтэйгээ тайван ярилцаж, хийсэн үйлдэл нь яагаад буруу байсныг тайлбарлаж өгнө.
- b. Эргэцүүлэх цаг. Хүүхдийн нэг бол өрөөнөөс гаргаад эсвэл дуу чимээгүй газар 10 минут сууж юу хийснээ бодох хугацаа өгнө. Хугацаа дуусмагц хүүхэд өөрөө танд үйлдэл нь яагаад буруу байсан, цаашид тийм үйлдэл хэрхэн давтан хийхгүй байх тухай хэлнэ. Энэ аргыг хэрэглэхдээ эцэг эх хүүхдийг ямар нэг байдлаар гутаан доромжлохгүй, тууштай байх хэрэгтэй.
- c. Захидал бичүүлэх. Тухайн үйлдлийг яагаад хийсэн, тэр нь яагаад буруу байсан, ийм алдааг дахин гаргахгүй байхын тулд яах вэ гэдэг талаар хүүхдээрээ өөртөө хандсан захидал бичүүлэх. Зохистой бол захидалдаа уучлалт гуйлгах.
- d. Амаар уучлалт гуйлгах. Хүүхдээр бурууг нь хүлээлгэж, гомдоосон хүнээс нь уучлалт гуйлгана.
- e. Зөрчлийн хуудас. Хуудсан дээр хийсэн буруу үйлдлийг нь хүүхдээрээ бичүүлнэ. Бичсэн зүйлийг гэр бүлийн гишүүдийн өмнө уншиж, бүх хүний саналыг үндэслэлтэй нь сонсож ямар арга хэмжээ авахаа шийдвэрлэнэ.
- f. Сахилгын хайрцаг. Буруу үйлдэл хийсэн хүүхдийн нэрийг цаасан дээр бичээд гэрт байдаг сахилыг хайрцагт гэр бүлийн хэн нь ч байсан хийж болно. Долоо хоног бүрийн эцэст хайрцгийг шалгана. Хэрэв нэг хүүхдийн нэгтэй хуудас нэгээс олон байх юм бол тэр хүүхдэд торгууль ногдуулна.

2. Торгууль

Эргэн тойрондоо гэм хортой үйлдлийг давтан үйлдээд байгаа тохиолдолд хүүхдүүдэд үйлдэл нь үр дагавартай байдгийг мэдрүүлэхийн тулд торгууль ногдуулах хэрэгтэй байж магадгүй. Гэхдээ торгууль ногдуулаад зогсохгүй үр дагаврын тухай эргэцүүлэн бодоход нь хүүхдэд туслах хэрэгтэй. Энэ ангилалд багтах арга хэмжээнүүд:

- a. **Давуу эрхийг нь хязгаарлах.** Хүүхдийн хийх дуртай ямар нэгэн зүйлийг хориглох, тухайлбал телевиз үзэх, компьютер дээр суух эрхийг 7 хоногоор хасах. Гэхдээ хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хортой торгууль ногдуулж болохгүй.
- b. **Гэр, орчноо сайжруулах хөнгөн ажил хийлгэх.** Гэр, хашаа, хороогоо цэвэрлэх, багавтар талбайн шал угаах, ус авах, түлээ хагалах, нүүрс шуудайлах гэх мэт. Хийх ажил хийсэн үйлдэлтэй нь холбоотой байх хэрэгтэй. Мөн хүүхдэд маш их ичмээр, доромжлуулж байгаа гэж санагдахаар ажил байж болохгүй.
- c. **Саатуулах.** Тусгайлан тохирсон нэг газар гэр бүлийн гишүүд рүү харахгүйгээр сууж, хийсэн буруу үйлдлийнхээ тухай эргэцүүлнэ.
- d. **Сахилгын гэрээ байгуулах.** Хүүхдийн буруу үйлдлийг тайлбарласан, энэ алдаагаа засахын тулд хүүхдийн зүгээс авах алхмуудыг нь тоочсон нэг нүүр гэрээг хүүхэд, эцэг эхтэй байгуулна.
- e. **Хүүхэдтэй сахилгын яриа хийх.** Хүүхэдтэй уулзаж, үйлийнх нь талаар ярилцан, биеэ авч явах байдлыг нь засаж залруулах төлөвлөгөө хамтдаа гаргах.
- f. **Олон нийтийн үйлчилгээ.** Хүүхдээр нийгэмд ямар нэгэн тустай нэгэн ажлын хөнгөн хэлбэрийн ажил олон нийтийн үйлчилгээний ажил хийлгэхдээ зорилгыг сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй.

3. Залруулга

Гуравдагч талд хохирол учруулсан бол хүүхэд нийтийн өмнө залруулга хийх ёстой. Энэ нь бусдын өмнө буруугаа хүлээж, хариуцлага хүлээнэ гэсэн үг. Энэ ангилалд багтах арга хэмжээнүүд:

- a. **Нийтийн өмнө уучлалт гуйх.** Хүүхэд нийт гэр бүл, хамаатан садны өмнө буюу тухайн асуудалд холбогдсон хэсэг бүлэг хүмүүсийн өмнө буруугаа хүлээж уучлалт гуйна.
- b. **Орлуулах эсвэл засварлах.** Хэрэв хүүхэд санаандгүй эд зүйлс эвдэж хэмхэлсэн бол тэдгээрийг орлуулах эсвэл засварлахад хувь нэмэр оруулна. Жишээ нь хашаа засах эсвэл шинээр барих, мод хагалах, хана будах зэрэг ажилд оролцоно.

4. Эцсийн арга хэмжээ

Зан үйлийн өөрчлөлттэй хүүхэддээ тусалж мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйчид хандаарай.

ХҮҮХЭД БАЙГАА БҮХ ГАЗРЫГ АНХААР

Таны хүүхэд өдрийг хаана, хэнтэй өнгөрөөдөг вэ? Юу хийдэг вэ? Судалгаагаар та хүүхдээ анхааралтай сонсож, 15 минут ярилцахад өөрт тохиолдож байгаа бэрхшээл, зовнилоо уудалдаг гэдгийг тогтоожээ⁷². Иймээс хүүхэдтэй багаас нь илэн далангүй ярилцаж, санаа бодлыг нь нээлттэй хэлүүлж сургаарай. Өнөөдөр та хүүхдийнхээ байнга очдог газруудыг хамтдаа зурах эсвэл тэмдэглээрэй. Заавар:

1. Өмнөх өдөр ашигласан нэг өдрийн дэглэмээ ашиглаж болно. Эсвэл хааяа очдог газар байвал хэзээ, ямар үед очдог болохыг лавлаарай.
2. Сургууль, дотуур байр, тоглоомын талбай, интернэт кафе, дугуйлан, секц, давтлага, түүний цагийн хуваарийг харьцуулж хараарай.
3. Өдөр сургууль дээр, дотуур байранд ямар байдгийг ярилцаарай.
4. Таны хүүхэд болон бусад хүүхэд ямар байдаг, нэг нэгнээ дэмждэг эсвэл шоглодог эсэх, дарамт байдаг талаар заавал асуугаарай.
5. Хэрэв сургууль эсвэл дотуур байрандаа, нэг бол гэртээ ирэх замдаа хэцүү байдаг бол юунаас болж байгааг албадахгүй, шахахгүйгээр нягтлаарай.
6. Таны хүүхэд болон бусад хүүхдэд ямар эрсдэл, аюул тулгардаг талаар давхар асуугаарай.

Жишээлбэл:

- Намайг манай ангийнхан хичээл дээр асуугдах үеэр “Аялгатай ярьдаг” гэж шоглодог. Багшид асуугдаж дүн авмаар байсан ч гараа өргөж чаддаггүй.
- Цаснаар мотоцикльтэй хүн гуйж гэр лүүгээ явах эсвэл мотоциклиор явах хэцүү байдаг. Томчууд хүргээд өгье гээд айлгаад байдаг. Жаахан бензин өгчих гэж дарамтлах гээд байдаг.
- Дотуур байрны том хүүхдүүд дандаа өрөөнд орж ирж зоддог. Гэрээс эргэлт ирмэгц шууд хувааж авна гээд байдаг.
- Теннис, биллиард тоглох гэхээр том хүмүүс тэнд архи ууж байгаа харагддаг. Томчуудтай үед огт тоглож чаддаггүй.
- Дугуйландаа яваад ирэхэд их орой болдог. Харанхуй гудмаас хэн гараад ирэх бол гэж айдаг.
- Дотуур байрны жорлон орой ороход их аймаар. Байрнаас бараг 10 метр зайтай, огт гэрэлгүй, таг харанхуй, хүнгүй газар байрладаг тул би айдаг гэх мэт.

Ийнхүү хүүхэдтэйгээ ярилцсаны дараа юу хийх боломжтой, ямар тусламж хэрэгтэй байгааг асуугаарай. Сурагчдын аюулгүй байдлыг мэдрэх нь амжилттай хөгжих, суралцахад чухал нөлөөтэй. Та өөрөө, багштай, эсвэл бусадтай хамтран хийж болох зүйлсээ ярилцаарай. Хуваарь гаргаж хүүхдээ хүргэж өгөх, авах, эцэг эхчүүдтэй нийлэн сургуулийн орчноо сайжруулах, ээлжлэн эргүүлд гарах, хүүхдийн эрхийн байцаагчтай уулзах, багш, захирлаас зөвлөгөө авах зэргээр хийж болох боломжтой зүйлээ хийгээрэй.

ТА ХҮҮХДИЙНХЭЭ ХУВЬД ХЭН БЭ? ⁷³

Та бага насны хүүхдээрээ гэр бүлээ зуруулах, өсвөр насны хүүхэдтэйгээ цаг гарган ярилцах замаар тухайн хүүхдийнхээ хувьд ТА ХЭН БЭ гэдгээ лавлаж асуугаарай. Зургийн гол төвд анхаарал хандуулан гоё зурахыг хичээж байгаа болон хайнга байдлаар цаасны зах руу зурж байгаа зургаас та ямар байр суурь эзэлдгээ баримжаалж болно. Таны үгийг сонсохоос илүүтэйгээр гэр бүлийн бусад гишүүний буюу эмээ, өвөөгөө сонсож байвал та хүүхэдтэйгээ хамт цаг өнгөрөөхгүй байгаа ажээ.

⁷² Хүүхдээ нээцгээе: Хүүхэдтэйгээ ярилцах 6 арга (www.parenting.com)

⁷³ “Эцэг эхэд зориулсан аяны богц”, Боловсрол эвсэл, 2017 он <https://www.uih.mn/sudalgaa/s/397>

Хэрэв цаасны гол төвд байрлуулан гараа гарган зурж байгаа, өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ чөлөөтэй хуваалцаж байвал та сайн аав ээж гэж өөрийгөө үнэлж болно.

Та төрсөн цагаас нь эхлэн хамгийн багадаа 6 жил, зарим нь түүнээс олон жил хүүхэдтэйгээ хамт амьдарч, асарч хамгаалсан билээ. Тэгвэл сургуульд орсон үеэс та өөрийгөө хэрхэн харах вэ, танд ямар шинж байх ёстойг дор харуулав:

Хайрт: Ямар нэгэн хариу, тус нэхэхгүйгээр энхрийлж, дотночилж, хайрладаг хүн, мөн бусдыг хэрхэн хайрлахыг үлгэрлэдэг хүн

Халамжлагч: Сул дорой үед нь өргөж, өмгөөлж, халамжилдаг хүн, бусдад хэрхэн санаа тавихыг үлгэрлэдэг хүн

Хамгаалагч: Аюул осол, гэмтлээс сэргийлэн, бусдын халдлагаас хамгаалдаг хүн, мөн өөрийгөө хэрхэн хамгаалахад сургадаг хүн

Зөвлөгч: Тулгамдсан асуудлаа шийдэж чадахгүй үед зааж зөвлөдөг хүн

Туслагч: Чадахгүй зүйлээ хийх, гүйцэтгэхэд гар бие оролцож тусалдаг хүн

Дэмжигч: Ямар нэгэн зүйл санаачлан хийж гүйцэтгэхэд биеэрээ төдийгүй сэтгэлээрээ дэмждэг хүн

Найз: Харилцан нэг нэгнээ ойлгож, анд нөхөр мэт үздэг хүн

Хайрлах, халамжлах, хамгаалах, зөвлөх, туслах, дэмжих, найзлах үүргээ дутуу биелүүлж байгаа мэт санагдвал “ЯАГААД?” гэдэг асуултыг өөртөө болон гэрийнхэндээ тавиарай:

- Цаг зав бага;
- Ажил ихтэй;
- Гадуур амжуулах зүйл байна;
- Ядарч харьдаг;
- Аж ахуйдаа анхаарахгүй бол болохгүй;
- Тэр бүр ирж, очих боломжгүй;
- Жаахан байна;
- Үг ойлгохгүй гэсэн үгс үнэхээр шалтгаан мөн эсэхийг дахин эргэцүүлээрэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САЙН ТУРШЛАГА, ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. СХЖСХ-Г ТАСЛАН ЗОГСООХОД КИНО ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АРГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл ТВ9 телевизээс албан ёсны зөвшөөрөл авч “Залуу нас” (Better Days) киногоор ЕБС дээр хэлэлцүүлэг өрнүүлэв.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, залуучуудын дундах хүчирхийлэл аливаа улс орны эрүүл мэнд, нийгмийн халамж болон хууль, шүүхийн салбаруудад илүү зардал үүсгэж, бүтээмжийг бууруулан, үр ашгийг багасгахад хүргэдэг. Дээрлэхэлтийн шинжүүд:

- Дээрлэхэгчийн үйлдэл шудрага бус байдаг,
- Эрх мэдэл, хүч чадлын тэнцвэр алдагдсан үед гардаг,
- Хохирогч өөрийгөө хамгаалах чадвар мууг далимдуулдаг,
- Хэн нэгнийг зовоох, дарангуйлах хүслээс үүддэг,
- Байнга давтагддаг,
- Хохирогчид “доромжлогдсон” мэдрэмж төрүүлдэг

Үүнтэй холбогдуулан Боловсрол эвсэл гишүүн байгууллагууддаа кино хэлэлцүүлэг хийх аргачлалыг боловсруулан өгч, сонгогдсон ЕБС-ууд дээр “Кино хэлэлцүүлэг” зохион байгуулах замаар сургуультай холбоотой жсх-ээс урьдчилан сэргийлэх аянд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав. Кино хэлэлцүүлгийн аргын онцлог нь сургалтанд оролцогчдод **хүний эрхийн боловсрол олгоод зогсохгүй**, үе тэнгийн дарамт дээрлэхэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулахын тулд хүний эрхийн суурь ойлголт, зарчмыг заавал хэлж өгөх шаардлагатай болдог. Сургуулийн хамт олон (багш, удирдлагын баг, ажилчид, сурагчид, эцэг эх, асран хамгаалагчид) хүний эрх, хүүхдийн эрхийн мэдлэг ойлголтоо дээшлүүлээд зогсохгүй өөрсөдтэйгээ холбоотой асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцоход суралцдаг.

Ач холбогдол

Нийгмийн бүх түвшинд хүний эрх, хүүхдийн эрх, хамгааллын талаарх зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх, хүүхдийг бодитоор хамгаалах, хүүхдийн эрхийн зөрчил, жендэрт суурилсна хүчирхийллийн талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд кино хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой.

Кино хэлэлцүүлгийн онцлог

Кино үзүүлэх замаар хэлэлцүүлэг өрнүүлэх нь тухайн асуудлаар огт мэдээлэлгүй хүнд ч урьдчилсан мэдээлэл өгч, таамаглал дэвшүүлэх боломж олгодог тул нийтийн санаа бодлыг гаргахад илүү үр дүнтэй болдог. Мөн асуудлын хүрээг хэт өргөжүүлэхгүйгээр оролцогчдын санаа, бодлыг баяжуулахаас гадна үзэл бодлоо илэрхийлэхэд илүү хялбар болж, мэдээллийн үлдэц сайжрах, бодит үр нөлөөг нэмэгдүүлэх, цаашид тухайн хүний эрхийн асуудлыг үргэлжлүүлэн судлах эрмэлзэл нэмэгдэх боломжтой.

Кино бодит нөхцлийг харуулсан боломжит хувилбарыг үзүүлж түүндээ утга зохиол, уран зураг, дуу хөгжим, драмын урлагийг бүгдийг нь багтааж нийгмийн нөлөөлөл, хүмүүсийн төсөөлөл, бодит байдал, ирээдүйн боломж зэргээр олон өнцгийг харуулдаг учир хүмүүст илүү хүрч сонирхлыг нь татдаг.

Сонгож авсан киноны гол санаа, онцлог зүйл, найруулагчийн олон нийтэд илэрхийлэхийг хүссэн үзэл санаа зэргийг харгалзан түүгээр дамжуулан хэлэлцүүлэгт авч ашигласан тодорхой асуудал, онцлог нөхцөл, шигтгээ болгох санаа зэргийг киноны дүр болон агуулгаар дамжуулан хүргэдэг.

Ялангуяа эргэлзээтэй маргаантай асуудлын талаар киногоор дамжуулан тодорхой төсөөллийг үүсгэж тайлбарлан ярилцах, санал бодлоо солилцож, дүгнэлтэд хүрэх нь асуудлыг шийдвэрлэх арга зам, хэлбэрийг тодорхойлох тухайн процесст олон нийтийн санаа бодлыг тусгахад үр дүнтэй.

Уг кино нь БНХАУ-ын нэгэн ахлах сургуулийн төгсөх ангийн сурагч охин их сургуульд орох шалгалтанд бэлтгэхийн зэрэгцээ үе тэнгийн дарамт дээрэлхэлтэд өртөж улмаар өсвөр насны гудамжны дээрэмчний амьдралтай холилдож буй тухай. “Better Days” кино 2019 оны 10-р сарын 25-нд Хятадад, 2019 оны 11-р сарын 8-нд АНУ, Их Британи, Канадад гарсан. Уг кино нь 2011 онд гарсан бодит явдлаас сэдэвлэсэн. Нийт 2 цаг 9 минут үргэлжлэх уран сайхны кино юм. Мөн 93 дахь удаагийн Оскарын шагнал гардуулах ёслолын үеэр гадаад хэл дээрх шилдэг уран сайхны киногоор Хонг Конгоос төлөөлөн сонгогдсон нь том амжилт болсон.


Кино үзээд хэлэлцүүлэг өрнүүлэх нь:

- Тухайн сэдвийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах
- Хүрэхийг хүссэн зорилгодоо оролцогчдын олонхийг нэгтгэх
- Хандлага үзэл бодолд өөрчлөлт оруулах
- Цаашдын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжих бүлгийг үүсгэх боломжийг олгох зэрэг зорилготой.

2. ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТУСЛАМЖТАЙГААР ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО ШИНЭЧЛЭГДЭВ

“Хөөрхөн Зүрх” ТББ нь 2022 онд БЗД-ийн Ерөнхий боловсролын 21 дүгээр сургуулийн Хүүхэд хамгааллын бодлоготой нарийвчлан танилцаж зүйл заалтууд дээр саналаа өгч ажилласан. Хүүхэд хамгааллын бодлогыг сайжруулах үйл явцыг дурдвал:

- o Хүүхэд хамгааллын бодлогын үг хэллэг, боловсруулалтад сургуулийн оролцогч талуудыг оролцоог хангасан эсэх болон сурагчдад зохион байгуулсан сургалтын явцад ажиглагдсан асуудлуудтай (үе тэнгийнхний дарамт, сургуулийн насанд хүрэгчдээс сурагчид руу чиглэсэн дарамт) нийцсэн байгаа эсэхэд дүгнэлт хийн шаардлагатай зүйл заалт нэмэх, үг хэллэгийг засварлах зэргээр саналаа оруулсан.



- Хүүхэд хамгааллын багийн гишүүдэд зориулан “Хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг ажлын орчноос тусгаарлан өөр газар зохион байгуулсан. Сургалтаар хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд болон үр дагавруудын талаар ойлголтыг нэмэгдүүлэх замаар хүүхэд хамгаалал яагаад чухал талаар байрлан гишүүдийг үүрэг, оролцоог нэмэгдүүлэхийг зорьсон.
- Сургалт зохион байгуулсны дараа тус сургуулийн хүүхэд хамгааллын баг нийт гурван удаа хуралдан “Хүүхэд хамгааллын бодлого”-д оруулах саналуудаа нэгтгэн сайжруулсан.

- Тус сургуулийн хүүхэд хамгааллын багт асран хамгаалагч болон сурагчдын төлөөлөл байхгүй байсан учир нэмэлтээр тэдгээр төлөөллүүдийг оролцуулан дахин хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулан нэмэлт саналыг оруулсан.

Эдгээр бүх үйл явцыг “Хөөрхөн Зүрх” ТББ хариуцан зохион байгуулж тус сургуулийн хүүхэд хамгааллын багийн хүлээх үүрэг, оролцоог таниулан ажиллаж байна. Хүүхэд хамгааллын бодлогийг хараахан батлаагүй байгаа хэдий ч сурагчдын ээлжийн амралттай холбоотойгоор бүх багш нарт хүүхэд хамгааллын талаар сургалт зохион байгуулах үеэр бүгдэд нь “Хүүхэд хамгааллын бодлого”-ын зүйл, заалт бүрийг




нарийн тайлбарлан танилцуулсан. Ингэснээр сурагчидтай хамгийн ойр харилцаатай хүмүүс хүүхдийн эрх, хамгааллын талаар ойлголтоо нэмэгдүүлж, өдөр тутамдаа баримталж ажиллах эхлэх тавигдаж хүүхэд ээлтэй нийгэм-сэтгэл зүйн орчин бүрдэх боломжтой билээ.

3. “СҮҮДЭР ШИЙ” ЖҮЖГЭЭР ДАМЖУУЛАН СХЖСХ-Г ТАСЛАН ЗОГСООХ ЧИГЛЭЛЭЭР НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЭВ.



Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд Ерөнхий боловсролын “Тэмүүжин өрлөг” сургуулийн 7-12 дугаарын ангийн нийт 300 гаруй хүүхдүүдийн дунд “Сүүдэр ший” жүжгийг тус сургуулийн урлаг зааланд ажилттай зохион байгуулсан. Тус сургууль нь 500 гаруй сурагчтай. Нийт сурагчдын 80 гаруй хувь эрэгтэй сурагчид байдаг. Мөн 135 гаруй хүүхдийн ортой дотуур байртай. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд дийлэнх тул нийгмийн болон орчны ялгаатай байдлаас шалтгаалан сурагчид нэг нэгнийгээ ялгаварлан гадуурхах, шоглох, үе тэнгийн дарамт дээрэлхэлт үзүүлэх, сэтгэл

санааны дарамтад өртүүлэх тохиолдол цөөнгүй гардаг.

Иймээс үе тэнгийн дарамт дээрхлэлтээс урьдчилан сэргийлэх, аливаа хүчирхийлэл дарамтын талаарх мэдлэг ойлголтыг урлагаар дамжуулан өгөхдөө өөрсдийн оролцоог хангах зорилготойгоор сүүдэрший жүжгийг оролцооны аргад суурилан зохион байгуулсан.



Мөн энэхүү үйл ажиллагааны хүрээнд цагаан туузтаны хөдөлгөөнийг өрнүүлэн эрэгтэй сурагчдын хувьд **“Охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн талаар дуугүй өнгөрөхгүй, хэзээ ч хүчирхийллийг үйлдэхгүй”** гэсэн амлалт өгүүлж, гарын үсэг зуруулан цагаан тууз зүүх үйл ажиллагааг зохион байгууллаа.



Энэхүү үйл ажиллагааны үр дүнд:

- Үзэгч оролцогчид “Та хүчирхийллийн эсрэг юу хийж чадах вэ ?” гэсэн жүжгийн эерэг хувилбарт оруулж оролцооны аргаар хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтод хүрэв.
- Аливаа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, дарамтыг үйлдэхгүй байх, хүн бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч сурах, аливаа зөрчилдөөн гарахад зөвшилцдөг ур чадварыг нэмэгдүүлсэн.

Жендэрт суурилсан хүчирхийллийн мөн чанарын талаарх ойлголтыг өгч, түүнээс өөрсдийгөө хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өглөө.

4. СУРАГЧДЫН КЛУБУУДЭЭР ДАМЖУУЛАН ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ БОЛНО



Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг нь 2022 онд “Үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох” хөтөлбөрийн хүрээнд сурагчдын санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлж ажиллахыг гол чиглэл болгосон. Сургууль дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг сурагчдын клубүүдтэй хамтарч үе тэнгийнхэн өөр хоорондоо нөлөөлөх замаар үйл ажиллагааг өрнүүлсэн байна. Нөлөөллийн үйл ажиллагаанд:

- Сургуулийн өөрөө удирдах зөвлөл
- Улаан загалмай
- Сэтгүүлч
- Эко
- Охидын зөвлөл
- Хөвгүүд зөвлөл
- Сэтгэл зүйч
- Өсвөрийн сэргийлэгч
- Өөрчлөлтийн дуу хоолой

Сурагчид санаачилгаа гаргаж буй учир түүндээ урамшин клубын үйл ажиллагаа идэвхжиж клубын гишүүд илүү чадавхжих боломжийг олгосон гэж харж байна.

“Аз жаргалтай тархи өдөрлөг”-ийг 7 хоногийн хугацаанд өртөөчилсөн арга зүйгээр зохион байгуулахдаа клуб бүр дээрэлхэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэг, мэдээллийг үе тэнгийнхэн хоорондоо хуваалцаж, хүргэсэн юм.

Өдөрлөгийн үеэр “Урмын мод”-ыг ажиллуулж, сургуулийн нийт 5-12 дугаар ангийн нийт 2210 хүүхэд бусдад хандсан сайн сайхан урмын үгээр модоо чимсэн юм. Дээрэлхэлттэй холбоотой сэтгэгдлээр “Сэтгэлийн мод”-ыг сурагчид өөрсдөө санаачилж ургуулсан. Түүнчлэн клубын сурагчдаар дамжуулж “Үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл үйлдэхгүй!” цуврал мессежтэй постерийг нийгмийн сүлжээнд нийтэлсэн. Цаашлаад сургууль дээр үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өөрөө удирдах зөвлөлийн дэргэдэх клубүүдийн тогтвортой хамтын ажиллагаа бэхэжсэн юм. Аяны хүрээнд зохион байгуулсан сургалт нь 50 анги удирдсан багш, ажилчид, 50 эцэг эхийн төлөөлөлд хүрсэн.

Сургуулийн эрх зүйн баримт бичигт “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх” журмыг сайжруулан баталж, сургуулийн бүх оролцогч талуудад энэ талаар мэдээлэл өгчээ.



ХАВСРАЛТ 1

ДЭЭРЭЛХЭЛТИЙГ ТАНЬЖ МЭДЬЕ

ХЭРВЭЭ ТАНЫ ХҮҮХЭД ДЭЭРЭЛХҮҮЛЖ БАЙВАЛ ДАРААХ ШИНЖ ТЭМДГҮҮД ИЛЭРНЭ. ТА АНХААРЧ БАЙГААРАЙ.

Сургуульдаа явах сонирхол буурах эсвэл хичээлээ таслах	Дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэл байгаа орчноос ямар ч хүн зугтдаг.
Сургууль руугаа явдаг замын маршрут нь өөрчлөгдөх	Тухайлбал, хүүхэд тань сургууль руугаа хойд зүгт явдаг байсан бол гэнэт өөр жимээр явж байгаа бол магадгүй өөрийн жим дээр нь хүүхдийг зоддог, гадуур хувцсыг нь булаадаг, хоолны мөнгө нэхдэг хүүхдүүд жим дээр отоод зогсдог болсон байж болзошгүйг анзаараарай.
Сурлагын амжилт буурах	Дээрэлхэлтэнд хэрхэн өртөхгүй байх вэ? гэсэн айдастай үед хичээлдээ төвлөрч чадахгүй, хичээлийн дараа юу тохиолдох бол гэсэн айдас, болгоомжлолтой байх үед, эсвэл өмнөх дээрэлхэлтийн цочролоос гарч амжаагүй байгаа үедээ хичээлдээ бүрэн анхаарч чадахгүй. Дээрэлхэлтэд байнга өртөж байгаа хохирогч нь өөрийн цаг, эрч хүчээ хичээлээ хийе гэхээсээ илүү өшөө авахад илүү төвлөрдөг.
Гэр бүлийн болон сургуулийн үйл ажиллагаанд оролцохоос цааргалах ганцаараа үлдэхийг хүсэх	Та ч мөн ганцаардсан, ичгэвтэр байдалд орсон, айсан, үедээ ганцаараа байх, өрөөндөө өөрийгөө цоожлоод, хэнтэй ч ярихыг хүсэхгүй, орондоо ороод уйлдаг шүү дээ.
Хичээлээ тараад ирэхдээ өлссөн байх	Хоолны мөнгөө хэн нэгэнд булаалгасан эсвэл сургууль дээрээ огт юм идээгүй гэсэн үг.
Байнга мөнгө нэхэх	Халаасны мөнгөө юунд зарцуулсан талаараа тодорхой мэдээлэл өгөхгүй байх, худлаа хэлэх
Гэртээ ирэнгүүтээ жорлон руу гүйх	Дээрэлхэлт хамгийн их үйлдэгддэг цэгийн эхний 4-т сургуулийн жорлон байдаг тиймээс хүүхдүүд шээсээ барих тохиолдол их байдаг. Улмаар шээс бөөрний замын эмгэгт хүрч болзошгүй.
Сөрөг мэдрэмж илэрхийлэх	Утасны дуудлага, зурвас хүлээн авсны дараа, эсвэл сошиал сүлжээгээр аялсныхаа дараа гунигтай, ууртай, айдастай гэх мэт мэдрэмж илэрхийлэх.
Урьд өмнө нь гаргаж байгаагүй, ааш авир гаргах	Хичээлээ таслах, худлаа хэлэх, хулгай хийх, дүр үзүүлэх
Бусдыг доромжилж, дорд үг хэллэгээр хэлэх	Үе тэнгийнхнийхээ талаар ярихдаа хэт доромжилсон, дорд үзсэн үг хэллэг ашиглаж ярих
Ярилцах дургүй болох	Найз нарынхаа тухай эсвэл сургууль дээр юу болж өнгөрсөн талаар ярихаа болих
Хувцас хунар нь өөр болох	Хувцас нь салбарсан, урагдсан, эсвэл хувцсаа алдсан байх
Гэмтэх, бэртэх нь ихсэх	Бие махбодын гэмтлээ сайн тайлбарлаж хэлж чадахгүй байх
Дэглэм алдагдах	Гэдэс эвгүйрхэх, толгой өвдөх зэрэг зовиурууд байнга хэлэх, шөнө нойрондоо муу болох эсвэл хэт их унтах

Сургуулийн ажилтнууд эцэг эх, асран хамгаалагчтай дээрэлхэлтийн асуудлын талаар ярилцвал тэдний зүгээс ирэх сөрөг хариу үйлдлээс маш болгоомжилдог. Тиймээс нээлттэй, эерэг уур амьсгалтай сургуульд хэн бүхэн энэ асуудлын талаар ил тод, нээлттэй ярилцаж байх чухал. Иймд сургууль дээрэлхэлтийн талаар нээлттэй ил тод ярьж эхэлбэл та “энэ нь хүүхдэд тань эерэг, сайн өөрчлөлт” гэж хүлээн авч хамтран ажиллах хэрэгтэй юм.

ТАНЫ ХҮҮХЭД ДЭЭРЭЛХЭЛТЭД ӨРТСӨН БОЛ ТА ЮУ ХИЙЖ БОЛОХ, БОЛОХГҮЙ ВЭ?

Таны хийж болох үйлдлүүд	Таны хийж болохгүй үйлдлүүд
1. Эхлээд хүүхдээ сонс. Хүүхдэдээ итгэ. Хажууд нь үргэлж хамт байна гэдгээ ойлгуулаарай. Юу болсон бэ? гэж асуугаад хүүхдээ чимээгүй сонс. Хүүхэд болсон явдлын талаар ярьж дууссаны дараа Хэн, Хаана, Хэзээ гэх мэт асуултыг асууж баримтыг цуглуул. Хэрэв шууд эдгээр асуултууд руу үсэрвэл зарим чухал мэдээллийг орхигдуулах магадлалтай. 2. Чиний буруу биш. Хэн ч дээрэлхүүлэх ёсгүй. Та хүүхдээ “Хэрвээ ингэсэн бол...” Хэрвээ тэгээгүйсэн бол... гэх мэтээр бүү шүү. Таны хүүхдэд таны тусламж л хэрэгтэй. Дээрэлхсэн хүүхэд таны хүүхдийг: “хүндлэл хүлээх ямар ч үнэ цэнгүй нэгэн; өөрийгөө хамгаалж чадахгүй; сургууль дээр чамд юу ч тохиолдсон чи яаж ч чадахгүй; бүгд чамд дургүй” гэх хандлагаар хандаж дээрэлхсэн шүү гэдгийг санаарай. 3. Хариу арга хэмжээ “Чамд яаж тусалж болох вэ? Чамд туслахад бэлэн байна, итгэл найдвараа бүү алд, Чи ганцаархнаа асуудлыг шийдэх гэсний хэрэггүй, хамтдаа үр дүнд хүрэх төлөвлөгөө боловсруулья” гэх мэтчилэн хүүхэдтэйгээ дотно ярилцаарай. Дээрэлхэлтийн эсрэг тууштай сөрөн тэмцэх, аюулаас зайлсхийх арга замыг олоход нь та тусалж чадна. Ингэснээр та хүүхдэдээ хүчээ эргүүлэн олж авах, өөрт байгаа авьяас чадвараа хөгжүүлэхэд нь тусалж байна гэсэн үг. Та хүүхэдтэйгээ ямар хариу арга хэмжээ авч болох талаар ярилцаж, сонголтуудад нь анализ хийж, нөхцөл байдлыг бүр дордуулах эсвэл аюултай байдалд оруулах, хүчирхийллийг өдөөх арга хэмжээг нь ялган таниулж хүүхэдтэйгээ ярилцах хэрэгтэй. Улмаар таны хүүхэд бүтээлч байдлаар тууштай дээрэлхэлтийн эсрэг тэмцэх боломжтой. 4. Дээрэлхэлтийн талаар сургуулийн ажилтнуудад мэдээллээрэй. Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн талаар таны хүүхдийн багш мэдэх хэрэгтэй. Та тодорхой баримтуудыг мэдээллээрэй. Тухайлбал сар өдөр, цаг, хаана, хэн гэдэг хэдэн хүүхэд оролцсон, таны хүүхэд хэрхэн хохирсон талаар мэдээлэл өгөөрэй. Мэдээлэл өгсний дараа таны хүүхдийг хамгаалах тал дээр ажиллаж байгаа эсэхийг, өөр хэн нэгний хүүхэд дээрэлхэлтэд өртөж байгаа эсэхийг, дээрэлхэгч хүүхдэд шийтгэл оногдуулахгүйгээр хүмүүжлийн эерэг арга хэмжээ авч байгаа эсэхийг араас нь нягталж хяналт тавиарай. Харин том хүүхдүүдийн хувьд эцэг эх асран хамгаалагчаа сургууль дээр дээрэлхэлийн асуудлаар очуулах дургүй: Учир нь байдлыг бүүр дордуулна гэсэн итгэл үнэмшилтэй байдаг.	1. Дээрэлхэлт бол хүн бүрийн туулдаг байдаг л зүйл дээрэлхэгч хүүхдээс хол бай гэж зөвлөж огтхон ч болохгүй. Дээрэлхэлт бол бие махбод болон сэтгэл зүйн хувьд өвдөлт өгдөг зүйл. Энэ бол зөрчил биш, тоглоом төдий биш, дээрэлхэлт бол эртнээс төлөвлөсөн, зорилготой, онилсон үйлдэл. Дээрэлхэж байгаа хүүхдээс хол бай гэж та өөрийн хүүхдэдээ хэлснээр чи ганцаараа энэ асуудлыг шийд чамд туслах хүн алга гэж хэлж байгаатай ижил. 2. Хүүхдэдээ асуудлыг нь шийдэж өгөх гэж бүү яараарай. Таны хүүхэд бие махбодын хувьд хүнд гэмтэл аваагүй бол та нөхцөл байдлыг хяналтандаа оруулах гэж яаран зүтгэснээр дээрэлхэгч хүүхдэд “таны хүүхэд бол дээрэлхэлтийн бай мөн” гэсэн мессеж өгч байгаа гэсэн үг. Мөн үе тэнгийнхэн нь дээрэлхэгч хүүхдийг өмөөрч, таны хүүхэд бол ноомой нэгэн, ээжийн эрх хүүхэд хэмээн буруушаах болно. Харин та хүүхдэдээ өөрийгөө хамгаалах, ухаалгаар дээрэлхэлтийн тохиолдлыг давж гарах аргуудыг заа. Дээрэлхэгч хүүхдэд ч мөн хэрхэн бусдыг дээрэлхэхгүй байхыг томчууд зааж сургах хэрэгтэй. 3. Дээрэлхүү хүүхдээс хол бай гэж хүүхдэдээ бүү хэлээрэй. Ингэж хэлснээр та хүүхдэдээ зугтаад бай, нуугдаад бай, энэ айдсаа тээгээд яваад бай гэсэн мессэжийг өгч байна гэсэн үг. Дээрэлхэл үйлдэгч хүүхэд айдастай байгаа нэгнийг андахгүй мэднэ. Аюулаас нэн даруй зайлсхийхийн тулд дээрэлхэлээс зугтаж болно. Гэхдээ энэ бол дээрэлхэлийг шийдэх урт хугацааны шийдэл биш. 4. Эргүүлээд өөрийг нь дээрэлх гэж хүүхдэдээ бүү хэлээрэй. Яагаад гэвэл дээрэлхэгч хүүхэд хүчний хувьд таны хүүхдээс илүү гэдгээ мэдрээд таны хүүхдийг сонгон дээрэлхэж байгаа. Хэрвээ таны хүүхэд эргүүлж дээрэлхэх гэж байгаад хохирвол дараа түүнийг илүү ихээр хохироох дээрэлхэл хүлээнэ. Өөрийгөө хамгаал гэхдээ өөртөө итгэлтэйгээр ухаалгаар хамгаал. Эргүүлж харилцан дээрэлхдэг хүүхдээс илүү өөрийгөө ухаалгаар итгэлтэйгээр хамгаалдаг хүүхэд илүү амжилттайгаар дээрэлхэлийг сөрж зогсоодог. 5. Дээрэлхэгч хүүхэдтэй мөн эцэг эх, асран хамгаалагчтай ганцаараа уулзаж болохгүй. Дээрэлхэгч хүүхэд магадгүй эцэг эхээсээ сурсан байж болзошгүй. Магадгүй өөрийгөө өмөөрч, хохирогчийг буруутгана. Гэр бүлийн гишүүд нь мөн хүүхдээ өмөөрнө. Иймд дээрэлхэгч хүүхэдтэй уулзахдаа мөн эцэг эх, асран хамгаалагчтай нь уулзахдаа заавал дэргэдээ дээрэлхэлтийн асуудал хариуцсан сургуулийн ажилтантай хамт сууж уулзаарай.

Хэрвээ таны хүүхэд бусдыг дээрэлхэлдэг бол та юу хийх ёстой вэ?

- Нэн даруй хүүхэд хүмүүжлийн эерэг аргатай эсэхээ нягтлаарай.
- Түүнд “Сайн үйлс хийх” боломж олгоорой.
- Бусдын оронд өөрийгөө тавьж, бусдыг ойлгон энэрэх сэтгэлийг төлөвшүүл.
- Найз нөхөрлөлийн чадвар заа - тууштай, хүндэтгэлтэй, энх тайванч байдлаар бусадтай нөхөрлөхийг үлгэрлэж, заагаарай.
- Хүүхдийнхээ телевиз, сошиал медиагаар юу үзэж байгааг, ямар видео тоглоом тоглож байгааг, компьютер, гар утсан дээрээ юу хийж, хадгалж авч байгааг, ямар дуу хөгжим сонсож байгааг анхааралтай ажиглаарай. Гэхдээ шууд хувийн утас, сошиал хаягуудыг хүчээр шалгаж, халдаж огтхон ч болохгүй^ Хувийн орон зайг үлдээгээрэй.
- Илүү бүтээлч байдал шаардах, өөрт нь баяр хөөр бэлэглэх, эрч хүч мэдрүүлэх арга хэмжээнд хүүхдээ идэвхтэй оролцуулаарай.
- Дээрэлхүү нэгнээс дээрэлхэлтээс бусдыг авран хамгаалдаг нэгэн болж өөрчлөгдөхөд нь та туслаарай. Бас дэмжээрэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



БОЛОВСРОЛ,
ШИЖЛЭХ УХААН,
ЯМ



МОНГОЛЫН ГАЗРЫН ХЭРЭЖИЛГЭЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



ДЭЛХИЙН НИЙТИЙН
УДИРДАМЖ

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл нь сургууль болон түүний эргэн тойронд тохиолдох, жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголтын үр дүнд үйлдэгдсэн эрх мэдлийн тэгш бус динамикаар хэрэгжсэн бэлгийн, бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийллийн үйлдэл, заналхийллийг хэлнэ.


Охид ихэвчлэн сэтгэлзүйн болон цахим дээрэлхэлт, бэлгийн дарамт хүчирхийлэлд өртдөг.

Хөвгүүд бие махбодын хүчирхийлэл болон биемахбод, сэтгэлзүйн шийтгэлд илүүтэй өртдөг байна.




СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ нь жендэрийн ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ бөгөөд хүүхдийн үндсэн эрхийн зөрчил юм.

ХААНА ҮЙЛДЭГДДЭГ ВЭ?



СУРАГЧИД БОЛОН СУРГУУЛИЙН ХАМТ ОЛОН, АЖИЛТНУУД
СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН
ХОХИРОГЧ ЭСВЭЛ ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ БАЙЖ БОЛНО.

Эх сурвалж: UN, UNGEI
Орчуулга: "ХӨӨРХӨН ЗҮРХ" ТББ





БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭЖҮҮЛЭГЧИ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



МАНЛАЙЛАЛ: Хууль, эрхзүй, дүрэм журам болон боловсролын реформ

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх үр нөлөөтэй хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Засгийн Газар манлайлал үзүүлж, амлалт өгөх хэрэгтэй.



Хамгаалсан чиглэлтэй хууль,
бодлого боловсруулж,
хэрэгжүүлэх

Боловсрол болон хүүхэд
хамгааллын систем хамтын
ажиллагаа, холбоогоо
бэхжүүлэх

Хүчирхийллийг жендерийн линзээр
нягтлан харж, шалтгааныг нь
тодруулан, арга хэмжээ авах
иж бүрэн алхмыг
систем даяар нэвтрүүлэх



Аюулгүй, дэмжлэгийн тогтолцоотой сургуулийн орчинг бий болгох

Сургуулиудыг аюулгүй, хүүхдэд ээлтэй, суралцахад таатай уур амьсгалтай болгохын тулд цогц арга хэмжээг авах шаардлагатай.



ТАВ ТУХТАЙ ОРЧИН

Үнэ цэн, хүндлэл
мэдэрдэг орон зай

БИЕ МАХБОДЫН ХУВЬД АЮУЛГҮЙ ОРЧИН

Гэрэлтүүлгийг бүрэн шийдсэн
орон зай ба тусдаа цоожтой
бие засах өрөө

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Сурагч, багш болон
сургуулийн ажилтнуудыг
хамгаалах

Сургуулийн эргэн тойрны аюулгүй болон аюултай бүсийн зургийг гаргаж, халуун цэгүүдийг тодорхой болгон тэмдэглэхэд сурагчдыг оролцуулах ёстой.

Сургуулийн удирдлага, багш нар сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчдад ил тод, нээлттэй мэдэгдэх ёстой.

Эх сурвалж: UN, UNGEI
Орчуулга: "ХӨӨРХӨН ЗҮРХ" ТББ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР





УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ: Сургалтын хөтөлбөр багшлахуй болон сурахуй

Зохистой сургалтын хөтөлбөр болон сургалтын арга барил нь сургуультай холбоотой жендэрийн хүчирхийллээс сэргийлэх гол түлхүүр юм.

Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд баримтлах хандлага

БАГШ НАРЫГ СУРГАЖ ДЭМЖИХ



Жендэрийн эрх тэгш байдал

АЮУЛГҮЙ ОРОН ЗАЙ БА ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА







ХАРИУ ҮЙЛДЭЛ: СУРГУУЛИЙН ГАДНА БОЛОН ДОТОРХ ОРЧИН

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэхэд аюулгүй, нээлттэй, хувь хүний нууцыг бүрэн хадгалсан журам боловсруулаарай.

Мэдээлэх

Мэдээлэх сувгууд



Тусламжийн утас



Онлайн мэдээлэл хүлээн авах



Нэрээ нууцлан мэдээлэл өгөх хайрцаг



Мэдээлэл хүлээж авахаар хариуцсан багш

Зөвлөх ба дэмжих



СХЖСХ-ийн хохирогч, гэрч болон хүчирхийлэл үйлдэгч аль алинд аюулгүй, хүүхдэд тохирсон, хувь хүний нууцыг хамгаалсан байдлаар зөвлөгөө өгөх

Дараагийн арга хэмжээг авах



Эрүүл мэндийн үйлчилгээ



Хууль хэрэгжүүлэх байгууллага

Эх сурвалж: UN, UNGEI
Орчуулга: "ХӨӨРХӨН ЗҮРХ" ТББ



НОТЛОХ БАРИМТ: Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийг хянах, тогтмол үнэлгээ хийх

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг авах үндэсний арга хэмжээг боловсруулахдаа судалгаа, дата мэдээлэл болон тасралтгүй үргэлжлэх хяналтын үйл явцад суурилах хэрэгтэй.

- ✓ Хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх
- ✓ Үйл явцыг хэмжих шалгуур үзүүлэлт гаргах
- ✓ Үндэсний дата, мэдээлэл цуглуулах систем
- ✓ Боловсролын менежментийн мэдээллийн систем
- ✓ Судалгаа/ Нөхцөл байдлын анализ
- ✓ Үнэлгээ
- ✓ Арга зүйн, Ёс зүйн болон Аюулгүй байдалд анхаарч ач холбогдол өгөх



Эх сурвалж: UN, UNGEI
Орчуулга: "ХӨӨРХӨН ЗҮРХ" ТББ



“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

